

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ЗАХИАЛАГЧ:

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ГҮЙЦЭТГЭГЧ:

Б.Лхамсүрэн

Хуульч, судлаач

Б.Өлзийбаяр

Хуульч, судлаач

Н.Нямдорж

Эдийн засагч, судлаач

Нэмэлт, өөрчлөлт оруулсан:

“Богд судалгааны хүрэээн” НҮТББ

Д.Амгалан

Хуульч, судлаач

Ү.Амарбат

Хуульч, судлаач

Э.Аззаяа

Эрх зүйч, судлаач

Улаанбаатар хот

2021

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА	1
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ТОВЧ ТОЙМ.....	3
НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	9
1.1. Асуудлын хамрах хүрээг тодорхойлсон байдал	9
1.2 Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон байдал.....	12
1.3 Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл.....	13
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН БАЙДАЛ.....	18
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	19
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ.....	22
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ.....	25
ЗУРГАА. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА .	26
6.1 ЯПОН УЛС (Хүнд үйлдвэрийн хууль тогтоомжийн судалгаа).....	27
6.2 ӨМНӨД СОЛОНГОС (Хүнд үйлдвэрийн хууль тогтоомжийн судалгаа). 31	
6.3 БНХАУ (Хүнд үйлдвэрийн хууль тогтоомжийн судалгаа)	41
6.4 КАЗАХСТАН УЛС	46
6.5. ЧИЛИ УЛС	51
6.6 ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС	53
6.7 АВСТРАЛИ УЛС	54
6.8 ГЕРМАН УЛС	55
6.7 ЭНЭТХЭГ УЛС	56
ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	58
ХАВСРАЛТ 1. ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЖАГСААЛТ	80

ХАВСРАЛТ 2. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ	95
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	101

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн Газар
УУХҮЯ	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ҮСГ	Үндэсний статистикийн Газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын сан
БОНБҮ	Байгаль Орчны Нөлөөлөх Байдлын Үнэлгээ
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ЭЗБТҮАСА	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
ДЦС	Дулааны Цахилгаан Станц
ДХБ	Дэлхийх Худалдааны Байгууллага
ЖДҮ	Жижиг, Дунд Үйлдвэрлэл
НӨАТ	Нэмүү Өртгийн албан Татвар
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн банк

ТОВЧ ТОЙМ

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох шийдвэрүүдийг гаргаж ирсэн боловч бодит ажил болсон нь цөөн байна.

2015 онд батлагдсан Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиар өрсөлдөх чадвартай, үнэ цэнэ шингэсэн, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаатай, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг боловч УИХ-аас энэ хуулийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болгосон.

Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлд төрийн бодлого, хөтөлбөрүүд хангалттай батлагдсан хэдий ч хүнд үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нэр, төрөл харьцангуй цөөн, технологийн агууламж бага, голдуу хагас боловсруулсан хэлбэрээр экспортод гарч байна.

Ган туйван, ган бөмбөлөг, катодын зэс, зэс утас, цемент, машин үйлдвэрлэл, газрын тосны бүтээгдэхүүн, металл хийцийн зарим үйлдвэрүүд бэхжиж, үйл ажиллагаа тогтворжих шинжтэй байгаа боловч ихэнх үйлдвэрүүдэд нийтлэг шинжтэй бэрхшээл тулгарч байна.

Тухайлбал, эргэлтийн хөрөнгийн дутагдал, техник, технологийн хоцрогдол, хүний нөөцийн дутагдал, эрчим хүч, тээвэр логистикийн нэгдсэн дэд бүтэц, сүлжээнд холбогдоогүй байдал зэрэг хүчин зүйлс нь дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн импортын бараатай өрсөлдөх, үйлдвэрлэл хөгжих боломж нөхцөлийг хязгаарлаж байна.

Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг, салбарын хөгжлийн түвшин, металл ба металл бус зах зээлийн эрэлт хэрэгцээ, эрсдэл, олон нийтийн хандлага, байгаль орчин ба уур амьсгалын өөрчлөлт зэрэг дотоод ба гадаад хүчин зүйлээс хамааран орон зай, цаг хугацааны хувьд хуулийн хүрээнд ялгаатай бодлого, зохицуулалт шаардлагатай байна.


Дээрх хүнд үйлдвэр хөгжүүлэхэд тулгарч байгаа асуудлууд нь тус салбарт төрийн дэмжлэг үгүйлэгдэж буйн тод илрэл юм.

Тандан судалгааны хүрээнд олон улсын хүнд үйлдвэрийн салбарын эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд 20 дугаар зууны эхэнд хөгжлийн буурай ангилалд байсан цөөнгүй орнууд хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх төрөлжсөн хууль, тогтоомж баталж, тухайн салбарыг дэмжих болон хамгаалах зохицуулалтыг амжилттай хэрэгжүүлснээр аж үйлдвэрийн хувьд өндөр хөгжсөн орон болсон байдаг.

Тухайлбал, дэлхийн II дугаар дайны дараа Япон, Өмнөд Солонгос, Тайван зэрэг өнөө цагийн “Азийн Бар” орнууд хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх төрөлжсөн хуулиуд баталсан бөгөөд эдгээр орны төр, засгийн зүгээс хөгжлийн “Хүчтэй түлхэх загвар”-ыг хэрэгжүүлж, хэд хэдэн томоохон секторуудад зохицуулалттай, чиглэсэн хөрөнгө оруулалт хийж, аж үйлдвэрийн салбарт их үсрэлт хийсэн юм.¹

¹ Industrial Development in East Asia.2009. by K. Ali Akkemik

Зураг 1. Хүнд үйлдвэрийн салбарт тулгарч байсан асуудлууд



Хүнд үйлдвэр, түүний дотор төмөрлөг, гангийн үйлдвэрлэл, хөлөг онгоц, автомашин болон электроникийн үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд хөрөнгө хүч, төрийн бодлого, зохицуулалтыг төвлөрүүлж тууштай ажилласны үр дүнд аж үйлдвэрийн тэргүүлэх орнууд болсон байна. Тухайлбал,


Аж үйлдвэрлэлийн тэргүүлэгч орнуудын нэг БНСУ-с (Өмнөд Солонгос) нь 1950-иад оны төгсгөл үе гэхэд урт хугацааны гадны колоничлол, түүний дараах хоёр Солонгосын дайны хөлд нэрвэгдэж, Ази тивийн хамгийн ядуу орон болсон байв. Дайны дараа Өмнөд Солонгосын төр, засгаас эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн шат дараалсан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгын хүрээнд машин байгууламж, усан онгоц, хар төмөрлөг, электроник, нефть-химийн үйлдвэрлэл, өнгөт төмөрлөг боловсруулалт гэсэн 6 чиглэлийг стратегийн салбараар сонгосон байна.

Ингээд хүнд үйлдвэрийг дэмжих дараах хуулиудыг баталжээ.

- *Суурь машин үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1967)*
- *Усан онгоц үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1967)*
- *Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1969)*
- *Электроникийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1969)*
- *Нефть, химийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1970)*
- *Өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1971)*

Дээрх хүнд үйлдвэрийн салбарыг дэмжсэн 6 хуулиар экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр засгаас онцгой анхаарч хөнгөлөлттэй зээл олгох, үйлдвэрлэлийн зориулалттай импортын бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг гаалийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх зэрэг дэмжлэг үзүүлэх зохицуулалтууд нийтлэг тусгагдсан байна.


Зураг 2. Төрөлжсөн хуулиар зохицуулсан асуудал



Ийнхүү хүнд үйлдвэрийн салбар тус бүрээр хууль баталж, тухайн салбарыг дэмжих бодлого хэрэгжүүлсний үр дүнд тус орны хүнд үйлдвэрийн салбар 1970 онд экспортын нийт бүтээгдэхүүний 7.4 байсан бол 1980 он гэхэд 19.2 хувь хүрсэн бөгөөд улмаар тасралтгүй өсөж 2000 онд 80 хувь давсан байна².

Зураг 3. Хүнд үйлдвэрийн салбарын экспортод эзлэх хувь

² Industrial upgrading of Korea. Cheonsik Woo. 2000 . KDI



Ийнхүү аж үйлдвэр хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэнээр тус улс нь харьцангуй богино хугацаанд заяагдмал баялагт тулгуурласан эдийн засгаас үр ашиг-аж үйлдвэрт тулгуурласан эдийн засагт шилжиж, улмаар ололт амжилтаа бататган инноваци-шинэ санаачилгад тулгуурласан аж үйлдвэрийн хөгжлийн шатанд хүрчээ. Өмнөд Солонгосын аж үйлдвэрийн хөгжлийн энэхүү амжилтыг тоон үзүүлэлтээр илэрхийлбэл нэг хүнд ногдох ДНБ нь 1994 онд 10,000\$, 2006 онд 20,000\$, 2018 онд 30,000\$ тус тус давсан байна.

Иймээс Монгол Улс хүнд үйлдвэрийн эрчимтэй хөгжлийг хангахын тулд эрх зүйн таатай орчин бүрдүүлэх үүднээс тус салбарыг хөгжүүлэх угтвар нөхцөлийг хангасан хүнд үйлдвэрийн суурь хуулийг батлан хэрэгжүүлж, цаашид төрөлжсөн хуулийг бий болгох таатай орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хүнд үйлдвэрийн салбарыг дэмжсэн хууль эрхзүйн орчинг бүрдүүлснээр Монгол Улсын эдийн засаг, нийгэмд дараах үр нөлөөг үзүүлнэ гэж тооцож байна. Үүнд:

- ✓ Хүнд үйлдвэрийн тухай нэр томъёоны ойлголт тодорхойлогдож, салбарын аж ахуй нэгж нэгдсэн зохион байгуулалтад орсноор бүтээгдэхүүний гарц, үйлдвэрлэл нэмэгдэж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сайжирна.
- ✓ Манай улсад нэн тэргүүнд хөгжүүлэх шаардлагатай хүнд үйлдвэрийн салбарыг томъёолж, тэргүүлэх салбарыг хөгжүүлэх төрийн дэмжлэг бүрдэнэ.
- ✓ Эхний ээлжид газрын тос, металлургийн салбарыг дэмжин хөгжүүлснээр дотоодын эрэлт хэрэгцээг хангаж 1.5-2.0 тэрбум ам.долларын гадаад урсгалыг дотооддоо авч үлдсэнээр гадаад худалдааны баланс эерэг гарч, валютын нөөц нэмэгдэнэ.
- ✓ Засгийн газраас хөгжүүлэхээр зорьж буй Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн байгуулах Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл, хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл, Үнэт метал цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах төсөл, Газрын тосны үйлдвэр байгуулах төсөл хэрэгжих эрх зүйн орчин тус тус бүрдэнэ.
- ✓ Дээрх хүнд үйлдвэрийн төслүүдөөс зөвхөн Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн байгуулах Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл,

технологийн парк байгуулах төсөл хэрэгжсэнээр 1825.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэх бөгөөд энэхүү төслийн хүрээнд 130.5 мян тонн катодын зэс, 12.0 мян.тонн хүхрийн хүчил, 14.9 мян.тонн тэсрэх бодис, 7.0 мян тонн гаруй цутгамал, металл хийц, механик боловсруулалттай бүтээгдэхүүн болон бусад дагалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1065 шууд ажлын байр бий болно. Түүнчлэн хар төмөрлөгийг хөгжүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэр барих, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих, үнэт метал цэвэршүүлэх үйлдвэрийн төслүүдийн хувьд 1.5 сая тонн автобензин, түлш, 257.2 мян.тонн катодын зэс, 630.0 мян.тонн ангижруулсан төмөр, ган бүтээгдэхүүн, 150.0 мян.тонн ширэм, 50 тн алт болон бусад дагалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын зах зээлийг ханган, эцсийн бүтээгдэхүүнийг экспортлох боломж бүрдэх бөгөөд 3248 шууд ажлын байр бий болно.


- ✓ Олон улсын туршлагаас харахад хүнд үйлдвэрийг төрөөс дэмжин хөгжүүлснээр эдийн засгийн бодит өсөлт бий болж, аж үйлдвэрийн орон болох боломж бүрдэнэ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Асуудлын хамрах хүрээг тодорхойлсон байдал

УУХҮЯ-наас 2018 онд Говьсүмбэр, Дорноговь, Дархан-Уул, Орхон аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт **хийсэн тооллогоор хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 79 аж ахуйн нэгж хамрагдсан байна.** Үүнээс төмөрлөг боловсруулах 26, металл хийцийн 5, машин, тоног төхөөрөмж эд анги үйлдвэрлэх чиглэлийн 10, газрын тосны бүтээгдэхүүн, резин материалын үйлдвэрлэлийн чиглэлийн 7, кокс, хагас коксын 3, будаг, химийн үйлдвэрлэлийн чиглэлийн 3, шохойн чулуу, цементийн үйлдвэрлэлийн чиглэлийн 8, барилгын дулаалгын чулуун хөвөнгийн 1, хийт бетоны 1, чулууны 1, сэргээгдэх эрчим хүчний чиглэлийн 1, зэс утас үйлдвэрлэх чиглэлийн 2 аж ахуйн нэгж бүртгэгдсэн байна.

Зураг 4. Төвийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй хүнд үйлдвэрлэл



Эх сурвалж: УУХҮЯ, 2018

Нийт үйл ажиллагаа явуулж буй **хүнд үйлдвэрийн 70 орчим хувь нь Хар төмөрлөг, метал хийц, машин угсралтын салбарт ажиллаж байна.** Эдгээр үйлдвэрүүд 2019 оны байдлаар 286 мян.тонн хар төмөрлөг, 16 мян.тонн өнгөт төмөрлөг, 21 мян.тонн металл хийц, 120 ширхэг автобус, 35 ширхэг чиргүүл, 500 ширхэг бусад төхөөрөмж, 53 мян.тонн авто бензин, дизель түлш, 200 тонн бордоо, 450 тонн будаг, резин бүтээгдэхүүн, 30 мян.тонн битум, 4.3 сая тонн цемент, 50 мян.тонн базальт, 270 мянган м³ хийт бетон үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай байна.

2019 оны гүйцэтгэлээр дээрх хүнд үйлдвэрийн салбарын ААН-үүд 208.54 мян.тонн нүүрсэн шахмал түлш, 11.93 мян.тонн катодын зэс, 28.43 мян.тонн металл бэлдэц, 26.90 мян.тонн металл цувимал, 9.23 мян.тонн ган төмөр хийц, 81.95 тонн цахилгаан утас үйлдвэрлэсэн байна.

2019 оны Монгол Улс нийт 6.127 тэрбум ам.долларын импорт хийснээс **машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, эдгээрийн сэлбэг, эд анги болон үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн**

бүтээгдэхүүний импорт нийт импортын 30 орчим хувь буюу 1.783 тэрбум ам.долларыг эзэлж байна. Иймд манай улсын хувьд металлургийн бүтээгдэхүүн импортоос хамааралтай байгаа учраас төмрийн хүдрийг стратегийн бүтээгдэхүүнд хамруулж, экспортод татварын хамгаалалт хийн, дотоодод нэн тэргүүнд металлургийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги, бодлогыг тодорхойлох нь нэн чухал байна.

Мөн хуулийн төсөлд мэргэжилтнүүд дараах байр суурийг илэрхийлж санал гаргасан.

Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл нь улс орны эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлж, улс орон орших уу, эс орших уу гэдгийг тодорхойлох маш чухал ач холбогдолтой юм. Төрөөс аж үйлдвэрийн тухай баримтлах бодлого гаргасан боловч хэрэгжээгүй гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Экспортоор гарч байгаа бүтээгдэхүүний хэмжээ ямар байгаа билээ. Бид энэ хуулийн төсөлд маш сайн анхаарч, тал бүрээс нь хянаж, үр өгөөж гарахуйц хууль болгох хэрэгтэй. Тунхаглалын чанартай, амьдралд хэрэгждэггүй хууль хэрэггүй. Солонгосын аж үйлдвэрийн эрх зүйн орчинг хуулж оруулах хэрэгтэй. Бид энэ хуулийн төслөө төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан зоригтой бичээд, өөрсдөө чуулганы хэлэлцүүлэгт орж хамгаалъя. Үйлдвэржилтийг дэмжих тухай хууль 2015 онд гарсан. Тэр хууль тунхаглалын шинжтэй гараад, хэрэгжээгүй. Энэ хууль тэр хууль шиг байж болохгүй.

Аливаа улсын хууль бол төрөөс баримтлах бодлого эсвэл хөтөлбөр биш. Хуульд хүнд үйлдвэрийг төрөөс дэмжинэ гэж бичихийн оронд хүнд үйлдвэрлэл эрхлэгчдэд ямар нэг санхүүгийн, татварын, хамгаалалтын үр нөлөөтэй тодорхой заалтууд оруулах ёстой.

Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан,
Үндэсний Аж Үйлдвэрийн Зөвлөлийн
гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан

Хүнд үйлдвэрийн харилцааг зохицуулах хууль хэрэгтэй. Хүнд үйлдвэрийн хуулийн төслийг өргөн хүрээнд авч үзэж, эрчим хүч, барилга зэрэг бусад салбарын уялдааг холбоог хангах хэрэгтэй. Бусад салбарын хуулиар зохицуулагдаагүй хүнд үйлдвэр эрхлэгчийн харилцааг энэ хуулиар зохицуулах шаардлагатай. Түүнчлэн үйлдвэрийн чухал нөөц болох хүний нөөцийг бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэх таатай нөхцөлийг бий болгоход чиглэсэн зохицуулалтийг оруулах хэрэгтэй.

ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн
машин үйлдвэрлэлийн салбар, Метал боловсруулалт,
инженерчлэлийн холбоо


Хүнд үйлдвэрийн асуудлыг зохицуулсан суурь хууль зайлшгүй хэрэгтэй. Хуулийн нэрийг өгөхдөө анхаарах хэрэгтэй. Хүнд үйлдвэр гэж юу вэ? гэдгийг үндэслэлтэй тодорхойлж гаргаад түүний дагуу хүнд үйлдвэрийн салбарт хамаарах үйлдвэрүүдийг тодохойлох хэрэгтэй. Олборлох, баяжуулах үйлдвэрүүд хүнд үйлдвэрийн салбарийн үйлдвэрүүд гэдгийг анхаарах хэрэгтэй.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөх Г.Шархүү

Хүнд үйлдвэрийг зохицуулах суурь хууль зайлшгүй шаардлагатай. Хүнд үйлдвэрийн салбар бол маш их хөрөнгө оруулалт шаарддаг салбар. Тийм учраас хүнд үйлдвэрийн хуулийн төслийг боловсруулахдаа хөрөнгө оруулалтын хуультай уялдуулах хэрэгтэй байна. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дээр “Доор дурдсан тохиолдолд импортлолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно.” гэж заасан байна. Үүнд нь: 11.2.1.барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих; 11.2.2.нано, био болон инновацийн технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих; 11.2.3.эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих гээд салбаруудыг зааж өгсөн байна. Энэ хуулийн 11.4 дээр нэмээд хүнд үйлдвэрийн салбар гээд нэмээд өгчихвөл бидэнд тодорхой хэмжээний дэмжлэг болно.

Үндэсний Аж Үйлдвэрийн Зөвлөлийн
гүйцэтгэх хүнд үйлдвэр хариуцсан
менежер Г.Бямбажав

Зураг 5. 2019 оны импортын хэмжээ, төрлөөр



Эх сурвалж: 1212.mn

Монгол Улсын шатахууны хангамж гадаад эх үүсвэрээс бүрэн хамааралтай байгаа өнөө үед газрын тосны дэлхийн үнийн хэлбэлзэл, нийлүүлэлт, валютын ханшны өөрчлөлтөөс шалтгаалан шатахууны хомсдол, бөөний болон жижиглэнгийн үнийн савлагаа үүсэх эрсдэлтэй байдаг. Энэхүү эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс байгаа тул төрөөс газрын тосны үйлдвэрийг байгуулахаар ажиллаж байгаа. Гэвч тухайн үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллах боломжийг хязгаарлах хүчин зүйлс цөөнгүй бөгөөд үүнээс сэргийлэхийн тулд **эрхзүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.**

Монгол Улс хүрэн нүүрсийг бага хэмжээтэй экспортлох, дотоодын ДЦС-уудын хэрэглээг хангахад голлон ашиглаж байна. Нүүрс шингэрүүлэх үйлдвэрлэл анхны

хөрөнгө оруулалт өндөр, нефть боловсруулах энгийн технологитой харьцуулахад технологийн шийдэл нарийн боловч хүрэн нүүрсний нөөц ихтэй, түүхий тосны баталгаат нөөц бага, нефтийн бүтээгдэхүүний 100 хувийн хараат манай орны хувьд нүүрс шингэрүүлж шингэн түлш гаргах үйлдвэр байгуулах боломжийг нарийвчлан судлах нь ирээдүйд өндөр өгөөжтэй байх боломжтой тул **нүүрсний салбарыг дэмжсэн хууль, эрхзүйн орчин шаардагдаж байна.**

Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг, салбарын хөгжлийн түвшин, металл ба металл бус зах зээлийн эрэлт хэрэгцээ, салбар дотор болон салбар хоорондын олон төрлийн ялгаатай эрсдэл, олон нийтийн хандлага, байгаль орчин ба уур амьсгалын өөрчлөлт гэх зэрэг дотоод ба гадаад хүчин зүйлээс хамааран орон зай, цаг хугацаа, байршлын хувьд хуулийн хүрээнд ялгамжтай бодлого, зохицуулалт шаардлагатай байна.

Монгол Улсад уул уурхайн олборлолт, газрын тос, боловсруулах үйлдвэрийн салбар гэсэн гурван ялгаатай салбарын зохицуулалтын сорилт тулгарч байна. Тухайлбал, Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Барилгын тухай, Төмөр замын тээврийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Эм, эмнэлгийн тухай, Эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулиудаар байгалийн нөөц баялгийг ашиглан хүнд үйлдвэрийн салбарт хамаарах бүтээгдэхүүн үйлдвэрлэх харилцааг зохицуулж байна. Мөн эдгээр хуулиудад байгалийн нөөцийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудлыг зохицуулахаар тусгасан ч цааш нь нарийвчлан зохицуулсан зохицуулалт тусгагдаагүй хийдэлтэй, зөвхөн тухай үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлагыг зохицуулсан буюу хэлбэрийн төдий зохицуулалттай байна.(Хавсралт 1)

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гангийн үйлдвэрүүдийн суурилагдсан нийт хүчин чадал 180.0 гаруй мян.тонн байгаагаас 30-60 хувийг л одоо ашиглаж байгаа нь **түүхий эдийн хязгаарлагдмал нөөц, техник технологийн түвшин, мэргэжлийн инженер техникийн ажилтны хүрэлцээ зэрэг хүчин зүйлээс шалтгаалж байна.**


1.2 Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон байдал

2020 оны байдлаар Монгол Улсын хүнд үйлдвэрлэлийн салбарын бодлого, зохицуулалтыг хангаж буй төрийн гол субъект бол УУХҮЯ болон АМГТГ юм.

Хүнд үйлдвэрийн салбарын хууль, эрхзүйн зохицуулалтын хамрах хүрээг дараах байдлаар томъёолж байна. Үүнд:

- УУХҮЯ болон АМГТГ,
- Салбарын яамд, орон нутгийн иргэд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй судалгааны байгууллагууд, салбарын экспертүүд, мэргэжлийн холбоод,
- Төрийн өмчит уул уурхайн компаниуд, хувийн компани болон ТББ-уудын төлөөлөл зэрэг бусад оролцогч талууд.

Зураг 6. Төвийн бүсэд хүнд үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд



Эх сурвалж: УУХҮЯ, 2018

2019 оны байдлаар хүнд үйлдвэрлэлийн салбарт нийт 7244 хүн ажиллаж байгаа бөгөөд **боловсруулах үйлдвэрийн салбарын 22 хувь³ нь ногдож байна.** Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах (хүнд) аж үйлдвэрийн мега төслүүд хэрэгжихэд ажлын байр нэмэгдэж, эдгээр шинэ төслүүдэд шаардлагатай боловсон хүчнийг орон нутаг болон төвлөрсөн хотуудаас авах, мэргэжлийн сургалтад хамруулах, давтан сургах арга хэмжээ авч хэрэгжүүлэх тогтолцоог шинэчлэх шаардлагатай болно. УУХҮЯ-ны хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх газрын тосны үйлдвэр барих, хар төмөрлөгийг хөгжүүлэх, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөлд ойролцоогоор 2560 орчим шинэ мэргэжлийн эрэлт хэрэгцээ үүсэх тооцоо гарсан байна.

Аливаа төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх гол нөхцөл нь салбаруудын хөгжлийн уялдаа, хөрөнгө санхүүгийн зохицуулалт, төслийн гэрээ хэлцэл хийх ажлыг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах төрийн байгууллага нэн чухал юм. Хүнд үйлдвэрлэлийн салбарт хамаарах мега төслүүдийг төсөл хэрэгжүүлэх баг (төслийн нэгж) нэрийн доор хэдэн хэсэг тараах нь үр дүн муутай, хэрэгжих эсэх нь баталгаагүй, хөрөнгө хүч их зарцуулж, тарамдах эрсдэлтэй байгаа тул эдгээр асуудлыг **нэгдсэн удирдлагаар хангах эрхзүйн орчин шаардлагатай байна.**

1.3 Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

- а) **Уул уурхайн гаралтай түүхий эдийг ихээр экспортод гаргаж байгаа ч нэмүү өртөг шингээсэн экспортын бүтээгдэхүүн маш бага байна.** Манай улс байгалийн нөөц ихтэй орны тоонд багтаж байгаа боловч ядуурлын түвшин 2018 оны байдлаар 28.4 хувьтай байгаа нь өндөр үзүүлэлттэй хэвээр байна. Ядуурал буурахгүй байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүнд нөөцийн бүтээмж шингээж, экспортолж чадахгүй байгаатай холбоотой юм. Тухайлбал, 2019 оны гүйцэтгэлээр уул уурхайн боловсруулсан эцсийн бүтээгдэхүүнээр 144.75 мян.тн кокс, 11.93 мян.тн катодын зэс буюу нийт үнийн дүнгээр 96.0

³ УУХҮЯ, 2019

сая ам.долларын бүтээгдэхүүн экспортолсон байна. Энэ нь нийт 6.3 тэрбум ам.долларын уурхайн бүтээгдэхүүний экспортолсны зөвхөн 1.5%-ийг эзэлж байна.

Сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтээр зөвхөн зэсийн баяжмал болон нүүрсний экспорт нь манай улсын нийт экспортын 60 орчим хувь, уул уурхайн салбарын экспортын 68.0 хувийг дангаараа бүрдүүлсэн байна. 2019 онд дээрх хоёр бүтээгдэхүүний экспортын дүн манай улсын нийт экспортын 58.7 хувь, уул уурхайн салбарын экспортын 71.0 хувийг бүрдүүлж байна. Нийт экспортын 90 орчим хувь зөвхөн БНХАУ-руу гардаг нь манай улсын **экспортын бүтээгдэхүүний зах зээлийн девирсификаци хийх боломж тун бага байгааг харуулж байна.**

- b) **Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл технологийн хувьд хоцрогдсон байна.** Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо, хэмжээ өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч нэр, төрлийн хувьд харьцангуй цөөн, технологийн агууламж бага, голдуу хагас боловсруулсан бүтээгдэхүүн хэлбэрээр экспортод гарч байна. Хүнд үйлдвэрлэл нь гол төлөв уул уурхайн түүхий эдийн анхан болон дунд шатны боловсруулалт дээр тулгуурласан бөгөөд уул уурхайн боловсруулах үйлдвэрүүдээс гарч буй бүтээгдэхүүний 97.0 хувь нь технологийн багтаамж багатай хагас боловсруулсан бүтээгдэхүүн эзэлж байна⁴. Энэ нь ОХУ-тай харьцуулахад 4 дахин, БНХАУ-аас 8 дахин доогуур үзүүлэлт юм.
- c) **Төрийн дэмжлэг хангалтгүй, зохицуулалтгүй байна.** Уул уурхайн гаралтай түүхий эдийг боловсруулах чиглэлд төрийн бодлого, хөтөлбөрүүд хангалттай батлагдсан боловч хөрөнгө оруулалтыг хамгаалах, үйлдвэрийн орон зайн төлөвлөлт болон тэдгээр байршил дахь худалдааг дэмжих бодлого сул, хэрэгжилтийн шатанд үйлдвэрүүдийн хүчин чадал, байршлын сонголт, төрийн эзэмшлийн хувь, дэд бүтэц, санхүүжилт зэрэгтэй холбоотой асуудлуудыг зохицуулах шаардлагатай байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилтыг дэвшүүлж (Зорилт 4.2), I үе шат буюу 2021-2030 оныг Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе хэмээн тодорхойлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин, боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн байхаар төлөвлөсөн. Мөн II үе шат буюу 2031-2040 оныг Хүнд, хөнгөн болон эрчим хүч, барилгын материалын үйлдвэрлэлийн хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх шатанд шилжих үе байхаар зааж, боловсруулах салбар давамгайлсан эдийн засгийн бүтцийг бүрдүүлсэн байхаар заасан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Эдийн засгийг төрөлжүүлэх, аж үйлдвэржүүлэх, бүс нутгуудын хөгжлийг дэмжих хууль, эрх зүйн болон хөрөнгө оруулалтын оновчтой зохицуулалтыг бий болгож, барилгын материал, мал, амьтны гаралтай болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын

⁴ <https://mrpam.gov.mn/article/90/>

хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхээр заасан. Мөн уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байх зарчмаар хөгжүүлж, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжих бөгөөд Таван толгойн нүүрсний орд; Оюутолгойн далд уурхай; Дорноговийн цахиурын орд; Цагаан суваргын орд; Хармагтайн орд; Литийн ордыг тус тус ашиглалтад оруулж, Нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк, Зэсийн баяжмал боловсруулах; Нефть-хими, кокс-хими, металлург; Нүүрс угаах; Ган төмөрлөг, Жонш баяжуулах, Алт цэвэршүүлэх өндөр технологийн хүнд үйлдвэрийн цогцолборуудыг барьж, байгуулахаар заасан. Түүнчлэн, газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулах, гадаад, дотоод зах зээлд чиглэсэн гүн боловсруулалтын технологид суурилсан хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ авахаар тус тус төлөвлөсөн байна.

Гэтэл 2015 онд батлагдсан “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” хуульд өрсөлдөх чадвартай, үнэ цэнэ шингэсэн, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаатай, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан боловч УИХ-аас энэ хуулийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болгосноор энэ салбарын дэмжлэг байхгүйтэй адил болсон байна.⁵ Мөн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль 2019 онд батлагдсан хэдий ч тус хуулийн 7.1.7-д зааснаар ашигт малтмал хайх, газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, боловсруулах үйл ажиллагааг хамруулаагүй байна. Өөрөөр хэлбэл, хүнд үйлдвэрийн асуудал хууль, эрх зүйн хувьд зохицуулалтгүй байна. 2018 онд судалгаанд хамрагдсан Төвийн бүсийн 79 үйлдвэрээс 63 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 15 үйлдвэр нь түүхий эдийн олдоц, нийлүүлэлт буурсан, валютын ханшийн өсөлтөөс шалтгаалсан импортын түүхий эдийн үнэ өсөж, бүтээгдэхүүний өртөг нэмэгдэн өрсөлдөх чадваргүй болсон, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтгүй, үйлдвэрийн газар олголтын асуудал, байгаль орчны бохирдлын зэрэг шалтгаанаар үйл ажиллагаагаа зогсоосон нь энэ салбарт төрийн дэмжлэг үгүйлэгдэж байгааг харуулж байна.

Олон улсын амжилттай туршлагаас үзэхэд хүнд үйлдвэрийг хөгжүүлэхдээ дөнгөж эхлэлийн шатанд байгаа үйлдвэрийг хөл дээр нь босгохын тулд хамгаалалтын болон санхүүгийн дэмжлэгийг төрөөс хэрэгжүүлдэг байна. Монгол Улсын холбогдох хуулиудад хүнд үйлдвэрийг төрөөс дэмжих санхүүгийн механизм хангалтгүй байна. Тухайлбал, импортоор оруулж ирсэн болон Монгол Улсад үйлдвэрлэсэн автобензин, дизелийн түлшэд ижил татвар ногдуулсан, Хөрөнгө оруулалтын тухай хуулиар уул уурхайн боловсруулах үйлдвэр барихад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зохицуулалт байхгүй, хүнд үйлдвэр гэдэгт ямар салбарыг хамааруулах зэрэг нь тодорхойгүй байна.

- d) **Төрийн нэгдсэн удирдлага үгүйлэгдэж байна.** Төвийн бүсийн судалгаанд хамрагдсан хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа


⁵ <https://www.legalinfo.mn/law/details/11226>

үйлдвэрийн 48 хувь нь ямар нэг тусгай зөвшөөрөлгүй, 52 хувь нь тусгай зөвшөөрөлтэй бөгөөд эдгээрээс уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй 15 үйлдвэр байна. Үлдсэн 17 үйлдвэр нь Барилга, хот байгуулалтын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Багахангай дүүргийн засаг дарга нараас олгосон тусгай зөвшөөрөлтэй байна.

Мөн судалгаанд хамрагдсан үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрийн 17% буюу 11 үйлдвэр техник, эдийн засгийн үндэслэлийг, 19% буюу 12 үйлдвэр байгаль орчны үнэлгээг холбогдох байгууллагаар хэлэлцүүлсэн байгаа нь энэ салбарт нэгдсэн зохицуулалт алдагдсан байгааг харуулж байна.

е) Хүнд үйлдвэрлэл хөгжих боломж, нөхцөл хязгаарлагдмал байна. Хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлдвэрүүдийн хувьд ган туйван, ган бөмбөлөг, катодын зэс, зэс утас, цемент, машин үйлдвэрлэл, газрын тосны бүтээгдэхүүний болон металл хийцийн зарим үйлдвэрүүд бэхжиж, үйл ажиллагааг тогтвортой байгаа хэдий ч ихэнх үйлдвэрийн түүхий эд, сэлбэг, хэрэгсэл импортоос хараат, хүний нөөц дутагдалтай, борлуулалтыг дэмжих механизм бүрдээгүй, тогтвортой санхүүжилтийн орчин, механизм төлөвшөөгүй учир эргэлтийн хөрөнгө дутагдалтай, шинэ техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх боломж хомс, эрчим хүч, дэд бүтэц, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ бүрэлдээгүй тул дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн импортын бараатай өрсөлдөх, үйлдвэрлэл хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал байна.

Зураг 7. Хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба аж үйлдвэрийн салбарт эзлэх хувийн жин



Эх сурвалж: 1212.mn, 2020 он

Монгол Улсын хүнд үйлдвэрийн салбарыг НҮБ-ын Статистикийн хорооны эдийн засгийн бүх салбарын үйл ажиллагааны ангиллаар авч үзэх нь салбарын хөгжлийн стратеги, бодлого төлөвлөлтийн процессыг илүү хялбаршуулах боломж олгох юм. **(Дэлгэрэнгүй тодорхойлолтыг Хавсралт 2 – оос үзнэ үү.)**

Үндэсний аюулгүй байдал, бүтээгдэхүүний нөөцөөс шалтгаалан төмрийн хүдэр, түүхий газрын тос, зэс, алтыг стратегийн бүтээгдэхүүнд хамруулан боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд бодлогоо чиглүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх нь эдийн засгийн үр өгөөжтэй юм.

Хүнд үйлдвэрийн салбарыг дэмжсэн хууль эрхзүйн орчинг бүрдүүлснээр Монгол Улсын эдийн засаг, нийгэмд дараах үр нөлөөг үзүүлнэ гэж тооцож байна. Үүнд:

- ✓ Хүнд үйлдвэрийн тухай нэр томъёоны ойлголт тодорхойлогдож, салбарын аж ахуй нэгж нэгдсэн зохион байгуулалтад орсноор бүтээгдэхүүний гарц, үйлдвэрлэл нэмэгдэж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сайжирна.
- ✓ Манай улсад нэн тэргүүнд хөгжүүлэх шаардлагатай хүнд үйлдвэрийн салбарыг томъёолж, тэргүүлэх салбарыг хөгжүүлэх төрийн дэмжлэг бүрдэнэ.
- ✓ Эхний ээлжид газрын тос, металлургийн салбарыг дэмжин хөгжүүлснээр дотоодын эрэлт хэрэгцээг хангаж 1.5-2.0 тэрбум ам.долларын гадаад урсгалыг дотооддоо авч үлдсэнээр гадаад худалдааны баланс эерэг гарч, валютын нөөц нэмэгдэнэ.
- ✓ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө ёсоор Нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк, Зэсийн баяжмал боловсруулах; Нефть-хими, кокс-хими, металлург; Нүүрс угаах; Ган төмөрлөг, Жонш баяжуулах, Алт цэвэршүүлэх өндөр технологийн хүнд үйлдвэрийн цогцолборуудыг барьж, байгуулах эрх зүйн орчин бүрдэнэ.
- ✓ Дээр дурдсан хүнд үйлдвэрийн төслүүдээс зөвхөн Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн байгуулах Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл хэрэгжсэнээр 1825.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэх бөгөөд энэхүү төслийн хүрээнд 130.5 мян тонн катодын зэс, 12.0 мян.тонн хүхрийн хүчил, 14.9 мян.тонн тэсрэх бодис, 7.0 мян тонн гаруй цутгамал, металл хийц, механик боловсруулалттай бүтээгдэхүүн болон бусад дагалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1065 шууд ажлын байр бий болно.
- ✓ Олон улсын туршлагаас харахад хүнд үйлдвэрийг төрөөс дэмжин хөгжүүлснээр эдийн засгийн бодит өсөлт бий болж, аж үйлдвэрийн орон болох боломж бүрдэнэ.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээний тайлангийн 1-т заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

1. Хүнд үйлдвэрийн тухай хуулийн зорилго нь түүхий эд, эрдэс баялгийн нөөцөд тулгуурлан хүнд үйлдвэрийг төрийн нэгдсэн бодлогоор дэмжин, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл, боломжийг бүрдүүлж, улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэгдэнэ.

2. Төрөөс хүнд үйлдвэрийн салбарыг дэмжих цогц бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж, төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоог хуульчлахад оршино.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Их Хурлаас 1996 онд баталсан “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал,” 2008 онд баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого,” 2010 онд баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2015 онд баталсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, Засгийн газраас 2019 онд баталсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр” зэрэг хөгжлийн тулгуур баримт бичгүүдэд “Хүнд үйлдвэр”-ийг хөгжүүлэх бодлогыг тухай бүр тусгасан хэдий ч тухайн салбарыг дэмжих төрөлжсөн хууль, эрх зүйн зохицуулалт тодорхой бус байсан учир хүнд үйлдвэрлэлийн хөгжилд томоохон ахиц дэвшил, улс орны эдийн засаг, аж үйлдвэрийн бүтцэд тодорхой өөрчлөлт гарсангүй.

Өөрөөр хэлбэл, хүнд үйлдвэрлэл хөгжих угтвар нөхцөл хангагдаагүй буюу эрх зүйн таатай орчин бүрдээгүйн улмаас бодлого, чиглэл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байснаар төлөвлөсөн үр дүнд хүрэлгүй өнөөдрийг хүрсэн байна.

Мөн хугацаанд Аж үйлдвэрийн салбарын бүтцэд эзлэх боловсруулах салбарын хувь, хэмжээнд онцгой өөрчлөлт гараагүй. Тухайлбал, 2019 оны гүйцэтгэлээр уул уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл нь аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 72 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, төсвийн орлогын 30 орчим хувийг тус тус бүрдүүлдэг боловч экспортын бүтээгдэхүүний 90 орчим хувийг эзэлж буй уул уурхайн бүтээгдэхүүний 95 орчим хувь нь технологийн багтаамжгүй, боловсруулаагүй түүхий эд байсаар байна.

Төр, засгийн зүгээс аж үйлдвэрийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх чиглэл баримталж буй хэдий ч хүнд аж үйлдвэр хөгжих угтвар нөхцөл бүрдээгүй, нөгөө талаас хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нь томоохон дэд бүтцийн асуудлыг бие даан шийдвэрлэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулах санхүүгийн нөөц боломж, туршлага дутмаг байна.

Харин Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус баталж, эдийн засгийг төрөлжүүлэх, аж үйлдвэржүүлэх хууль, эрх зүйн болон хөрөнгө оруулалтын оновчтой зохицуулалтыг бий болгох, барилгын материал, уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилт, арга хэмжээг тусгасан. Мөн 2021-2030 онд 7 төрлийн өндөр технологийн хүнд үйлдвэрийн цогцолборуудыг барьж, байгуулахаар заажээ.

Иймээс асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэж, боломжуудаа алдана.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;	Өнөөгийн тулгамдаж байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;	Хууль, эрх зүйн зохицуулалтгүй байгаа харилцааг эдийн засгийн арга хэрэгслээр зохицуулах боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх;	Хүнд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэснээр зарим үр дүнд хүч болох боловч энэ нь зөвхөн төрийн дэмжлэгийн нэг хэлбэр юм.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;	Хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлсэн олон улсын сайн туршлагаас үзэхэд зөвхөн төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагад шилжүүлэн хөгжүүлсэн туршлага байхгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал шаардагдана.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
6	Захиргааны шийдвэр гаргах;	Хүнд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагааг дүрэм, журам баталж тодорхой асуудлыг шийдвэрлэж болох хэдий ч хууль хоорондын уялдаа холбоог хангахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

		Салбарыг хөгжлийг эрчимжүүлэх зорилгыг биелүүлэх эрх зүйн эх сурвалж болж чадахгүй.		
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.	Хүнд үйлдвэр хөгжүүлэх үйл ажиллагаанд тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Өнөөгийн тулгамдаад байгаа асуудлыг зохицуулалтгүй орхих, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс шууд мөнгөн дэмжлэг үзүүлэх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй юм.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгох нь зүйтэй байна.

Тандан судалгааны хүрээнд олон улсын хүнд үйлдвэрийн салбарын эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд 20 дугаар зууны эхэнд хөгжлийн буурай ангилалд байсан цөөнгүй орнууд хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх төрөлжсөн хууль, тогтоомж баталж, амжилттай хэрэгжүүлснээр аж үйлдвэрийн орон болсон байдаг.

Тухайлбал, дэлхийн II дугаар дайны дараа Япон, Өмнөд Солонгос, Тайван зэрэг өнөө цагийн “Азийн Бар” орнууд хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх төрөлжсөн хуулиуд баталсан бөгөөд эдгээр орны төр, засгийн зүгээс хөгжлийн “Хүчтэй Түлхэх Загвар”-ыг хэрэгжүүлж, хэд хэдэн томоохон секторуудад зохицуулалттай, чиглэсэн хөрөнгө оруулалт хийж, аж үйлдвэрийн салбарт их үсрэлт хийсэн юм. Хүнд үйлдвэр, түүний дотор төмөрлөг, гангийн үйлдвэрлэл, хөлөг онгоц, автомашин, цахилгаан болон электроникийн үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд хөрөнгө хүч, төрийн бодлого, зохицуулалтыг төвлөрүүлж тууштай ажилласны үр дүнд аж үйлдвэрийн тэргүүлэх орнууд болсон байна.

Иймээс Монгол Улс хүнд үйлдвэрийн эрчимтэй хөгжлийг хангахын тулд эрх зүйн таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий тус салбарыг хөгжүүлэх угтвар нөхцөлийг хангасан төрөлжсөн хуулийг батлан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хүнд үйлдвэрийн тухай хуулийн батлан хэрэгжүүлснээр дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

- Төрийн зүгээс хүнд үйлдвэрийг дэмжих нэгдсэн, зорилтот санхүүгийн механизм бүрэлдэнэ.
- Бусад орны дэвшилтэт техник, технологийг нутагшуулна.
- Мэргэжилтэй боловсон хүчний хангамж нэмэгдэнэ.

- Импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэснээр зарим бүтээгдэхүүний хувьд нэг орноос хараа байдал арилж Үндэсний аюулгүй байдалд таатай нөлөө үзүүлнэ.
- Экспортын бүтээгдэхүүний тоо, хэмжээг нэмэгдүүлснээр төсвийн орлого нэмэгдэнэ.
- Хүнд үйлдвэрийг дагасан бусад салбарууд хөгжиж, эдийн засаг төрөлжинө.
- Хүнд үйлдвэрүүдээс олсон орлогоос судалгаа, шинжилгээнд хөрөнгө хуваарилснаар бусад салбар хөгжих анхдагч нөхцөл бүрдэнэ.
- Хүнд үйлдвэрийг зарим бүс нутагт кластераар хөгжүүлснээр тухайн бүс нутгийн өрсөлдөх чадвар нэмэгдэж, хүн амын төвлөрөл саарна.
- ГШХО-ыг салбарын хувьд ялгаатай байдлаар зохицуулах боломж нээгдэнэ.
- Хүнд үйлдвэрийн тухай хуулийн салангид зохицуулалтуудыг нэгтгэн, тухайн салбарт чиглэсэн, бүрэн хэмжээний дэмжлэгийн зохицуулалт бий болно.
- Хүнд үйлдвэрийг төрөөс нэгдсэн бодлого, зохицуулалттай хөгжүүлснээр одоогийн хүнд үйлдвэрүүдийн хяналтгүй байдал цэгцэрч, нэгдсэн хяналттай болно.

**Жич: Олон улсын хүнд үйлдвэрийн салбарын эрх зүйн зохицуулалтыг
Бүлэг 6 -аас үзнэ үү.**

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон 2 хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 5, 6, 7, 8-аас үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Эдийн засгийн тэргүүлэх чиглэл буюу ажлын байрны шингээлт ихтэй хүнд аж үйлдвэрийг дэмжин хөгжүүлснээр Монгол Улсын Үндсэн хуульд заасан ёсоор хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засгийн баталгааг төрөөс бий болгоно.

Өөрөөр хэлбэл, хүний эрхийг аливаа хэлбэрээр хязгаарласан бус тэдгээрийг дэмжих, тогтвортой ажлын байр нэмэгдэж, иргэд амьжиргаагаа дээшлүүлэхэд томоохон түлхэц болно.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хүнд үйлдвэрийн төслүүдээс зөвхөн Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн байгуулах Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл хэрэгжсэнээр 1825.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэх бөгөөд энэхүү төслийн хүрээнд 130.5 мян.тн катодын зэс, 12.0 мян.тн хүхрийн хүчил, 14.9 мян.тн тэсрэх бодис, 7.0 мян.тн гаруй цутгамал, металл хийц, механик боловсруулалттай бүтээгдэхүүн болон бусад дагалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1065 шууд ажлын байр бий болно. Түүнчлэн хар төмөрлөгийг хөгжүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэр барих, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих, үнэт метал цэвэршүүлэх үйлдвэрийн төслүүдийн хувьд 1.5 сая.тн автобензин, түлш, 257.2 мян.тн катодын зэс, 630.0 мян.тн ангижруулсан төмөр, ган бүтээгдэхүүн, 150.0 мян.тн ширэм, 50 тн алт болон бусад дагалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын зах зээлийг ханган, эцсийн бүтээгдэхүүнийг экспортлох боломж бүрдэх бөгөөд 3248 шууд ажлын байр бий болно.

Урт хугацаанд эдийн засаг төрөлжиж урт хугацааны, тогтвортой эдийн засаг бий болж, ажил эрхлэлт нэмэгдэж, эдийн засгийн хөгжил тогтворжино.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбарын тухайд тогтмол ажлын байрыг нэмэгдүүлэх сайн талтай бөгөөд иргэдийн хувьд өөрсдийн нөөц боломжид тулгуурлан хүнд үйлдвэрийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэн орлогоо нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбарын хүрээнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл тодорхой хэмжээнд бий болно. Гэхдээ бусад хууль тогтоомжид тавигдах байгаль орчны холбогдох шаардлагууд, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээний хүрээнд болон байгаль орчинд ээлтэй, шинэ технологийг дэмжих зохицуулалтуудаар сөрөг нөлөөллийг тодорхой хэмжээгээр урьдчилан сэргийлэх, бууруулах боломжтой.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.3-т “Эдийн засгийг төрөлжүүлэх, аж үйлдвэржүүлэх, бүс нутгуудын хөгжлийг дэмжих хууль, эрх зүйн болон хөрөнгө оруулалтын оновчтой зохицуулалтыг бий болгох”, 4.2.7-д “Барилгын материал, мал, амьтны гаралтай болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх” арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тус тус тусгагдсан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны онд баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийг 2021 онд боловсруулж батлуулахаар тусгагдсан.

Иймд дээрх хувилбарууд нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын Олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй болно.

Дараахь хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулна. Үүнд:

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай
2. Хөрөнгө оруулалтын тухай
3. Мэргэжлийн боловсрол сургалтын тухай

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 5 дугаар зүйлийн 5.4-т заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгосон тул харьцуулсан дүгнэлт хийх шаардлагагүй.

ЗУРГАА. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.2-т “Зохицуулалтын хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон тэдгээрийн эерэг, сөрөг тал, тухайн асуудлыг шийдвэрлэсэн бусад орны сайн туршлага зэргийг харьцуулан судалсны үндсэн дээр зохицуулалтын хувилбарыг сонгоно,” гэж заасны дагуу гадаад орнуудын хүнд үйлдвэрийн салбарын бодлого, хууль, тогтоомжийн тухай судалгааг хийж гүйцэтгэлээ.

Энэ хүрээнд 20 орчим орны хүнд үйлдвэрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжуудыг судлан 10 гаруй хууль эрх зүйн баримт бичгийг орчуулсан болно.

Дээрх судалгаанаас үзэхэд зарим улс орнууд хүнд үйлдвэрийн салбар тус бүрээр тухайлсан хуультай, зарим нь үйлдвэрлэлийн, аж үйлдвэрийн, эрдэс баялгийн зэрэг хууль тогтоомжуудад тусгах замаар хүнд үйлдвэр эрхлэх, дэмжих, бүртгэх харилцаагаа зохицуулсан байна.

Улс орон бүр хүн ам, газар нутгийн хэмжээ, өрсөлдөх давуу тал, голлох байгалийн нөөцөөсөө хамааран хүнд үйлдвэрийг өөрийн онцлогт тохируулан төрөлжүүлэн дэмжин хөгжүүлж иржээ. Хүнд үйлдвэрт үзүүлэх дэмжлэг нь эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчин, ажиллах хүчнийг бэлтгэх урт хугацааны бодлого, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүдийг дэмжсэн татварын тодорхой орчин, дэд бүтцийн зохистой сүлжээ зэрэг хэлбэртэй байна.

Мөн хүнд үйлдвэрийн хөгжлийн шатнаас хамааран тухайн улс орнууд бодлого, хууль тогтоомж боловсруулахдаа худалдааны онолд тулгуурлан өөрчилж байсныг онцолж байна. Тухайлбал, туйлын давуу талын онол, харьцангуй давуу талын онол, галуун цувааны онол, өрсөлдөх чадварын онолыг харгалзан хууль тогтоомжууд нь тухай бүр өөрчлөгдөж байсан байна.

Гадаад орнуудын хүнд үйлдвэрийн салбарын бодлого, хууль тогтоомжийг судлах ажлын хүрээнд

- Япон
- БНСУ
- БНХАУ
- Казахстан
- Чили
- Оросын Холбооны Улс
- Австрали Улс
- Герман
- Энэтхэг

зэрэг улсын хүнд үйлдвэр хөгжүүлсэн туршлагыг судлахдаа “Азийн Бар” орнуудын туршлага (Япон, Өмнөд Солонгос) байгалийн баялагтаа тулгуурлан хөгжсөн орнууд (Чили, Австрали), төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай орны туршлага (БНХАУ), пост-социалист орны туршлага (Оросын Холбооны Улс) гэсэн шалгуураар сонгон судалсан болно.


6.1 ЯПОН УЛС (Хүнд үйлдвэрийн хууль тогтоомжийн судалгаа)

Япон улс нь Ази тивийн анхны аж үйлдвэржсэн орон бөгөөд хүнд болон химийн үйлдвэрлэл, электроникийн чиглэлээр дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг юм. Тус орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, үе шатнаас хамааран хүнд үйлдвэрлэл хөгжүүлэх бодлого, хууль тогтоомжийн зорилго харилцан адилгүй байсан юм.

Япон улсад хүнд үйлдвэрлэл дараах үе шатыг дамжин хөгжиж ирсэн байна.

- Анх хүнд үйлдвэрлэл хөгжсөн цаг үе (1890-1940).
- Хүнд үйлдвэрийн бүтээмжийг дээшлүүлэх чиглэлд анхаарсан цаг үе (1945-1989).
- Хүнд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлд анхаарсан цаг үе (1990 -) гэж ангилж болно.

Зураг 8. Япон улсын хүнд үйлдвэрийн салбарын хуулийн өөрчлөлт шинэчлэл



Нэг. Япон улсад анх хүнд үйлдвэр хөгжсөн цаг үе (1890-1940).

Япон улс нь 1890-1940 оны хооронд хүнд үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлд онцгой анхаарал тавьж, салбар бүрийг тусгайлан дэмжих тухай хуультай байжээ. Хар болон өнгөт төмөрлөгийн үйлдвэр, усан онгоцны үйлдвэр, суурь машины үйлдвэр, нефть-химийн боловсруулах үйлдвэр, машин үйлдвэрлэлийг сонгон дараах төрөлжсөн хуулиар зохицуулж байсан байна. Тухайлбал:

- Хар төмөрлөгийн үйлдвэрийн тухай хууль (1917)
- Газрын тосны тухай хууль (1934)
- Машин үйлдвэрлэлийн тухай хууль 1936
- Гангийн үйлдвэрлэлийн тухай хууль (1937),
- Суурь машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэлийн тухай хууль (1938),
- Агаарын хөлгийн үйлдвэрлэлийн тухай хууль (1938),
- Усан онгоцны үйлдвэрлэлийн тухай хууль (1939),
- Өнгөт төмөрлөг үйлдвэрлэлийн тухай хууль (1939),

➤ *Химийн үйлдвэрийн тухай хууль (1940)*⁶

Эдгээр хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх төрөлжсөн хуулиуд нь Япон улсыг хөгжүүлэх “Хөгжлийн Стандарт Загвар”-ын дөрвөн зарчимд тулгуурлаж, бодлогын цөм болж байсан юм. “Хөгжлийн Стандарт Загвар”-ын дагуу хүнд үйлдвэрийн төрөлжсөн хуулиудад тус салбарыг дэмжих дараах нийтлэг зохицуулалт багтсан байдаг. Үүнд:

- *Дотоодын аж үйлдвэрийг татвар, тарифын хүчээр хамгаалах;*
- *Үндэсний банкнуудыг хөгжүүлэн мөнгөний бодлогыг тогтвортой байлгах, том төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх;*
- *Төмөр замын сүлжээ, бусад дэд бүтцийг хөгжүүлэх замаар үндэсний хэмжээний зах зээлийг бий болгох;*
- *Бүх нийтийн боловсролыг дэмжих замаар ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх.*

Эдгээр хүнд үйлдвэр хөгжүүлэх салбарын төрөлжсөн хуулиудыг хэрэгжүүлснээр Япон улс хөдөө аж ахуйн орноос хүнд үйлдвэр хөгжсөн аж үйлдвэрийн орон болсон бөгөөд энэ хугацаанд тус улсын хүнд үйлдвэрийн ДНБ-нд эзлэх жин бараг хоёр дахин өссөн байна.

Аливаа хууль нь тухайн цаг үед оршин буй төр-засгийн бодлогын тусгал байдгийн хувьд хүнд үйлдвэрлэл хөгжүүлсэн эдгээр төрөлжсөн хуулиудад Засгийн газраас хүнд үйлдвэрийн салбарыг дайны захиалгад дайчлах зэргээр хэт хяналт тогтооход чиглэсэн зохицуулалт цөөнгүй байжээ.

Хоёр. Хүнд үйлдвэрийн бүтээмжийг дээшлүүлэх чиглэлд анхаарсан цаг үе (1945-1989).

Дэлхийн II дугаар дайны дараа эдийн засгаа сэргээх зорилгоор Япон улс хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх төрөлжсөн “түр” хуулиуд баталсан бөгөөд тус улсын төр, засгийн зүгээс хөгжлийн “Хүчтэй Түлхэх Загвар”-ыг хэрэгжүүлснээрээ онцлог цаг үе байдаг. Тус улс нь хөгжлийн “Хүчтэй Түлхэх Загвар”-т тулгуурлан хүнд үйлдвэрийн хэд хэдэн гол секторуудад зохицуулалттай, чиглэсэн хөрөнгө оруулалт хийж, аж үйлдвэрийн салбарт их үсрэлт хийсэн юм.

Хүнд үйлдвэр, түүний дотор төмөрлөг, гангийн үйлдвэрлэл, хөлөг онгоц, автомашин, цахилгаан болон электроникийн үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд хөрөнгө хүч, төрийн бодлого, зохицуулалтыг төвлөрүүлж тууштай ажилласны үр дүнд 1990 он гэхэд нэг хүнд ногдох ДНБ нь 20,000\$ ам.долларт хүрсэн байна.

(Япон улсын аж үйлдвэрийн салбарт үйлчилж буй хуулиудаас хүнд үйлдвэрийн төрөлжсөн “түр” хуулиудыг тодоор тэмдэглэв.)

- *Аж үйлдвэрийн стандартын тухай хууль (1949);*
- *ХАҮ танхим болон Үйлдвэрийн тухай хууль (1950);*
- *Жижиг, дунд үйлдвэрийн даатгалын тухай хууль (1950);*
- *Эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1952);*
- ***Аж үйлдвэрийн тухай хууль (1952);***
- *Үйлдвэрийн тухай журам (1953);*
- ***Газны үйлдвэрлэлийн тухай хууль (1954);***
- *Цөмийн энергийн тухай хууль (1954);*
- ***Нүүрсний үйлдвэрлэлийн бүтээмжийг дэмжих түр хууль (1955);***

⁶ <https://www.meti.go.jp/english/information/data/laws.html>

- **Суурь машин, эд анги (тоног төхөөрөмж) үйлдвэрлэлийн бүтээмжийг дэмжих түр хууль (1956);**
- *Нэхмэлийн үйлдвэрлэлийн бүтээмжийг дэмжих түр хууль (1956);*
- **Электроникийн үйлдвэрлэлийг дэмжих тухай түр хууль (1957);**
- *Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль (1963);*
- *Цахилгаан хэрэгслийн үйлдвэрийн тухай хууль (1963);*
- *Тусгай бүсийн аж үйлдвэрийг дэмжих тухай хууль (1964);*
- *Жижиг, дунд үйлдвэрийг туслан гүйцэтгэгчээр ажиллуулах тухай хууль (1970);*
- **Электроникийн болон суурь машин үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1971);**
- **Аж үйлдвэрийн байршлын тухай хууль (1972);**
- **Суурь машин болон мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих түр хууль (1978);**
- **Уналтад орсон үйлдвэрүүдийг дэмжих тухай түр хууль (1978);**
- *Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль (1979);*
- *Эрчим хүчний уламжлалт бус эх үүсвэрийг дэмжих тухай хууль (1980);*
- **Зарим төрөлжсөн үйлдвэрийн бүтцийн өөрчлөлтийг дэмжих тухай хууль (1983).**

Эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнд Японы аж үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалт 1970 он гэхэд Үндэсний орлогын гуравны нэгтэй тэнцсэн байна. Япон улс 1923 онд 2.4 сая.тн ган үйлдвэрлэж байсан бол 1975 он гэхэд 100 гаруй сая.тн-д хүрчээ. Ган үйлдвэрлэлийг даган усан онгоц, автомашин, суурь машин, барилгын зэрэг олон салбар цэцэглэн хөгжсөн байдаг. Япон улс хөгжлийн “Хүчтэй Түлхэх Загвар”-ыг хэрэгжүүлснээр 1990 он гэхэд эдийн засгийн хөгжил, амьдралын түвшнээр барууны орнуудтай нэг түвшинд ирсэн юм.

Гурав. Хүнд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлд анхаарсан цаг үе (1990 -)

Энэ үед 1990 оноос хойш буюу мэдлэгт тулгуурласан аж үйлдвэрийн хөгжлийн үе хамаарна. 1990 оноос 2020 он хүртэлх Япон улсын аж үйлдвэрийн хөгжлийн онцлог нь шинжлэх ухаан, инноваци, мэдээллийн технологид тулгуурлан өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн өрсөлдөх чадвараа дээшлүүлэх чиглэлд төрийн бодлого, хууль тогтоомжийн зорилго орших болсон явдал юм. Тухайлбал дараах хуулиудыг иш татаж болно:

- **Аж үйлдвэрлэлийг дахин сэргээх тухай хууль (1999)**
- **Аж үйлдвэрийн суурь технологийг дэмжих тухай хууль (1999)**
- **Аж үйлдвэрийг дахин сэргээх, инновацын үйл ажиллагааг дэмжих тухай хууль (2001)**
- **Бүс нутгийн үйлдвэрлэлийн кластерийг дэмжих тухай хууль (2007)**
- **Аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг чадавхжуулах тухай хууль (2013)**
- **Аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулах тухай хууль (2014)**

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Япон улсын хүнд үйлдвэрийн харилцааг зохицуулж буй хуулиудаас 1952 оны “Аж үйлдвэрийн хөгжлийн тухай” хууль болон 1990 оны “Аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг төгөлдөршүүлэх тухай” хуулийн агуулга, бүтцийг товч судалж үзье.

Аж үйлдвэрийн хөгжлийн тухай хууль (1952)

(Industrial Rationalization Promotion Act)

1952 онд баталсан “Аж үйлдвэрийн хөгжлийн тухай” хууль нь хүнд үйлдвэрийн салбарыг дэмжих төрөлжсөн хуулиудтай зэрэгцэн үйлчилж байсан бөгөөд аж үйлдвэрийн бүтээмжийг өсгөхийн тулд зардал бууруулах, гарцыг нэмэгдүүлэх чиглэлд гол ач холбогдол өгсөн суурь хууль юм.

Тус хуулийн нэгдүгээр зүйлд *“энэ хуулийн зорилго нь техник, технологийг шинэчлэх, үйлдвэрийн завсрын түүхий эдийн болон эд анги үйлдвэрлэлийн чанарыг сайжруулж, аж үйлдвэрийн бүтээмжийг дээшлүүлэх замаар үндэсний эдийн засгийн бие даасан байдалд хувь нэмэр оруулахад оршино”* хэмээсэн байна.

1952 оны Аж үйлдвэрийн хөгжлийн тухай хууль нь дараах агуулга бүтэцтэй. Үүнд:

- Ерөнхий үндэслэл;
- Техник, технологи сайжруулах үйл ажиллагааг дэмжих тухай;
- Засгийн газраас үйлдвэрлэлийн судалгаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай;
- Машин судлалыг татварын бодлогоор дэмжих, хөнгөлөх, чөлөөлөх тухай;
- Машин, тоног төхөөрөмжийн модерни, шинэчлэлийг дэмжих тухай;
- Үйлдвэрлэлийн байгууламжийг дэмжих тухай;
- Үйлдвэрийн суурь бүрдлийг дэмжих;
- Жижиг, дунд үйлдвэрийн шалгуур, шаардлага;
- Тайлан мэдээ, шалгалт хяналт;
- Хариуцлага.

Аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг төгөлдөршүүлэх тухай хууль (1990) (*Industrial Competitiveness Enhancement Act*)

Япон улсын эдийн засгийн жилийн дундаж өсөлт 1960-1970-аад онуудад 7.5% байсан бөгөөд 1980 оноос буурсаар 1990 он гэхэд 3.2% хүртэл унасан байна. Иймээс эдийн засгийн зогсонги байдлаас гарах, аж үйлдвэрийн салбарыг идэвхжүүлэх бодлогын хүрээнд “Аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг төгөлдөршүүлэх тухай” хуулийг 1990 онд баталсан юм.

Япон улсын аж үйлдвэрийн шинэ бодлого “Аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг төгөлдөршүүлэх тухай” хуулийн зорилгод тусгагдсан байдаг. Тус хуулийн зорилгыг *“Аж үйлдвэрийн хөгжлийн зогсонги байдлаас гарахын тулд нийгэм, эдийн засгийн шаардлагад нийцүүлэн бүтцийн өөрчлөлт хийж, өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу, төр, хувийн хэвшлийн эрх үүргийг тогтоон, тогтолцооны шинэчлэлийг эхлүүлж, аж үйлдвэрийн үйл ажиллагааг дахин сэргээхийн тулд зайлшгүй дэмжих шаардлагатай болон жижиг, дунд үйлдвэрүүдийг **хөрөнгө оруулалтын корпорацын дэмжлэгтэйгээр** идэвхжүүлж, нийгмийн сайн сайханд хувь нэмэр оруулахын зэрэгцээ үндэсний эдийн засгийг төгөлдөршүүлэхэд оршино”* хэмээн тодорхойлсон байна. “Аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг төгөлдөршүүлэх тухай” хууль нь дараах агуулга бүтэцтэй. Үүнд:

Нэгдүгээр бүлэг: Ерөнхий үндэслэл

Хоёрдугаар бүлэг: Аж үйлдвэр хариуцсан төрийн байгууллагын шинэчлэлийн тухай

Гуравдугаар бүлэг: Үйлдвэрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиг үүрэг, үйл ажиллагаа

- Шинэ болон судалгаанд тулгуурласан үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалтаар дэмжих
- Бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх
- Үйл ажиллагааг дахин идэвхжүүлэх
- Үйлдвэрийн оюуны өмчийн эрхийг хамгаалах
- Үйлдвэрлэлийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах

Дөрөвдүгээр бүлэг: Инновацыг дэмжих чиг үүрэг бүхий хөрөнгө оруулалтын корпорац байгуулах тухай

- Ерөнхий үндэслэл
- Үүсгэн байгуулах
- Захиргаа, удирдлага
- Үйл ажиллагаа
- Төрийн тусламж
- Санхүү, нягтлан бодох бүртгэл
- Хяналт
- Татан буулгах үндэслэл

Тавдугаар бүлэг: Жижиг, дунд үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих

- “Старт-апп” эхлэлийн компанийг дэмжих
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тогтолцоог шинэчлэх

Зургаадугаар бүлэг: Бусад

Долоодугаар бүлэг: Хариуцлага

Япон улсын 1952 оны “Аж үйлдвэрийн хөгжлийн тухай” хууль нь аж үйлдвэрийн бүтээмжийг нэмэх зорилгоор материаллаг чиглэлд санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлэхэд голлон анхаарч байсан бөгөөд тус хууль амьдралд хэрэгжсэнээр хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний өөрийн өртгийг 4%-с 30% хувь хүртэл бууруулсан үр дүнд гарсан байдаг. Харин 1990 оны “Аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг төгөлдөршүүлэх тухай” хууль нь илүү судалгаа, шинжилгээний чиглэлээр санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд гол анхаарлаа хандуулсан бөгөөд 2013 онд шинэчлэн найруулж дахин баталсан байна.

Япон Улсын хувьд хүнд үйлдвэрлэл гэдэгт гангийн үйлдвэрлэл, машин үйлдвэрлэл, хөлөг онгоцны үйлдвэрлэл, химийн үйлдвэрлэл зэрэг салбарыг хамруулж байна. Тус улсын хувьд үйлдвэрлэлд тавигдах стандартыг маш сайн тогтоож хэрэгжүүлдэг. Стандартчиллын тухай тусгайлсан хуультай бөгөөд уг хууль дараах харилцааг зохицуулдаг байна. Үүнд:

Бүлэг 1. Ерөнхий заалт (1 ба 2 дугаар зүйл)

Бүлэг 2. Японы үйлдвэрлэлийн стандартыг шалгах хороо (3-10 дугаар зүйл)

Бүлэг 3. Японы үйлдвэрлэлийн стандартыг бий болгох (11-18 дугаар зүйл)

Бүлэг 4. Японы уул уурхайн болон үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний стандартад нийцсэн гэрчилгээ.

а. Хэсэг 1. Японы үйлдвэрлэлийн стандартад нийцэж буй байдлын тухай (19-24 дүгээр зүйл)

б. Хэсэг 2. Гэрчилгээжүүлэх байгууллагын бүртгэл (25-30 дугаар зүйл)

с. Хэсэг 3. Япон улсын бүтээгдэхүүнийг гэрчилгээжүүлэх бүртгэлийн систем (31-40 дүгээр зүйл)

- d. Хэсэг 4. Гадаадын улсын бүтээгдэхүүнийг гэрчилгээжүүлэх бүртгэлийн систем (41-56 дугаар зүйл)
- Бүлэг 5. Бүтээгдэхүүний туршилтын бизнес (57-66 дугаар зүйл)
- Бүлэг 6. Бусад (67-69 дугаар зүйл)
- Бүлэг 7. Хариуцлага (70-76 дугаар зүйл)

6.2 ӨМНӨД СОЛОНГОС (Хүнд үйлдвэрийн хууль тогтоомжийн судалгаа)

Аж үйлдвэрлэлийн тэргүүлэгч орнуудын нэг БНСУ (Өмнөд Солонгос) улс нь 1950-иад оны төгсгөл үе гэхэд урт хугацааны гаднын колоничлол, түүний дараах хоёр солонгосын дайны хөлд нэрвэгдэж, Ази тивийн хамгийн ядуу орон болсон байв. Гэвч гал зогсоох хэлэлцээрийн дараа Өмнөд Солонгосын төр, засгаас эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн шат дараалсан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх хууль, эрх зүйн эх сурвалжийг баталсан байдаг. Ийнхүү аж үйлдвэр хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэнээр тус улс нь харьцангуй богино хугацаанд заяагдмал баялагт тулгуурласан эдийн засгаас үр ашиг-аж үйлдвэрт тулгуурласан эдийн засагт шилжиж, улмаар ололт амжилтаа бататган инновац-шинэ санаачилгад тулгуурласан аж үйлдвэрийн хөгжлийн шатанд хүрчээ. Өмнөд Солонгосын аж үйлдвэрийн хөгжлийн энэхүү амжилтыг тоон үзүүлэлтээр илэрхийлбэл нэг хүнд ногдох ДНБ нь 1994 онд 10,000\$, 2006 онд 20,000\$, 2018 онд 30,000\$ тус тус давсан байна.

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн ийм амжилтад хүрэхийн тулд Өмнөд Солонгос нь 1962 оноос 1993 он хүртэл тав, таван жилийн төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлсэн байдаг. Өмнөд Солонгосын “хүнд үйлдвэрлэл” хөгжүүлэх бодлого, хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлийг зорилго, агуулгаар нь дараах байдлаар 3 ангилж болно.


Нэгдүгээр шат: Хүнд үйлдвэрийн “төрөлжсөн” хууль үйлчилж байсан үе (1962-1985)

Хоёрдугаар шат: Хүнд үйлдвэрийн харилцааг “Аж үйлдвэрийн хөгжлийн тухай” ерөнхий хуулиар зохицуулсан үе (1986-2000)

Гуравдугаар шат: Аж үйлдвэрийн хөгжлийн тухай хуулийн зэрэгцээ Хүнд үйлдвэрийн зарим харилцааг “тусгай” хуулиар зохицуулсан үе (2001-)

**Зураг 9. Өмнөд Солонгосын хүнд үйлдвэрийн салбарын хуулийн өөрчлөлт,
шинэчлэл**

**Хүнд үйлдвэрийн салбарын хуулийн өөрчлөлт
(1953-2001)**



Нэгдүгээр шат: Хүнд үйлдвэр хөгжүүлэх “төрөлжсөн хууль” (1962-1985)

Өмнөд Солонгос нь хүнд үйлдвэрийн төрөлжсөн хуультай болохоос өмнө тус салбарын зах зээлийг хамгаалсан гааль, татвар, санхүүгийн чиглэлийн хэд хэдэн хууль баталсан бөгөөд эдгээр хуулиар импортыг хязгаарлах хатуу бодлого явуулсны үр дүнд үндэсний үйлдвэрлэгчдийг хамгаалж, импортын бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх чиглэлийг баримталсан байна. Хөнгөн үйлдвэр хөгжүүлэх бодлогын дараа хоёрдугаар 5 жилийн төлөвлөгөөний хүрээнд хүнд үйлдвэрийг дэмжих төрөлжсөн хуулиудыг батлахаар тусгажээ.

Экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгын хүрээнд машин байгууламж, усан онгоц, хар төмөрлөг, электроник, нефть-химийн үйлдвэрлэл, өнгөт төмөрлөг боловсруулалт гэсэн 6 чиглэлийг стратегийн салбараар сонгосон байна. Ингээд хүнд үйлдвэрийг дэмжих дараах хуулиудыг баталжээ.

- Суурь машин үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1967)
(*Machinery Industry Promotion Act*)
- Усан онгоц үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1967)
(*Shipbuilding Industry Promotion Act*)
- Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1969)
(*Iron and Steel Industry Support Act*)
- Электроникийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1969)
(*Electronic Industry Promotion Act*)
- Нефть, химийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1970)
(*Petrochemical Industry Support Act*)
- Өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (1971)
(*Nonferrous Metals Refining Industry Act*)⁷

⁷ <https://www.moleg.go.kr/index.es?sid=a3>

Дээрх хүнд үйлдвэрийн салбарыг дэмжсэн 6 хуулиар экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр засгаас онцгой анхаарч хөнгөлөлттэй зээл олгох, үйлдвэртээ зориулж импортоор оруулж байгаа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг гаалийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх зэрэг дэмжлэг нийтлэг тусгагдсан байдаг.

Ийнхүү хүнд үйлдвэрийн салбар тус бүрээр хууль баталж, тухайн салбарыг дэмжих бодлого хэрэгжүүлсний үр дүнд тус орны хүнд үйлдвэрийн салбар экспортын нийт бүтээгдэхүүний 80 хувьд хүрсэн юм.

Хоёрдугаар шат: Аж үйлдвэрийн хөгжлийн хууль (1986-2000)

Өмнөд Солонгос нь хөнгөн үйлдвэрээс хүнд үйлдвэрийн хөгжилд амжилттай шилжсэний дараа буюу 1986 онд хүнд үйлдвэрийн салбарын харилцааг тус тусдаа зохицуулж байсан хуулиудаа нэгтгэж “Аж үйлдвэрийн хөгжлийн тухай хууль” гэсэн нэг ерөнхий хуультай болсон.

1986 онд батлагдсан “Аж үйлдвэрийн хөгжлийн хууль”-иар цаашдын үйлдвэржүүлэлтийн бодлогоо тодорхойлсон бөгөөд аж үйлдвэрийн салбарын бодлогын гол агуулга нь зээллэг, санхүүгийн дэмжлэгээс гадна судалгаа, технологийн чиглэлд илүү дэмжлэг үзүүлэхээр тусгасан байна.

“Аж үйлдвэрийн хөгжлийн хууль” нь 7 бүлэг, 30 зүйлтэй бөгөөд тус хуулийн нэгдүгээр зүйлд “*аж үйлдвэрийн салбарыг тэнцвэртэй хөгжүүлэх, тус салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих замаар үндэсний эдийн засгийн өсөлтийг хангахад тус хуулийн зорилго оршино*” гэж заажээ.

Нэгдүгээр бүлэг: Аж үйлдвэрийг дэмжих ерөнхий бодлого

Хоёрдугаар бүлэг: Аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлтийг дэмжих тухай

- *Урт хугацааны чиглэлийг тогтоох тухай;*
- *Өрсөлдөх чадварыг сайжруулах тухай;*
- *Бүтээмжийг нэмэгдүүлэх тухай;*
- *Үр ашиг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулах тухай;*
- *Үр ашиг нэмэгдүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай;*
- *Зөвлөх, тохируулах, зохицуулах тухай;*
- *Үйлдвэрийг бүртгэх тухай;*
- *Үр ашигтай ажиллаж буй үйлдвэрлэлийг дэмжих;*
- *Түүхий эдийг хэмнэлттэй ашиглах арга хэмжээ авах;*
- *Үйлдвэрийн төрөлжилтийг дэмжих арга хэмжээ авах тухай.*

Гуравдугаар бүлэг: Үйлдвэрийн гарц, технологийг сайжруулах

- *Үйлдвэрийн гарц, технологийг сайжруулах тухай;*
- *Сайжруулах төлөвлөгөө боловсруулах тухай;*
- *Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай;*
- *Өндөр технологи хөгжүүлэх сан байгуулах тухай;*
- *Бүтээмжийн асуудал эрхэлсэн агентлаг байгуулах тухай.*

Дөрөвдүгээр бүлэг: Үйлдвэрлэл хөгжүүлэх сангийн тухай

- *Сан байгуулах тухай;*
- *Сангийн эх үүсвэр тухай;*
- *Сангийн үйл ажиллагаа тухай;*
- *Сангийн ашиглах зориулалтын тухай.*

Тавдугаар бүлэг: Үйлдвэрлэл хөгжүүлэх хороо болон үйлдвэрлэл эрхлэгчийн бүлэг

- *Хороо байгуулах тухай*
- *Бүтэц, зохион байгуулалт болон менежмент*
- *Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүлгийн тухай*
- *Зохион байгуулалт, менежмент*
- *Хамтын ажиллагаа*
- *Харилцан туслалцах тухай*

Зургаадугаар бүлэг: Нэмэлт зохицуулалт

- *Хамтарсан үйл ажиллагааг дэмжих тухай;*

Долоодугаар бүлэг: Хариуцлага.

Гуравдугаар шат: Аж үйлдвэрийн хөгжлийн хуулиас гадна хүнд үйлдвэрийн төрөлжсөн хуулиар зохицуулж буй үе (2001-)

2000 оноос Өмнөд Солонгосын Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн чиг хандлага шинэ санаа, шинэ бүтээл зэрэг мэдлэгийн багтаамж өндөр чиглэлд онцгой анхаарах болсон. Үйлдвэрлэлийн салбарт илүү шинэ санаа нэвтрүүлж, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд бизнесийн таатай орчин бүрдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэгчид болон том компаниудын хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлогыг дэмжин хөгжүүлж байна.

2009 онд тус улсын аж үйлдвэрийн хөгжлийн түвшин, цаашдын хөгжлийн шинэ бодлого, чиг хандлагад нийцүүлэх үүднээс шинэ “Аж үйлдвэрийн хөгжлийн тухай” хуулийг шинэчлэн найруулсан. Өмнөд Солонгосын 2009 оны “Аж үйлдвэрийг хөгжлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга нь 8 бүлэг, 50 зүйлтэй бөгөөд тус хуулийн үзэл баримтлалыг “мэдлэгт тулгуурласан, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн, аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар үндэсний эдийн засгийг хөгжүүлнэ” гэж зорилго хэсэгт заасан байна.

2009 оны “Аж үйлдвэрийг хөгжлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга нь дараах бүтэцтэй байна.

Нэгдүгээр бүлэг: Ерөнхий үндэслэл

- *Зорилго;*
- *Үйлчлэх хүрээ;*
- *Үйлдвэрлэл хөгжүүлэх бодлого.*

Хоёрдугаар бүлэг: Үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дэмжих тухай

- *Дунд хугацааны урьдчилсан төсөөлөл;*
- *Өндөр технологи, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нутагшуулах;*
- *Салбар тус бүрийн өрсөлдөх чадварыг сайжруулах бодлого боловсруулах;*
- *Шинэ үйлдвэр байгуулах санаачилгыг урамшуулах;*
- *Мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг хөхүүлэн дэмжих;*
- *Бүс нутгийн хөтөлбөрийг дэмжих;*
- *Нарийн мэргэшсэн үйлдвэрлэл хөгжүүлэх төслийг дэмжих тухай бодлого боловсруулах;*
- *Хамтын ажиллагааг идэвхжүүлэх;*
- *Удирдах боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх;*
- *Бизнесийн шинэчлэлийг дэмжих;*
- *Үйлдвэрийн статистик, тоо бүртгэлийн системийг хөгжүүлэх;*

- *Өнөөгийн байдлын судалгаа.*

Гуравдугаар бүлэг: Тогтвортой аж үйлдвэрийн үндсийг тавих тухай

- *Нөөц ашиглалтыг сайжруулах;*
- *Нөөц ашиглалтыг сайжруулах үйл ажиллагааг урамшуулах;*
- *Тогтвортой үйлдвэрлэлийн стандарт, хэмжих үзүүлэлтийг тогтоох;*
- *Тогтвортой удирдлагыг хэрэгжүүлэх ерөнхий бодлого;*
- *Аж үйлдвэрийн нэгжид бүтцийн өөрчлөлт хийх тухай ;*
- *Бүтцийн өөрчлөлт хийхэд хувийн хөрөнгө оруулалтын татах,*
- *Бүтцийн өөрчлөлт хийх аж үйлдвэрийн нэгжийн хязгаар, шалгуур үзүүлэлт;*
- *Хувийн хөрөнгө оруулалтын сангийн менежментийн загвар.*

Дөрөвдүгээр бүлэг: Хүлэмжийн хий бууруулах технологийг дэмжих, сайжруулах

- *Хүлэмжийн хий бууруулах технологи үйлдвэрлэх бизнесийг дэмжих;*
- *Хүлэмжийн хий бууруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компанийг дэмжих;*
- *Бүтээмжийн төвийн тухай;*
- *Төсөлд зориулсан санхүүгийн эх үүсвэр.*

Тавдугаар бүлэг: Олон улсын үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг дэмжих тухай

- *Олон улсын үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг дэмжих бодлого;*
- *Олон улсын үйлдвэрлэлийн зөвлөх байгууллагын үйл ажиллагаа;*
- *Хувийн үйлдвэрийн хамтын үйл ажиллагааг дэмжих;*
- *Хувийн шинжээчийн татан оролцуулах тухай.*

Зургаадугаар бүлэг: Худалдааны холбоо

- *Холбоод харилцан туслалцах*


Долоодугаар бүлэг: Нэмэлт

Өмнөд Солонгос нь 2009 онд “Аж үйлдвэрийн хөгжлийн тухай” хуулиа шинэчлэн найруулснаас гадна хүнд үйлдвэрийн зарим салбарыг дэмжих зорилгоор дараах төрөлжсөн хоёр хуулийг 2001- 2011 онд баталсан.

- *Тусгай үйлдвэрийг дэмжих үйл ажиллагааны тухай хууль (2001)*
- *Суурь үйлдвэрлэлийг төгөлдөршүүлэх, дэмжих тухай хууль (2011)*

Дээрх хүнд үйлдвэрийн салбарын төрөлжсөн хуулиуд нь аж үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түүхий эд, материал, тоног төхөөрөмж, эд анги, сэлбэг хэрэгслээр хангах завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилготой.

Зураг 10. Суурь болон Тусгай үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зохицуулах харилцаа



Суурь үйлдвэрлэлийг төгөлдөршүүлэх, дэмжих тухай хууль (2011)

(Act On The Promotion And Sophistication Of Ppuri Industries)

Энэ хуулийн зорилго нь “суурь үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлж, тус салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, төгөлдөршүүлэх замаар тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад оршино” гэсэн байна.

Суурь үйлдвэр гэдэгт “цутгах, хэв дарах, металлурги, гагнуур, бутлах, хайлах” зэрэг үйл ажиллагааг ойлгох бөгөөд жижиг, дунд болон дундаас дээш бүх үйлдвэр хамаарахаар зохицуулжээ.

“Суурь үйлдвэрлэлийг төгөлдөршүүлэх, дэмжих тухай” хууль нь дараах бүтэцтэй.

- Зорилго
- Нэр томьёо
- Төв болон орон нутгийн төрийн байгууллагын үүрэг хариуцлага
- Суурь үйлдвэрлэлийг дэмжих мастер төлөвлөгөө
- Жилийн төлөвлөгөө, хэрэгжилт
- Суурь үйлдвэрлэл хөгжүүлэх хороо
- Суурь үйлдвэрийн статистик, мэдээлэл цуглуулах
- Суурь үйлдвэрийн хүний нөөц
- Суурь үйлдвэрийн хүний нөөцийг сургах тогтолцоог бэхжүүлэх
- Гадаад ажилчид, инженер, техник технологи болон судалгааны мэргэжилтнүүдэд хөнгөлөлт дэмжлэг үзүүлэх
- Суурь үйлдвэрлэлийн нарийн мэргэжсэн мэргэжилтнийг сонгох, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх
- Суурь үйлдвэрийн хүний нөөцийн өнөөгийн байдлыг судлах
- Суурь үйлдвэрлэлийн судалгаа, үндсэн технологи хөгжүүлэлтийг бэхжүүлэх
- Суурь үйлдвэрийн төрөлжилтийг дэмжих, бэхжүүлэх
- Нэн чухал суурь үйлдвэрийг сонгох, дэмжих
- Суурь үйлдвэрийн автоматжуулалтыг төгөлдөршүүлэх
- Суурь үйлдвэр байгуулахыг дэмжих
- Суурь үйлдвэрийн тусгай цогцолбор хөгжүүлэх, бэхжүүлэх
- Тусгай цогцолборыг дэмжих
- Суурь үйлдвэрийг дэмжих төвийг байгуулах-чадавхжуулах

- Суурь үйлдвэрт зориулсан мэргэжил сургалтын тогтолцоог сайжруулах, дэмжих

“Тусгай” үйлдвэрийг дэмжих үйл ажиллагааны тухай хууль (2001)

Энэ хуулийн зорилго “үйлдвэрийн материал болон эд анги (тоног төхөөрөмж) үйлдвэрлэлийн хөгжлийн суурийг бэхжүүлэх, аж үйлдвэрийн бусад салбарыг завсрын материал, эд анги, тоног төхөөрөмжөөр хангах замаар үндэсний эдийн засгийг харилцан тэнцвэртэй хөгжүүлэхэд оршино” гэж заасан байна.

Үйлдвэрийн материал гэдэгт үйлдвэрийн эцсийн биш хагас боловсруулсан түүхий эд, бүтээгдэхүүнийг ойлгох бол эд анги, тоног төхөөрөмж гэдэгт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн суурь машин байгууламжид ашиглах эд анги, сэлбэг хэрэгслийг ойлгоно хэмээн заасан байна.

2001 оны “Тусгай үйлдвэрлэлийг дэмжих тухай” хууль нь дараах бүтэцтэй байна.

Нэгдүгээр Бүлэг: Ерөнхий үндэслэл

- Зорилго
- Нэр томьёо

Хоёрдугаар бүлэг: Материал, эд ангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндсэн төлөвлөгөө

- Материал, эд анги үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндсэн төлөвлөгөөг зохиох
- Материал, эд анги үйлдвэрлэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх
- Материал, эд анги үйлдвэрлэлийн статистик, тоо мэдээг бэлтгэх

Гуравдугаар бүлэг: Материал, эд ангийн төрөлжсөн үйлдвэрлэлийн дэмжих, хөнгөлөх, чөлөөлөх

- Материал, эд анги үйлдвэрийг бүртгэх, баталгаажуулах- хяналт
- Материал, эд анги үйлдвэрийн бүртгэлийг өөрчлөх, шинэчлэх
- Материал, эд анги үйлдвэрийн хөрөнгө оруулалтын холбоо
- Материал, эд анги үйлдвэрлэлд гадаадын хөрөнгө оруулалт татах
- Материал, эд анги үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулах журам
- Материал, эд анги үйлдвэрлэлийн хамтарсан судалгааны нэгдэл
- Материал, эд анги үйлдвэрлэлийн судалгааны нэгдэлд техникийн туслалцаа үзүүлэх
- Материал, эд анги үйлдвэрлэлд зориулсан технологи хөгжүүлэлтийг дэмжих, туслалцаа үзүүлэх
- Материал, эд анги үйлдвэрлэлийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр
- Материал, эд анги үйлдвэрлэлийн мэдээ, мэдээллийн систем
- Материал, эд анги үйлдвэрлэлд бүтцийн өөрчлөлт хийх
- Материал, эд анги үйлдвэрлэлд татварын хөнгөлөлт үзүүлэх

Дөрөвдүгээр бүлэг: Материал, эд ангийн үйлдвэрлэлийн худалдаа, технологи хөгжүүлэлт

- Материал, эд анги үйлдвэрлэлийн технологи хөгжүүлэх төсөл, гүйцэтгэл

- *Материал, эд анги үйлдвэрлэлийн худалдаа, технологийн зах зээлд гарах үр дүн*
- *Солонгосын Материал, эд анги үйлдвэрлэлийн технологийн холбоо*
- *Материал, эд анги үйлдвэрлэлийн харилцан туслалцах корпорац*

Тавдугаар бүлэг: Материал, эд ангийн үйлдвэрлэлийг шинэчлэх тогтолцоо байгуулах

- *Материал, эд анги үйлдвэрлэлийг сайжруулах, шинэчлэх төсөл, хөтөлбөрийн суурь бүрдүүлэх*
- *Материал, эд анги үйлдвэрлэлийг Засгийн газрын тэтгэлэг, татаасаар дэмжих*

Зургаа дугаар бүлэг: Материал, эд ангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хороо

- *Материал, эд анги үйлдвэрлэлийн Хороо*
- *Материал, эд анги үйлдвэрлэлийн тухай тайланг шинжлэх ухаан, технологийн зөвлөлд хүргүүлэх*

Долоодугаар бүлэг: Нэмэлт

- *Шимтгэл төлбөр*
- *Хариуцлага*

Дээрх хуулиудаас гадна Уул уурхайн үйлдвэрлэлийн хуультай бөгөөд /Mining Industry Act/ 2007 оны 04-р сарын 11-ний өдөр шинэчилсэн найруулга нь батлагдаж, өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Тус хуулийн **зорилго нь** ашигт малтмалын нөөцийг зохистой ашиглах замаар үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, уул уурхайн салбарын суурь харилцааг зохицуулахад оршдог⁸ байна. Уул уурхайн үйлдвэрлэлийн хуулийг 2007 онд шинэчлэн найруулснаас хойш нийт 17 удаагын нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.

Хуулийн бүтцийн хувьд нийт 10 бүлэгтэй. Бүлэг тус бүрийн хувьд дараах харилцааг тус тус зохицуулдаг онцлогтой. Үүнд :

Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл – Хуулийн зорилго, нэр томъёоны тайлбар, ашигт малтмал ашиглах, газрын тос олборлох тусгай зөвшөөрлийн талаар зохицуулсан.

Хоёрдугаар бүлэг: Уул уурхайн аж үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөл – Энэ бүлэгт уул уурхайн салбарт хайгуул, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл, уг салбарт гадаадын иргэдийн үйл ажиллагаа эрхлэх эрх, үүрэг, хязгаарлалт, олборлолтын тусгай зөвшөөрлийн хугацаа, уул уурхайн нэгж талбар, олборлолтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргах, олборлолтийн тусгай зөвшөөрөл олгох талбай, түүний нэгж талбар, давхцалын талаар дэлгэрэнгүй зохицуулсан.

Гуравдугаар бүлэг: Уул уурхайн салбар дахь концесс – Концессын гэрээний талаар зохицуулсан.

⁸ https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=49335&type=new&key=

Дөрөвдүгээр бүлэг: Уул уурхайн салбар дахь бизнесийн үйл ажиллагаа – Энэхүү бүлгээр уул уурхайн олборлолтын үйл ажиллагаанд төр, төрийн өмчийн компаниуд хэрхэн оролцох, ямар эрх эдлэх талаар зохицуулсан.

Тавдугаар бүлэг: Газрыг эзэмших, ашиглах – Ашигт малтмалын үйл ажиллагаа явуулахад бусдын талбайд нэвтрэх, аливаа саадыг арилгах, тухайн газрын эзэмших, ашиглах эрх, үүргийг зохицуулсан.

Зургаадугаар бүлэг: Уул уурхайн үйлдвэрлэлийн явцад үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх талаар зохицуулсан.

Долдугаар бүлэг: Уул уурхайн салбар дахь төрийн хяналт ба дэмжлэг – Тус бүлэг нь уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны зүгээс тавих хяналт болон дэмжлэгийн талаар нарийвчлан зохицуулсан.

Наймдугаар бүлэг: Өргөдөл, гомдол гаргах – Энэхүү бүлгээр холбогдох яамны гаргасан шийдвэр, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг гаргах журмыг зохицуулсан.

Есдүгээр бүлэг: Нэмэлт заалтууд – Тус бүлгээр салбарын яамны сайд нь өөрийн эрх хэмжээний хүрээнд тухайн ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж буй газар нутгийн Засаг, захиргаанд эрх шилжүүлэх боломжийн тухай, мөн уул уурхайн салбарын хамтын ажиллагаа, төлбөр, хураамжийн талаар зохицуулсан.

Аравдугаар бүлэг : Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Түүнчлэн дээрх хуулиас гадна тус салбарын үйл ажиллагааг зохицуулсан олон дүрэм, журмуудыг гаргасан байдаг. Жишээлбэл БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамнаас гаргасан Уул уурхайн аж үйлдвэрлэл тооллогын дүрэм⁹ (Mining Industry Census Rules) юм. Тус дүрмээр 1963 оноос хойш 5 жил тутамд нэг удаа тус салбарт үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад хяналт, шалгалт хийдэг байна. Тус журамд зохицуулснаар хяналт шалгалт нь дараах төрөлтэй байдаг. Үүнд :

Бизнесийн онцлогтой холбоотой зүйлсийн талаар,
Хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсний талаар,
Хүнд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өртгийн талаар,
Үйлдвэрлэлийн хүчин чадлын талаар,
Тээвэрлэлт, импортын хүчин чадлын талаар,
Бараа материалын хэмжээний талаар,
Үл хөдлөх эд хөрөнгийн талаар,

9

https://www.law.go.kr/LSW//lsInfoP.do?efYd=19640416&lsiSeq=37278&urlMode=lsInfoP&ancYnChk=&chrcIsCd=010202&fbclid=IwAR35S5WrYpH9qlcdLSenmWLhmbnBYspDvjOI382jJKsOkvGzIRwO_ILukPk#0000

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй эрчим хүчний байгууламжийн талаар,

Татварын хувь, хэмжээтэй холбоотой асуудлаар,

Хүснэгт 2. Өмнөд Солонгосын Аж үйлдвэрийн салбарт холбогдох ерөнхий болон тусгай зохицуулалт агуулсан хууль тогтоомжийн жагсаалт

Холбогдох хууль	Аж үйлдвэрийн салбар	Хүнд үйлдвэрийн салбар
- Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хууль - Уул уурхайн аюулгүй ажиллагааны тухай хууль - Уул уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн тухай хууль - Уул уурхайн үйлдвэрлэлийн тухай хууль - Үндэсний тэнцвэртэй хөгжлийн тухай хууль - Технологи хөгжүүлэх тухай хууль - Цацраг идэвхт хог хаягдлын менежментийн хууль - Газрын тос дамжуулах хоолойн аюулгүй байдлын хяналтын хууль - Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, түгээх үйл ажиллагааг дэмжих тухай хууль - Шингэрүүлсэн шатдаг хийн аюулгүй байдал, хяналтын тухай хууль - Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлэх тухай хууль - Том болон жижиг, дунд үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжих тухай хууль	-Аж үйлдвэрийн хөгжлийн хууль -Аж үйлдвэрийн салбар хоорондын уялдаа холбоог дэмжих хууль -Аж үйлдвэрийн кластер хөгжүүлэх, үйлдвэр байгуулах тухай хууль -Аж үйлдвэрийн технологийн инновацыг дэмжих тухай хууль -Аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг дэмжих тухай хууль -Техно-паркийг дэмжих тухай хууль - Үйлдвэрлэлийн технологийн горимын тухай хууль -Үйлдвэрлэлийн стандартчиллын тухай хууль -Нефть, нефтийн бус шатахууны тухай хууль -Нүүрсний үйлдвэрлэлийн тухай хууль -Эрчим хүчний хууль	Тусгай үйлдвэрийг дэмжих тухай хууль Суурь үйлдвэрлэлийг дэмжих тухай акт

6.3 БНХАУ (Хүнд үйлдвэрийн хууль тогтоомжийн судалгаа)

БНХАУ нь хүнд үйлдвэрийн асуудлыг тусгайлан хуулиар зохицуулдаггүй, төрөлжсөн хуулиуд болон бодлого, журмаар зохицуулж байна. Үүнд:

- **Төрийн өмчийн үйлдвэрийн газрын тухай хууль.** 2008.10.28. Энэ хууль нь Хятад улсын эдийн засгийн суурь тогтолцоог хамгаалах, үндэсний эдийн засгийг хөгжүүлэх, төрийн өмчийн эдийн засгийн салбарыг нэгтгэх, өргөжүүлэх, социалист зах зээлийн эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн. Энэ хуулийн хүрээнд төрийн өмчийн аж ахуйн нэгж, компаниуд, төрийн өмчит хувьцаат компаниуд хамаарна.
- **Жижиг дунд үйлдвэрийг идэвхжүүлэх тухай хууль.** 2002.06.29. Энэ хуулиар санхүүжилт, дэмжлэг, технологийн дэвшил, зах зээлийн хөгжил, төрийн хяналтын асуудлыг зохицуулсан. Уг хуулийн зорилго нь жижиг, дунд үйлдвэрлэлийн бизнесийн орчныг сайжруулах, зөв хөгжлийг дэмжих, хот, хөдөө орон нутагт ажлын байр бий болгох замаар эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах юм.
- **Хятад-Гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэр байгуулах тухай хууль.** 1979.07.01, Энэ хуульд 1990, 2001 онуудад Бүх ард түмний нэгдсэн хурлаар нэмэлт өөрчлөлт оруулсан. Уг хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагч этгээд БНХАУ-ын ААН-тэй хамтарсан хувьцаат компани байгуулах нь нээлттэй бөгөөд эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд үндэслэнэ. Гадаадын хамтарсан хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь нь бүртгэгдсэн хөрөнгийнхөө 25 хувиас багагүй байхаар зохицуулсан.
- **Байгаль орчныг хамгаалах татварын тухай хууль.** 2016.12.25. Энэ хууль 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Хятадын хувьд “ногоон татварын систем”-тэй болж буй бөгөөд тусгай татварын анхны хууль юм. 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Хятад улсад Байгаль орчныг хамгаалах татварын тухай хууль хэрэгжиж эхэлснээр нөөцийн ба байгаль орчны татварыг нэгэн зэрэг хэрэглэх болсон.
- **Аж үйлдвэрийн бүлгийн тухай хууль (Industrial Group Act).** 2009 оны 05-р сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон. Аж үйлдвэрийн бүлгийн тухай хуулийн зорилго нь аж үйлдвэрүүдийн хоорондын харилцааг зохицуулах, хамтын ашиг тусыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрэлийн шинэчлэлийг дэмжих, эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэхэд оршино. Энэ нь 5 бүлэг 70 зүйлтэй нэлээд том хууль.

Түүнчлэн БНХАУ нь төмөр болон гангийн аж үйлдвэрийн хөгжлийн тусгайлсан бодлогыг батлан хэрэгжүүлдэг.

БНХАУ-д эдийн засгийн хөгжлийн урт хугацааны туршид гангийн эрэлт харьцангуй их байсаар ирсэн бөгөөд гангийн үйлдвэрлэл олон жилийн туршид дэлхийд нэгдүгээрт тооцогдож байв. Гэсэн хэдий ч гангийн үйлдвэрлэлийн техникийн түвшин, материал зарцуулалт нь олон улсын дэвшилтэт түвшингээс хоцрогдсон хэвээр байна. Ирээдүйн хөгжлийн гол чухал зүйл бол технологийн шинэчлэл болоод бүтцийн зохицуулалт юм. Гангийн үйлдвэрлэлийн техникийн ерөнхий түвшинг дээшлүүлэх, бүтцийн зохицуулалтыг дэмжих, аж үйлдвэрийн бүтцийг сайжруулах, тойрог эдийн засгийг (circular economy) хөгжүүлэх, эд материалын хэрэглээ болон эрчим хүчний зарцуулалтыг бууруулах, байгаль орчныг хамгаалах асуудалд ач холбогдол өгөх, аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг

нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн шинэчлэлд хүрэх зорилгоор холбогдох хууль тогтоомж болоод гангийн үйлдвэрүүдэд тулгарч буй дотоод, гадаад нөхцөл байдлын дагуу үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэрэгцээг үндсэнд нь хангасан олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай гангийн үйлдвэрүүдийн тоо хэмжээ, чанар, төрөл зүйлийг хөгжүүлэх, гангийн үйлдвэрийн зөв хөгжлийг удирдан чиглүүлэх зорилгоор энэхүү хөгжлийн бодлогыг гаргасан байна.

Энэхүү бодлогыг хэрэгжүүлсэнээр бүтээгдэхүүний бүтцийн тохируулга хийж, 2010 он гэхэд Хятадад өндөр чанарын гангийн бүтээгдэхүүний хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдэж, ихэнх бүтээгдэхүүн нь үндсэндээ барилга, химийн үйлдвэр, автомашин, гэр ахуйн болон цахилгаан хэрэгсэл, усан онгоц, тээвэр, төмөр зам, цэргийн үйлдвэр болон шинээр хөгжиж буй үйлдвэрүүдийн хэрэгцээ, шаардлагыг хангаж өгнө. Төмрийн болон гангийн үйлдвэрлэлийн бүтцийн тохируулга хийснээр нэгтгэх, өөрчлөн байгуулах ажлын хэрэгжүүлсэнээр харьцангуй давуу тал бүхий үндсэн аж ахуйн нэгжийн бүлгүүдийн цар хүрээ өргөжиж, үйлдвэрийн төвлөрөл нэмэгдэнэ. 2010 он гэхэд төмөр, ган хайлуулах үйлдвэрүүдийн тоо мэдэгдэхүйц буурч, төмрийн аж ахуйн нэгжүүдийн эхний аравт багтах үйлдвэрлэл нь үндэсний үйлдвэрийн 50 гаруй хувийг эзэлж, 2020 онд энэ тоо 70-аас дээш хувьд хүрнэ.

Мөн төмөр, гангийн үйлдвэрлэлийн бүтцийг тохируулснаар 2020 он гэхэд эрчим хүчний хангамж, тээврийн тохиргоо, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон байгаль орчны шаардлагад нийцсэн илүү оновчтой үйлдвэрлэлийн бүтэц бий болно гэж бодлогод тусгагдсан байна.

Уг бодлогод гангийн үйлдвэрлэлийг дараах хэлбэрээр дэмжихээр тусгагдсан. Үүнд:

1. Ганг орлох өндөр үзүүлэлт, хямд зардал, бага зарцуулалттай шинэ эд материалыг судалж, боловсруулахыг дэмжинэ.

2. Төмөр болон ган үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг дээд зэргийн бат бэх, зэврэлтэнд тэсвэртэй ган үйлдвэрлэх, гангийн бат бэх чанар болоод ашиглалтын хугацааг нэмэгдүүлэхийг дэмжинэ.

3. Гангийн зарцуулалт, түүнээс дээш халуун цувисан ган баар, төрөл бүрийн зориулалттай өндөр хүчин чадал бүхий ган хавтан мөн Н-цацрагийг 3-р зэрэгт (400MPa) хүргэн бууруулахыг дэмжинэ.

4. Газрын тосны худгийн хоолой, дамжуулах хоолойн ган хавтан, устөрөгчийн сульфид болон нүүрстөрөгчийн давхар ислийн зэврэлтэнд тэсвэртэй, агаар мандлын заврэлтэнд тэсвэртэй ган хавтан, зүсэлттэй ган, галд тэсвэртэй ган зэрэг бүтээгдэхүүнийг болосвруулж, хөгжүүлэхийг дэмжинэ.

Эдгээр бодлого, хуулиудаас гадна Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2007.03.26, Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжийн тухай хууль 1986.04.12, Стандартын тухай хууль 1988.12.29, Гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадын аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварын тухай хууль 1991.04.09, Гадаад худалдааны хууль 1994.03.12 зэрэг хуулиудаар хүнд үйлдвэрт холбогдох харилцааг зохицуулж байна.

БНХАУ нь хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхдээ тусгайлан дэмжсэн хууль батлаагүй боловч аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр муж, хотын түвшинд аж үйлдвэрийн паркийн талаар баримтлах бодлого, дүрэм, аж үйлдвэрийн паркийг удирдах журам зэргийг батлан мөрдүүлдэг байна. Тухайлбал, Ганьсу мужийн Жиаюгуаний Ардын Засгийн газраас Ганьсу мужийн Жиаюгуаний аж үйлдвэрийн

паркийн бодлого ба дүрмийн баталсан бол Ляжин хотод Лижян хотын аж үйлдвэрийн үндсэн паркуудыг удирдах журмаар зохицуулдаг байна.

1.Ганьсу мужийн Жиаягуаний аж үйлдвэрийн паркийн бодлого ба дүрэм¹⁰. Энэхүү бодлого, дүрэм нь аж үйлдвэрийн парк байгуулах үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ технологи, ололт амжилт болон өндөр технологийн аж үйлдвэрийн хувьслыг дэмжих, үйлдвэржилтийн явцыг хурдасгах, олон төрлийн аж ахуйн нэгж болоод шилдэг боловсон хүчнийг дэмжих, татан оролцуулах зорилготой.

Бодлого ба дүрэм нь газар, татвар, санхүү, боловсон хүчин, урамшууллын бодлого болон бусад гэсэн 6 бүлэг, 22 зүйлээс бүрдэх бөгөөд дараах зохицуулалтыг агуулсан байна:

Нэгдүгээр бүлэгт: Аж үйлдвэрийн паркт багтаж буй бүх аж ахуйн нэгжүүд газар шилжүүлэн авах, түрээслэх, хөрөнгө оруулах, хувьцаа санал болгох замаар газар ашиглах эрхээ авах эрхтэй байх бөгөөд газар ашиглах эрх авсан газар ашиглагчид ашиглалтын хугацаанд тухайн газрыг бусдад шилжүүлэх, түрээслэх, барьцаалах болон зориулалтын дагуу эдийн засгийн бусад үйл ажиллагаанд ашиглах боломжтой, ийнхүү газар ашиглах эрх шилжүүлэх дээд хугацаа: орон сууцны зориулалттай газарт 70 жил, үйлдвэрлэлийн газарт 50 жил, боловсрол, технологи, соёл, эрүүл мэнд болон спортын газарт 50 жил, худалдаа, аялал жуулчлал, үзвэр үйлчилгээний газарт 40 жил, хамтран эзэмших болон бусад газарт 50 жил байна.

Хоёрдугаар бүлэгт: Аж үйлдвэрийн паркт багтаж буй аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлээ эхлүүлсэн өдрөөс эхлэн 3 жилийн хугацаанд туршилтын үйлдвэрлэл явуулна. Туршилтын үйлдвэрлэлийн хугацаанд хотын санхүүжилтэд буй орон нутгийн татвар (нэмэгдсэн өртгийн албан татвар, аж ахуйн нэгжийн албан татвар, орлогын албан татвар)-ыг аж ахуйн нэгжийн хөгжлийг дэмжихэд бүрэн хэмжээгээр ашиглаж болно. Туршилтын үйлдвэрлэлийн хугацаа дууссаны дараа орон нутгийн төсвийн орлогын 50 хувийг (нэмэгдсэн өртгийн албан татвар, аж ахуйн нэгжийн албан татвар, орлогын албан татвар) таван жилийн хугацаанд аж ахуйн нэгжийн хөгжлийг дэмжихэд зарцуулна.

Гуравдугаар бүлэгт: Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт нь 5-10 сая юань (үүнд 5 сая юань багтана) бүхий аж үйлдвэрийн паркт хамаарах аж ахуй нэгжүүдэд тухайн хугацаанд банкинд байршуулсан үндсэн хөрөнгийн бодит хөрөнгө оруулалтанд үндэслэн орон нутгийн төсвөөс зээл олгож болно. Нэг жилийн хугацаанд зээлийн хүүг бууруулж дэмжлэг үзүүлнэ.

10 сая ба түүнээс дээш юанийн хөрөнгө оруулалттай аж үйлдвэрийн паркт хамаарах аж ахуй нэгжүүдэд тухайн хугацаанд банкинд байршуулсан түүний үндсэн хөрөнгийн бодит хөрөнгө оруулалтанд үндэслэн орон нутгийн төсвөөс хоёр жилийн хугацаанд зээлийн хүүг бууруулж дэмжлэг үзүүлнэ.

30 сая ба түүнээс дээш юанийн үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт бүхий аж үйлдвэрийн паркт хамаарах аж ахуй нэгжүүдэд засгийн газраас 2 байгууламж үнэ төлбөргүйгээр олгоно. (тус бүр нь 80-120 м.кв талбайтай байна.) 5000 болон 10,000 юаниас дээш үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт бүхий аж үйлдвэрийн паркт хамаарах аж ахуй нэгжүүдэд засгийн газраас 3 байгууламж үнэ төлбөргүйгээр олгоно. 20 сая юань нэмэгдэх тутамд нэг багц байгууламж нэмж олгогдоно. 10

¹⁰ <http://laws.66law.cn/law-81356.aspx>

жилийн турш бизнес эрхэлж буй аж ахуй нэгжүүд байгууламжийн үл хөдлөх хөрөнгийн эрхийг үнэ төлбөргүй авч болох зохицуулалтууд туссан.

Дөрөвдүгээр бүлэгт: Их, дээд сургуулийн бакалавр болон түүнээс дээш (магистр болон докторын) зэрэгтэй этгээд болон дотоодын эрдэм шинжилгээний судалгааны байгууллагуудад судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг, технологи, түүнийг зохион бүтээгч болон өмчийн технологиор мэргэшсэн этгээд аж үйлдвэрийн паркт ажиллах бөгөөд дараах хөнгөлөлт эдлэхээр заасан:

1.Бүртгэлтэй аж ахуйн ажилчид, мэргэжлийн болон техникийн ажилчид болон тэдгээрийн хөдөө орон нутагт байнгын бүртгэлтэй гэр бүлийн хүмүүс болон хүүхдүүд хөдөө орон нутгийн бүртгэлээс бүртгэлгүй байнгын оршин суух газар руу шилжих албан ёсны журмыг дагаж холбогдох төлбөрөөс чөлөөлөгдөнө.

2.Паркт ажиллахаар ирсэн байнга оршин суух ахлах боловсон хүчин (доктор, үндэсний хэмжээний мэргэжилтнүүд, магистр болон түүнээс дээш, дэд профессороос дээш мэргэжлийн болон техникийн ажилтнууд гэх мэт)-ийг орон сууцаар үнэгүй хангах болон орон сууцаа үнэ төлбөргүй солих, мөн таваас дээш жил үргэлжлүүлэн ажиллахад автомашин худалдаж авахад дэмжлэг үзүүлж, тав хүртэл жилийн хугацаанд төлсөн хувь хүний орлогын албан татварын хэмжээтэй дүйцэхүйц хэмжээний тэтгэмж олгоно.

3.Аж үйлдвэрийн паркт аж ахуй нэгжийг байгуулан удирдахаар ирсэн бүх мэргэжлийн болоод техникийн боловсон хүчин парктай холбоотой бусад бодлогыг мөрдөн паркт байгуулагдсан жижиг дунд үйлдвэрлэлийн сангаас зээл авах болон зээлийн батлан даалтын хүсэлтийг гаргах давуу эрх эдэлнэ.

Тавдугаар бүлэгт: Аж үйлдвэрийн паркт бүртгэлтэй аж ахуй нэгжүүд төслөө боловсруулж, төлөвлөсөн хуваарийн дагуу үйлдвэрлэл нэвтрүүлсний дараа паркийн удирдлагын хорооноос төслийг гүйцэтгэсэн зуучлагч болон тэргүүний ажилтнуудыг урамшуулах зохицуулалт тусгагдсан бөгөөд урамшууллын санг санхүүжилтээр бүрдүүлэхээр заажээ. Үүнд:

1.Хорооны нутаг дэвсгэрт шинэ төсөл хэрэгжүүлж буй зуучлагч байгууллага болон хувь хүмүүст төсөл хэрэгжиж дууссаны дараа бодит хөрөнгө оруулалтын 5 хувьтай тэнцэх хэмжээний нэг удаагийн урамшууллыг аж үйлдвэрийн паркийн удирдах хорооноос олгоно.

2.Шинжлэх ухаан, технологийн ололт, патентлагдсан технологи, мужийн өндөр түвшний шинэ технологи, түүнчлэн тухайн мужид шаардлагатай технологийг нэвтрүүлсэн этгээдэд олсон ололт ажмилтад үндэслэн паркийн удирдах хорооноос нэг удаагийн урамшууллыг нэмэгдсэн өртгийн албан татварын нэг хувиар тооцож олгоно.

3.Аж үйлдвэрийн паркт хөрөнгө оруулалт оруулсан этгээдэд “хэн зүтгэнэ, тэр сайшаагдана” гэсэн зарчмын дагуу нэг удаагийн үндсэн хөрөнгийн 5 хувьтай тэнцэх, оруулсан хөрөнгө оруулалтын 1.5 хувьтай тэнцэх урамшууллыг тус тус олгох зэрэг зохицуулалттай байна.

Зургаадугаар бүлэгт: Аж үйлдвэрийн паркт бүртгэлтэй аж ахуй нэгж үйлдвэрлэлийн өртгөөс бусад захиргааны төлбөрөөс чөлөөлөгдөх, аж үйлдвэрийн паркийн удирдлагын хорооны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулагчдаас ямар нэгэн хураамж авах, хөрөнгө оруулагчдын хууль ёсны үйлдвэрлэл, үйл ажиллагаанд саад учруулахын тулд аливаа нэгж, хувь хүн паркт нэвтрэхийг хориглох зохицуулалт тусгагдсан байна.

2.Лижян хотын аж үйлдвэрийн үндсэн паркуудыг удирдах журам¹¹. Энэхүү журам нь БНХАУ-ын Лижян хотын аж үйлдвэрийн үндсэн паркуудад шинжлэх ухаанч, стандартчилагдсан менежментийг хэрэгжүүлэх, аж үйлдвэрийн үндсэн паркуудын бүтээн байгуулалт, хөгжлийг хурдасгах зорилготой бөгөөд 7 бүлэг 45 зүйлтэй байна. Журмын зохицуулалтыг товч тоймлон авч үзвэл:

Нэгдүгээр бүлэгт: журмын зорилго, аж үйлдвэрийн паркийн тодорхойлолтыг тусгасан байх ба журам нь аж үйлдвэрийн паркууд дахь байгууллага, хувь хүн, мөн энэхүү журамд заасан үйл ажиллагааг эрхэлдэг аж үйлдвэрийн паркаас гадуурх байгууллага, хувь хүмүүст хамаарахаар заасан. Мөн Лижян хотын аж үйлдвэр технологийн хороо нь үндсэн аж үйлдвэрийн паркуудыг иж бүрэн менежментийн болон бизнесийн удирдлагаар хангаж, зохицуулалт хийх талаар заасан.

Хоёрдугаар бүлэгт: Лижян хотын аж үйлдвэрийн үндсэн парк болох зорилгоор үндэсний болон хотын, эсхүл мужийн аж үйлдвэрийн паркууд өргөдөл гаргах боломжтой байх тухай, болон өргөдөл гаргах журмыг зохицуулж, тус хотын аж үйлдвэрийн үндсэн паркад тавих шаардлагуудыг дараах байдлаар заасан:

- (1) Шинжлэх ухааны аж үйлдвэрийн үндсэн паркийн төлөвлөлт, техник эдийн засгийн үндэслэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, тайлантай байх;
- (2) Паркийн талбай нь 5 км²-с багагүй радиустай байх ёстой бөгөөд тухайн талбайд дэд бүтцэд холбогдсон, таван үндсэн холболтыг хийлгэсэн (цахилгаан, усан хангамж, харилцаа холбоо, бохир ус болон хөрсний бохирдлыг зайлуулах, газрыг тэгшитгэл), байршил нь тээвэрлэлт, харилцаа холбоо, газар нутгийн байршлын давуу талтай байх, сайн чанарын барилга байгууламжтай байх;
- (3) Аж үйлдвэрийн парк дахь аж үйлдвэрүүд нь тухайн бүс нутгийг аж үйлдвэрлэлийг илүү хөгжүүлэх төлөвлөгөөтэй байх, аж үйлдвэрийн тэргүүлэх салбаруудын харьцангуй шинж чанар болон давуу талыг ашиглах, аж үйлдвэрийн салбарын өсөлтийн чадвар сайтай байх, илүү сайн урт хугацааны үйлдвэрлэлийн гинжин хэлхээтэй байх;
- (4) Паркад элсэх тэргүүлэх аж ахуйн нэгжүүд нь өндөр түвшний технологитой, инновацийг чадвар сайтай байх ёстой бөгөөд чадварлаг эрдэм шинжилгээний судалгааны төв болон боловсролын институцийг бий болгоход шинжлэх ухааны болон технологийн дэмжлэг үзүүлэх;
- (5) Зөв менежментийн зохион байгуулалтын системтэй, манлайллын оновчтой удирдлага, өндөр үр ашиг бүхий үйл ажиллагааны системийг бий болгосон байх;
- (6) Аж үйлдвэрийн парк дахь аж ахуй нэгжүүд нь үндэсний аж үйлдвэрийн бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг байх.

Гуравдугаар бүлэгт: Лижян хотын аж үйлдвэр, мэдээллийн технологийн хорооны үндсэн чиг үүрэг, хотын аж үйлдвэрийн үндсэн паркийн удирдлага, менежментэд тавих хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй байгууллага, хот, дүүргийн захиргаанаас өөрийн нутаг дэвсгэрт байрлах аж үйлдвэрийн үндсэн паркуудын өмнө хүлээх үүрэг зэрэг удирдлага, зохион байгуулалт, хариуцлагын талаар заасан.

Дөрөвдүгээр бүлэгт: Аж үйлдвэрийн үндсэн паркийн барилга, байгууламж ба менежментийн зохицуулалт буюу аж үйлдвэрлэлийн паркийг хөгжүүлэх болон барилга, байгууламжийг барих ажлыг паркийн батлагдсан ерөнхий төлөвлөгөө,

¹¹ <http://laws.66law.cn/law-130329.aspx>

зохицуулалтын нарийвчилсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, аж үйлдвэрийн паркт баригдах барилга, байгууламж болон хүрээлэн буй орчныг хамгаалах, газар ашиглах, төлөвлөлт, барилга, байгууламжийг ашиглалтад оруулах асуудлыг төслийг эхлүүлэхээс өмнө шийдвэрлэж дуусгасан байх, үйлдвэрлэлийн зориулалттай аж үйлдвэрийн паркийн газрын зориулалтыг өөрчлөх болон арилжааны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө болгох, аж үйлдвэрийн паркийн газар дээр аж үйлдвэрийн бус барилга байшин, зочид хүлээн авах байгууламж, сургалтын төвүүд байгуулахыг хатуу хориглох зэрэг асуудлыг тодорхой зааж өгсөн.

Тавдугаар бүлэгт: Аж ахуйн нэгж, эсхүл тодорхой төслүүд нь аж үйлдвэрийн үндсэн паркад нэгдэх хүсэлт гаргах журам, тавигдах шаардлага болон аж ахуй нэгж болон төслийн үйл ажиллагаа нь үндэсний аж үйлдвэрлэлийн бодлого, үйлдвэрлэл эрхлэлтийн стандартад нийцээгүй; аж ахуй нэгж болон төсөл нь хүрээлэн буй орчныг хамгаалах болон үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангаж ажиллагаагүй; аж ахуйн нэгж болон төсөл нь аж үйлдвэрийн паркийн төлөвлөлт, зохион байгуулалтыг хангаж ажиллаагүй зэрэг үндэслэлээр аж үйлдвэрийн үндсэн паркаас гаргах тухай харилцааг зохицуулсан.

Зургаадугаар бүлэгт: Аж үйлдвэрийн үндсэн парк болон муж, дүүргийн зүгээс үзүүлэх дэмжлэгийн талаарх зохицуулалт агуулдаг. Энэ бүлэгт аж үйлдвэрийн парк дахь аж ахуй нэгж, төслүүдэд эдлүүлэх бүх төрлийн хөнгөлөлтийн бодлогыг мужийн (дүүргийн) Ардын засгийн газрын холбогдох газруудтай хамтран аж үйлдвэрийн паркийн захиргааны хэлтсээс батлуулж, хэрэгжүүлэхээр заасан. Мөн аж үйлдвэрийн парк дахь шаардлага хангасан аж ахуй нэгжид санхүүгийн баталгааг нь харгалзан Мужийн (дүүргийн) Ардын засгийн газраас зээлийн батлан даалт гаргах, аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц, нийтийн үйлчилгээний байгууламжийг сайжруулахад байнгын дэмжлэг, баталгаа гаргах, Мужийн (дүүргийн) Ардын засгийн газар болон түүний холбогдох газрууд Аж үйлдвэрийн парк дахь аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалт, санхүү, харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ, тээвэр, цахилгаан хангамж, усан хангамж, зуучлагч зэрэг туслах үйлчилгээг нэвтрүүлэхэд тохиромжтой нөхцлийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан байна.

Долдугаар бүлэг нь: журамд дурдсан “төслүүд” гэдэгт шинэ барилга, өргөтгөл, нүүлгэн шилжүүлэлт, сэргээн босголт, технологийн өөрчлөлт зэрэг барилгын төслүүд байх тухай болон журмыг тайлбарлах эрх бүхий этгээд, журмыг мөрдөж эхлэх хугацааны тухай.

6.4 КАЗАХСТАН УЛС

Казахстан Улс хүнд үйлдвэрлэлийн тусгайлан хуульгүй бөгөөд Эдийн засгийн тусгай бүсүүдийн тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тодорхой төрлийг үйлдвэрлэх, эргэлтэд оруулах журмын тухай хууль, Хий, хийн хангамжийн тухай хууль, Цөмийн энерги ашиглах тухай зэрэг хуулиар хүнд үйлдвэрлэлтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

1.Казахстан Улсын Эдийн засгийн болон аж үйлдвэрийн тусгай бүсийн тухай хууль 2019 онд батлагдсан бөгөөд тус хуулиар тус улсын нутаг дэвсгэрт эдийн засаг, аж үйлдвэрийн тусгай бүс байгуулах, ажиллуулах, татан буулгахад үүсэх нийгмийн харилцааг зохицуулдаг.

Тус хуульд аж үйлдвэрийн бүс гэдгийг Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасны дагуу хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, түүний дотор аж үйлдвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбар, тээврийн ложистик, хог

хаягдлын менежментийн чиглэлээр тогтоосон журмаар бизнес эрхлэх зориулалттай инженерийн болон холбооны дэд бүтцээр хангагдсан нутаг дэвсгэрийг ойлгохоор заасан.

Эдийн засаг, аж үйлдвэрийн тусгай бүс байгуулах үндсэн зорилго нь орчин үеийн өндөр бүтээмжтэй, өрсөлдөх чадвартай аж үйлдвэрийг хөгжүүлэх, үйлчилгээ үзүүлэх чанарын шинэ түвшинг бий болгох, хөрөнгө оруулалт татах, шинэ технологиудыг үйлдвэр, бүс нутагт нэвтрүүлэх, түүнчлэн ажлын байрыг нэмэгдүүлэх, бүс нутгуудад аж үйлдвэр эрхлэх дэд бүтцийн хөгжлийг хангахад оршино.

Хуульд зааснаар Казакстан Улсад аж үйлдвэрийн бүсийг нийтийн болон хувийн гэж ангилах бөгөөд улсын аж үйлдвэрийн бүс нь 1) бүгд найрамдах улсын ач холбогдол бүхий аж үйлдвэрийн бүс; 2) бүс нутгийн ач холбогдол бүхий аж үйлдвэрийн бүс; 3) жижиг аж үйлдвэрийн бүс гэсэн 3 төрөлтэй. Харин хувийн аж үйлдвэрийн бүсийг хувь хүн, төрийн бус хуулийн этгээд байгуулахаар заасан. Эдгээр аж үйлдвэрийн бүс байгуулах журмыг хуулиар нарийвчлан зохицуулсан байх бөгөөд аж үйлдвэрийн бүс байгуулах, ажиллуулах хугацааг сунгах, татан буулгах үндэслэлтэй эсэхийг шалгадаг байнгын газар хоорондын зөвлөлдөх, зөвлөх байгууллага буюу шинжээчдийн зөвлөл ажилладаг.

Харин аж үйлдвэрийн бүс байгуулсан бол түүнийг удирдах компанийг байгуулан ажиллуулдаг онцлог зохицуулалт байна. Тухайлбал,

1) Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар - Бүгд найрамдах улсын ач холбогдол бүхий аж үйлдвэрийн бүсийн удирдах компанийг;

2) орон нутгийн гүйцэтгэх байгууллага - орон нутгийн ач холбогдол бүхий аж үйлдвэрийн бүсийн удирдах компанийг;

3) энэхүү хуулийн дагуу хувийн аж үйлдвэрийн бүсийн эзэмшигч нар тухайн аж үйлдвэрийн бүсийг удирдах компанийг тус тус үүсгэн байгуулдаг.

Орон нутгийн аж үйлдвэрийн бүсийн удирдах компанийг төрийн бус хуулийн этгээд болон гадаад улс оронд аж үйлдвэрийн бүсийг удирдах туршлагатай гадаадын хуулийн этгээдээр үүсгэн байгуулж болдог. Энэ тохиолдолд тус удирдах компанийн 25-с ихгүй хувийг төр эзэмшдэг байна.

Энэхүү аж үйлдвэрийн бүсийг удирдах компани нь аж үйлдвэрийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэл эрхлэгчдэд үл хөдлөх хөрөнгө түрээслэх, газар олгох, дэд бүтцийн байгууламжаар хангах; үйл ажиллагааны гэрээ байгуулах, цуцлах; дэд бүтцийн байгууламж барих, аж үйлдвэрийн бүсийн бусад төрлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгө оруулалт татах; аж үйлдвэрийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа этгээдэд шилжүүлээгүй газар дээр батлагдсан зураг төсөл, тооцооны баримт бичгийн дагуу дэд бүтцийн байгууламж барих; аж үйлдвэрийн бүсэд шинэ үйлдвэр байгуулах талаар маркетингийн судалгаа хийх; аж үйлдвэрийн бүсэд үйлдвэр, инновацийн болон хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг татах; бизнес төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, тооцоо, бусад төслийн баримт бичгийг боловсруулах үйлчилгээ үзүүлэх зэрэг чиг үүрэгтэй ажилладаг байна.

Аж үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэр байгуулах, ажиллуулах хувь хуулийн этгээд нь аж үйлдвэрийн бүсийн менежментийн компанитай үйл ажиллагааны гэрээ байгуулдаг.

Тус бүс нутагт үйлдвэр байгуулах, ажиллуулахад олгогддог хамгийн том дэмжлэг нь дулаан, цахилгаан, ус, хий, бохир ус, тээврийн харилцаа холбоо, харилцаа холбооны үйлчилгээ болон бусад үйлдвэрлэлийн бусад объект, дамжуулах байгууламжууд зэрэг дэд бүтцийг улсаас байгуулж өгдөг. Тухайлбал, хуулийн 27 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Аж үйлдвэрийн хувийн бүсийн хил хүртэл дэд бүтцийн байгууламж барих (сэргээн босгох) ажлыг санхүүжүүлэх ажлыг Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газраас тогтоосон журмаар явуулна.” гэж заасан байна.

Газрын тосны зарим төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эргэлтэд оруулах төрийн зохицуулалтын тухай хууль нь 2011 онд батлагдсан. Энэхүү хуулиар газрын тосны зарим төрлийн бүтээгдэхүүн буюу бензин, онгоцны болон дизель түлш, болон шингэн шатахууны үйлдвэрлэл эргэлтийн үед үүсэн гарч буй нийгмийн харилцааг зохицуулдаг. Нийт 26 зүйлтэй. Үүнд:

- 1 дүгээр зүйл.Нэр томьёоны тодорхойлолт;
- 2 дугаар зүйл.Газрын тосны зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эргэлтэд оруулах хууль тогтоомж;
- 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ;
- 4 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэх, эргэлтэд оруулах Төрийн оролцоо, зохицуулалт;
- 5 дугаар зүйл.Хуулийн зорилт;
- 6 дугаар зүйл.Бүгд Найрамдах Казахстан улсын Засгийн газрын бүрэн эрх;
- 7 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн эрх бүхий байгууллагын бүрэн эрх;
- 8 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний эргэлтийн хүрээнд оролцох эрх бүхий байгууллагын бүрэн эрх;
- 9 дүгээр зүйл.Засгийн газрын бусад эрх бүхий байгууллагуудын эрх хэмжээ;
- 10 дугаар зүйл.Нийслэл, орон нутгийн гүйцэтгэх байгууллагын эрх хэмжээ;
- 11 дүгээр зүйл.Төрөөс тавих хяналт;
- 12 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үүрэг;
- 13 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эргэлтийн хүрээнд аюулгүй байдлыг хангах шаардлагууд;
- 14 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний Төрийн үнийн зохицуулалт;
- 15 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн данс тооцоо;
- 16 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний эргэлтийг хүлээн зөвшөөрөх, дотоодын аудитын үр дүн;
- 17 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний бөөний нийлүүлэлттэй холбоотой газрын тосны бүтээгдэхүүний бөөний нийлүүлэгчдийн үйл ажиллагаа эхлэх, дуусгавар болох тухай мэдэгдэл;
- 18 дугаар зүйл.Түүхий нефть болон хийн конденсат, завсрын бүтээгдэхүүн, болон түлшний бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагаан дахь төрийн оролцоо, зохицуулалт;

19 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний эргэлтийн ерөнхий нөхцөл;

20 дугаар зүйл. Түүхий нефть, хийн конденсат, нефийн бүтээгдэхүүнийг төмөр зам, хурдны зам, тэнгис, дотоод ус болоон агаарын тээврийн хэрэгслээр тээвэрлэх нөхцөл;

21 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүнийг бөөнөөр худалдаалах нөхцөл;

22 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүнийг жижиглэнгээр худалдаалах нөхцөл;

23 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтад тавих хяналт, шинжилгээ;

24 дүгээр зүйл. Хаврын тариалангийн болон ургац хураалтын ажил, халаалтын улирлын дулаан хангамжийн компаниудын үед хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийг газрын тосны бүтээгдэхүүнээр хангахтай холбоотой газрын тосны бүтээгдэхүүний эргэлтийн төрийн зохицуулалтын онцлог шинж чанарууд;

25 дугаар зүйл. Бүгд Найрамдах Казахстан Улсын газрын тосны тодорхой төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эргэлтэд оруулах төрийн зохицуулалтын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага;

26 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох зохицуулалттай.

Энэхүү хуульд заанаар газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эргэлт дэх төрийн зохицуулалтын зорилго нь:

1) Хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүрээлэн буй орчныг хамгаалах;

2) Бүгд Найрамдах Казахстан Улсын эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнчлэн газрын тосны бүтээгдэхүүний хууль бус үйлдвэрлэл, эргэлтийг бий болгохгүй байх нөхцлийг бүрдүүлэх;

3) Бүгд Найрамдах Казахстан улсад олборлосон газрын тосны бүтээгдэхүүний чанарыг сайжруулах;

4) Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн шинэчлэл, хүчин чадлыг сайжруулахад оршино.

Хуулийн дээрх зорилтод нийцүүлэн газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хувьд Казахстан Улсын Засгийн газар өргөн эрх мэдэлтэй, хатуу хяналтын зохицуулалтыг хуулиар бий болгосон байна. Үүнд:

1. Бүгд Найрамдах Казахстан Улсын орон нутгийн зах зээлийн шаардлагыг хангах зорилгоор газрын хэвлий ашиглагчдаас Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд түүхий нефть ба (эсвэл) хийн конденсатыг нийлүүлэх хуваарийг баталгаажуулах;

2. газрын тос, завсрын бүтээгдэхүүнийг боловсруулах, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн төлөвлөгөөг батлах;

3. газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх нөхцөл, хязгаарлалтыг тогтоох;

4. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эргэлтийн хүрээнд техникийн зохицуулалт, стандартчилал хийх;

5. газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эргэлтэд оруулах чиглэлээр төрийн хяналтыг хэрэгжүүлэх;

6.төрийн үнийн зохицуулалтын дагуу гаргасан газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдааны үнийн хязгаарыг тогтоох,

7.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын хяналт тавих;

8.газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эргэлтийг зохицуулах, асуудлыг зохицуулах эрх бүхий гадаад улс, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, Бүгд Найрамдах Казахстан улсын газрын тосны үйлдвэрлэл, эргэлтийн зохицуулалтын талаарх олон улсын үүргийг биелүүлэх.

Түүнчлэн, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтад дараах чиглэлээр хяналт тавихаар заасан байна:

1.үйлдвэрлэсэн газрын тосны бүтээгдэхүүний төрлүүдийн хэмжээг хянах,

2.газрын тосны бүтээгдэхүүний борлуулалт, болон газрын тосны бүтээгдэхүүний экспорт, импортын хяналт;

3.үйлдвэрлэсэн газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдааны үнэд хяналт тавих;

4.Муж, бүгд найрамдах улсын ач холбогдол бүхий хот, нийслэлийн газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээнд хяналт тавих.

Хуульд зааснаар тус улсад эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үүднээс газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлийн эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу нийгмийн гол ач холбогдол бүхий, мөн Казахстан улсын эдийн засагт нэн чухал нөлөөтэй газрын тосны бүтээгдэхүүний жижиглэн худалдаалах үнийн төрийн зохицуулалт үйлчилдэг байна.

Мөн хуулиар одоо байгаа газрын тосны үйлдвэрлэгчдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэх, сэргээн босгоход чиглэсэн, тодорхой хугацааны туршид техник, эдийн засгийн үр ашиг олж авахын тулд газрын тосны бүтээгдэхүүний үнэд нөлөө үзүүлдэг хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүн болон эдийн засгийн засгийн индекст суурилсан газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хөрөнгө оруулалт, хөрөнгийг буцаан олгох хөтөлбөр байдаг. Тус хөтөлбөрийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч харилцах данс нээлгэх бөгөөд түүний хөрөнгийг хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор онцгой журмаар оруулах шаардлага тавигддаг. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг (хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүн хэсэг) тухайн үеийн болон дунд хугацааны зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийг тооцохдоо харгалзан үзэх зохицуулалттай байна. Энэ нь тус салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтыг хамгаалах буюу хөрөнгө оруулалтаа нөхөх боломжийг олгохын зэрэгцээ оруулсан хөрөнгө оруулалтад дансаар нь дамжуулан хяналт тавих зорилготой байна.

Манай улсын хувьд Казахстан Улсын хууль тогтоомжийн зохицуулалтаас хүнд үйлдвэрлэл, ялангуяа уул уурхайн салбарын хүнд үйлдвэрлэлд тавих хяналтын механизмыг авч хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

6.5. ЧИЛИ УЛС

Өнгөрсөн зууны турш Чили улс нь аж үйлдвэрийн хөгжлийн бодлогын хувьд хоорондоо зөрчилтэй, эсрэг тэсрэг 2 үеийг туулсан. 1938-1973 оны үеийн засгийн газрууд аж үйлдвэрийн бодлого боловсруулахад голлох байр суурьтай байсан ба аж үйлдвэрийн бодлогын олон арга хэрэгслүүдийг нэвтрүүлсэн. Импортыг орлох бүтээгдэхүүнийг дэмжин ган, эрчим хүч, цахилгаан холбоо, ашигт малтмал

олборлох, боловсруулах зэрэг голлох салбаруудад төрийн шууд хяналтыг хэрэгжүүлсэн. 1960-1971 онуудад Чилийн экспортын хамгийн чухал түүхий эд болох зэсийн салбарыг төрийн өмчид авах хөтөлбөрийг 2 удаагийн засгийн газар хэрэгжүүлсэн.

Энэ хугацаанд Чили улс аж үйлдвэрийн бодлогыг боловсруулах болон хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн банк-Banco Estado, хөгжлийн агентлаг-CORFO корпораци зэрэг хэд хэдэн байгууллагыг байгуулсан. CORFO корпораци нь улсын хөрөнгийг удирдах (зэсийн түрээс гэх мэт), дөнгөж бий болсон үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд техникийн тусламж үзүүлэх, технологийн шинэчлэлд урт хугацааны хөрөнгө оруулалт хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлсэн.

1973 онд төрийн өмч давамгайлсан эдийн засгаас худалдааг чөлөөлөх (либералчлах) бодлого явуулсан. Төрийн өмчид байсан ихэнх аж үйлдвэрийн болон санхүүгийн салбарыг хувьчилсан. Мөн ГШХО, зээлийн хяналтын болон тарифын бүх хязгаарлалтыг арилгасан. 1970-аад оны сүүлчээр худалдааг хамгаалах бодлогоос татгалзаж, 10 хувийн тарифын дэглэмд шилжсэн.

Чөлөөт зах зээлийн бодлогоос гадна тухайлсан салбаруудыг дэмжих бодлого барьсан боловч жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжүүлээгүй. Институцийн залгамж чанарыг маш сайн хадгалсны дүнд CORFO хөгжлийн үндсэн агентлаг хэвээр үлдэж инновацын шинэчлэлийг давхар хариуцах болсон. Fundacion Chile нь ТХХТ-ийн шинэ загвар болон гарч ирсэн.

Чилийн зэсийн үйлдвэрлэл нь улсдаа орлого авчирсан төдийгүй ашигт малтмалын ашгийн 3 хувийн татвараар технологи, инновацын институцыг санхүүжүүлэх замаар аж үйлдвэрийн салбарыг дэмжих бодлого хэрэгжүүлэх боломжийг олгосон.

Сүүлийн 40 жилийн хугацаанд зэс, хулд загас, дарс, мод, цаас зэрэг бүтээгдэхүүнийг “сонгон авч”, “бойжуулан” экспортын голлох бүтээгдэхүүн болгосон нь энэхүү бодлогын үр шим юм. Мөн энэ амжилт нь нам болон дунд технологийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс илүү хоол хүнс, ойн аж ахуй зэрэг анхдагч (primary sectors) салбарыг сонгон хөгжүүлсэнтэй холбоотой.

Төрийн өмч давамгайлсан, тодорхой салбарт чиглэсэн амжилттай бодлого хэрэгжүүлж байгаагийн нэг тод жишээ бол зэсийн үйлдвэр юм. Пиночетээс эхлэн неолиберал бодлогыг хэрэгжүүлсэн ч зэсийн үйлдвэрт чиглэсэн аж үйлдвэрийн бодлого өнгөрсөн зууны турш гайхалтай амжилттай үргэлжилсэн юм. Уул уурхайн салбарын бусад Латин Америкийн орнууд болох Перу, Боливи, Бразил зэрэг улс нь төрийн өмчийг хувьчлах, ГШХО-ыг хязгаарлах бодлогыг багасгах зэрэг неолиберал шинэчлэлийн олон аргыг хэрэгжүүлж байх үед Чилийн засгийн газар зэсийн салбарт төрөөс шууд оролцох шийдвэр гаргаж, КОДЕЛКО нэртэй ТӨҮГ байгуулсан. Чили уул уурхайн салбарт хувийн хэвшлийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх талаар уул уурхайн үйл ажиллагаанд ашиглах үйлдвэрлэлийн түүхий эд (завсрын бүтээгдэхүүн) импортлоход үзүүлэх татварын буцаан олголт, татварын төлбөрийг хойшлуулах гэх мэт олон арга хэмжээг хэрэгжүүлсэн хэдий ч 1980, 1990-ээд онд КОДЕЛКО төрийн эзэмшилд хэвээр үлдсэн.

КОДЕЛКО нь үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэх болон технологи, хөдөлмөрийн чадавхид тогтмол стратегийн хөрөнгө оруулалт хийдэг. Мөн жижиг, хувийн хэвшлийн инженерийн болон технологийн гарааны компаниудыг бойжуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэхүү үйлдвэрлэлийн бодлогын стратегийн үр дүнд КОДЕЛКО нь өнөөдөр ENAMI (National Mining

Corporation) компанитай хамтран Чилийн зэсийн үйлдвэрлэлийн гуравны нэг орчмыг эзэлдэг, дэлхийд тэргүүлэгч хэвээр байна.

Чили нь голдуу неолиберал эдийн засгийн амжилтын түүх гэж нэрлэгддэг бөгөөд "байгалийн" харьцангуй давуу талд үндэслэн хөгжсөн улс гэж үздэг.

6.6 ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Оросын Холбооны Улсын хүнд үйлдвэрийн салбарт Цахилгаан эрчим хүчний тухай, Газрын хэвлийн тухай, Үйлдвэрлэлийн бодлогын тухай зэрэг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд үүнээс Үйлдвэрлэлийн бодлогын тухай хууль нь үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд, тэдгээрийг дэмжих арга хэмжээний тухай болон төрийн байгууллагуудын эрх хэмжээ, үйлдвэрлэлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг байна. Үйлдвэрлэлийн бодлогын тухай хууль нь 5 бүлэг 23 зүйлтэй бөгөөд дараах агуулгатай байна:

Нэгдүгээр бүлэг. Уг бүлэгт хуулийн үйлчлэх хүрээ, үйлдвэрлэлийн бодлогын салбар дахь эрх зүйн зохицуулалт, нэр томьёоны тодорхойлолт, үйлдвэрлэлийн бодлогын зорилго, зорилт, зарчим, аж үйлдвэрийн бодлогыг боловсруулахад оролцогчид болон түүнийг хэрэгжүүлэгчдийн тухай ойлголт, ОХУ-ын Засгийн газар болон аж үйлдвэрийн салбарын бодлогын асуудал хариуцсан холбооны гүйцэтгэх төрийн эрх бүхий байгууллагууд болон аж үйлдвэрийн бодлогын бүс нутаг дахь ОХУ-ын бүрэлдэхүүн хэсгийн гүйцэтгэх эрх бүхий байгууллага, аж үйлдвэрийн бодлогын бүс нутгийн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын бүрэн эрхийг тусгасан.

Хоёрдугаар бүлэг. Энэ бүлэгт үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээг тусгасан. Хуульд зааснаар аж үйлдвэрийн салбар дахь үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ санхүү, мэдээлэл, зөвлөх үйлчилгээний дэмжлэг, үйлдвэрлэлийн салбарт шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа явуулах этгээдүүдэд үзүүлэх ажилчдын чадавхын дэмжлэг, төрийн болон орон нутгийн байгууллагуудаас давуу эрх олгох арга хэмжээ болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан дэмжих арга хэмжээ тус тус багтдаг байна. Түүнчлэн, үйлдвэрлэлийн салбарын онцлог шинж чанарыг харгалзан тухайн салбарыг дэмжих арга хэмжээ авах харилцааг нь холбооны тусгайлан хуулиар зохицуулж болохыг заасан.

Мөн энэхүү бүлэгт Улсын аж үйлдвэрийн хөгжлийн сан байгуулах, түүнийг захиран зарцуулахтай холбоотой харилцааг нарийвчлан тусгасан байна. Улсын аж үйлдвэрийн хөгжлийн сан нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсэгт хамаарах ашгийн бус байгууллага байна.

Улсын аж үйлдвэрийн хөгжлийн сан нь нь үйлдвэрлэлийн салбарын субъектууд гэж нэрлэгдсэн ОХУ-ын нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчид ОХУ-ын хууль тогтоомжид нийцсэн аливаа хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд үүнд зээл, буцалтгүй тусламж, дүрмийн санд оруулах хөрөнгө, санхүүгийн түрээс (лизинг) зэрэг багтдаг байна.

Түүнчлэн уг бүлгийн нэг дэх дэд хэсэгт Тусгай хөрөнгө оруулалтын гэрээний тухай харилцааг тусгасан ба тусгай хөрөнгө оруулалтын гэрээний зүйл, талууд, гэрээний агуулга, тусгай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах, дуусгавар болох журмыг заасан.

Тусгай хөрөнгө оруулалтын гэрээ нь Тусгай хөрөнгө оруулалтын гэрээний дагуу ОХУ-ийн нутаг дэвсгэрт, эсхүл ОХУ-ийн эх газарт хамаарах нутаг дэвсгэр болон ОХУ-ийн эдийн засгийн онцгой бүсэд ОХУ-ийн Засгийн газраас баталсан орчин үеийн технологийн жагсаалтад багтсан үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглагдах бөгөөд дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, өндөр технологи нэвтрүүлэх боломжийг олгодог байна.

Тусгай хөрөнгө оруулалтын гэрээний дагуу ОХУ ба ОХУ-ийн бүс нутгийн болон орон нутгийн захиргаа хамтран гэрээний хугацаанд хөрөнгө оруулагчийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтвортой нөхцөлийг хангах, мөн аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг байна.

Гуравдугаар бүлэг.Энэ бүлэгт үйлдвэрлэлийн бүс нутгийн хөгжлийн асуудлын товч зохицуулсан байх ба ОХУ-д аж үйлдвэрийн парк, аж үйлдвэрийн технопарк гэсэн 2 тусдаа ойлголт байна. Эдгээр ойлголтын ялгаа заагийг нарийвчлан зохицуулаагүй боловч Аж үйлдвэрийн парк болон түүнийг удирдах компани нь Засгийн газраас тогтоосон шаардлагад нийцсэн тохиолдолд тэдэнд ОХУ-ын хууль тогтоомжид заасан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ авдаг бол Аж үйлдвэрийн технопаркын хувьд технопаркын бүтцэд хамаарах технологийн дэд бүтцийн объектыг ашиглаж буй үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг субъект болон технопаркын менежментийн компанид гагцхүү ОХУ-ын Засгийн газраас тогтоосон шаардлагад нийцсэн тохиолдолд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасан байна.

Мөн аж үйлдвэрийн парк болон технопаркыг ОХУ-ын мужуудад шинээр байгуулах, одоо байгааг нь хөгжүүлэх ажлыг ОХУ-ын орон зайн хөгжлийн стратеги, ОХУ-ын нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн схем, ОХУ-ын мужуудын төлөвлөлтийн схемийг тус тус харгалзан хийж гүйцэтгэхээр хуульчилсан байна.

Дөрөвдүгээр бүлэгт ОХУ-ын Зэвсэгт хүчний салбарын үйлдвэрлэлийн онцлогийг зохицуулсан бол **Тавдугаар бүлэгт** хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны тухай заасан байна.

ОХУ-ын Үйлдвэрлэлийн бодлогын тухай хууль нь Монгол Улсын хууль тогтоомжийн агуулга, бүтэцтэй ойролцоо, зохицуулалтын хувьд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлтэй байх тул Хүнд үйлдвэрийн тухай хууль боловсруулахдаа загвар болгон ашиглаж болохоор байдаг.

6.7 АВСТРАЛИ УЛС

Австралийн Холбооны Улс нь 6 мужаас бүрддэг засаг захиргааны хувьд холбооны муж улс бөгөөд Холбооны нэгдсэн хууль тогтоомжууд үйлчилдэг.

Хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүнд дараах нийтлэг зүйлсийг хамруулдаг:

Үйлдвэрийн барилга;

Цахилгааны дэд бүтцийн бүтээн байгуулалт;

Цахилгаан холбооны дэд бүтцийн бүтээн байгуулалт;

Ус, ариутгах татуургын дэд бүтцийн барилга угсралтын ажил;

Тээврийн дэд бүтцийн бүтээн байгуулалт зэрэг

Уурын зуух, зуух, зуухны барилгын ажил;

Машин угсралт;

Төмөр замын барилга;

Амралт зугаалгын дэд бүтцийн барилга байгууламж зэрэг

Холбооны нэгдсэн хууль тогтоомжоос гадна мужуудад үйлчилдэг хууль тогтоомжууд байдаг. Үүнд:

1.Аж үйлдвэр ба технологийн хөгжлийн тухай хууль. /1998 он, Баруун Австрали муж/

Энэхүү хууль нь мужийн аж үйлдвэр, худалдаа, шинжлэх ухаан, технологи болон судалгааг урамшуулах, сурталчлах, хөнгөвчлөх, Баруун Австрали мужийн технологийн болон аж үйлдвэрийн зөвлөх Зөвлөлийн байнгын ажиллагааг хангах зорилготой. 6 бүлэгтэй:

- Удиртгал
- Сайдын эрх, үүрэг
- Санхүүгийн дэмжлэг
- Ажилтан
- Аж үйлдвэрийн зөвлөх зөвлөл
- Бусад

2.Аж үйлдвэрийн харилцааны тухай хууль /1996 он, Шинэ Өмнөд Уэльс муж/

Энэ хуулиар аж үйлдвэр эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан. 7 бүлэгтэй:

- Удиртгал. Хууль тогтоомжийн хамрах хүрээ, нэр томъёоны тодорхойлолтыг хамруулсан.
- Ажил эрхлэлт. Хөдөлмөр эрхлэлтийг хамгаалах болон хамтын хэлэлцээртэй холбоотой харилцааг зохицуулсан.
- Хөдөлмөрийн маргаан. Үйлдвэрлэл эрхлэлттэй холбоотой маргааныг хэрхэн шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан.
- Үйлдвэрлэлийн харилцаа. Үйлдвэрлэлийн харилцааг зохицуулах комиссын чиг үүргийг зохицуулсан.
- Аж үйлдвэрийн байгууллагууд. Аж үйлдвэрт хамаарах байгууллагуудын эрх, үүргийг зохицуулсан.
- Нийтийн болон ачаа тээврийн хэрэгсэл. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн тээвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан.
- Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

6.8. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

ХБНГУ нь дэлхийд үйлдвэрлэлээрээ тэргүүлэх улс орнуудын нэг бөгөөд Герман улс аж үйлдвэрийн салбарт төрийн оролцоог багасгасан бөгөөд Засгийн газрын зүгээс аж үйлдвэрлэлийн бодлого, стратегийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшил, бизнес эрхлэгчид болон үйлдвэрчний эвлэлийн

холбоодын санал санаачилгыг дэмжиж, тэдэнд үйлдвэрлэл эрхлэх боломжийг нь олгодог байна.

Тус улсад үйлдвэрлэлийг цогцолбор, паркийн хэлбэрээр хөгжүүлэх бодлогыг баримталдаг боловч нэг талаас тэдэнд эдийн засгийн болон эрх зүйн тусгай нөхцөл олгоогүй, нөгөө талаас тэдгээр нь чөлөөт зах зээлийн зарчмаар ажиллаж буй хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн хэлбэртэй байгаа нь эрх зүйн тухайлсан орчин үүсэх хэрэгцээ шаардлагыг үгүйсгэж байна. Иймээс үйлдвэрлэлийн цогцолборын үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг холбогдох салбарын хууль тогтоомжуудаараа зохицуулаад явдаг.

Харин аж үйлдвэрийн бодлогын хүрээнд төрөөс зохих дэмжлэгийг үзүүлдэг байна. Аж үйлдвэрийн эрх зүй орчин дахь нэг анхааран авч үзэх асуудал нь байгаль орчин, хүрээлэн буй орчинд үзүүлэх хортой нөлөөллөөс хамгаалах, хог хаягдлыг зайлуулах, хоргүйжүүлэх, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтуудын онцлог юм. Энэ талаарх ХБНГУ-ын хууль тогтоомжийн зохицуулалтууд, стандартууд нь нягт сайн юм.

ХБНГУ-ын үйлдвэрлэлийн төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтын дараах сайн туршлагууд байна. Үүнд:

- Байгаль орчин, хүрээлэн буй орчныг хамгаалах, хог хаягдлыг боловсруулах, зайлуулах эрх зүйн зохицуулалт, стандартууд.
- Судалгаа хөгжлийн талаар баримталж буй төрийн бодлого, зохицуулалтыг нь нарийвчлан судалж, авч хэрэгжүүлэх.
- Үйлдвэрлэлийг цогцолбор, паркийн хэлбэрээр ажиллуулах нөхцөлийг үндсэнд нь хувийн хэвшлийн мэдэлд үлдээж, чөлөөт өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллуулж, төрөөс гагцхүү үйл ажиллагааны хүрээ хязгаар, нөхцөл боломжийг нь хууль тогтоомжийн зохицуулалтаар бүрдүүлж буй хандлагыг авч үзэх.
- Инновацийг хөгжүүлэх, инноваци бүхий аж ахуйн нэгжүүдийг үүсгэн байгуулах эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, өсөлт хөгжилтөд үзүүлж буй төрийн дэмжлэгийн арга, хэлбэрээс суралцах.

6.9. ЭНЭТХЭГ УЛС

Энэтхэг улс нь засаг захиргааны зохион байгуулалтын хувьд холбооны улсын зохион байгуулалттай бөгөөд 8 бүс нутаг, 28 мужтай тул нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжоос гадна тухайн газар нутгийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжуудыг муж тус бүрийн захирагч нар батлан хэрэгжүүлдэг байна.

Тус улсад хүнд үйлдвэрийн тухай бие даасан тусгайлан зохицуулсан хууль байдаггүй харин Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуультай.

Энэтхэг улсад Эдийн засгийн тусгай бүсийн тухай актад заасны дагуу Эдийн засгийн тусгай бүсийн тодорхой болон нэмэлт урамшууллыг Засгийн газраас батлахаар тусгасан байдаг. Төв Засгийн газрын урамшуулалд дараах урамшуулал багтдаг. Үүнд:

- Холбооны болон мужийн Засгийн газар, хувийн хэвшил эсвэл төр, хувийн хэвшлийн хамтарсан түншлэлээс эдийн засгийн тусгай бүсийг хөгжүүлэх;

- Эдийн засгийн тусгай бүс нь Энэтхэг улсын нутаг дэвсгэрээс гадуурх гаалийн нутаг дэвсгэрт тооцогддог учраас эдийн засгийн тусгай бүс нь барааны гаалийн шалгалтаас чөлөөлөгдөх;
- Орлогын албан татвараас 10 хүртэл жилийн хугацаанд чөлөөлөх;
- Онцгой албан татвар, гаалийн татвар, импортын татвар, цалингийн татвар, улсын тэмдэгтийн хураамж, үнэт цаасны шилжүүлгийн татвар, борлуултын татвар зэргээс чөлөөлөх;
- 5 хүртэлх жилийн хугацаанд Ажиллагсдыг хүн амын орлогын албан татвараас чөлөөлөх;
- Үйлчилгээний татвар, ногдол ашиг хуваарилалтын албан татвар болон эд хөрөнгийн шилжүүлгийн ашгийн татварыг бууруулах;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийг бууруулах

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

XVII зууны эхэн үеэс Их Британид аж үйлдвэрийн хувьсгал өрнөж, 100 жилийн хугацаанд дэлхийн аж үйлдвэрлэлд манлайлан, тухайн үеийн дэлхийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 25 хүртэл хувийг дангаар үйлдвэрлэж байжээ.

АНУ болон Европын бусад орнууд Их Британийн аж үйлдвэрийн салбартай өрсөлдөхийн тулд эдийн засгийн “Хөгжлийн Стандарт Загвар”-ыг анхлан авч хэрэгжүүлжээ. “Хөгжлийн Стандарт Загвар” нь хүнд үйлдвэрийн салбарыг төрийн бодлогоор дэмжих замаар аж үйлдвэрийн бусад салбар хөгжих суурь баазыг бүрдүүлдэг хөгжлийн стратеги юм.

Хөгжлийн энэ загварыг бүрэн хэрэгжүүлж чадсанаар АНУ болон Европын бусад улсууд дэлхийн тэргүүний хөгжилтэй улс болон бусдаасаа тасарч өнөөдрийг хүртэл тэргүүлсэн хэвээр байна.

1850-аад оны сүүлээс эхлэн ОХУ, Япон зэрэг улсууд дээрх загварыг өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлж эхэлсэн байна.

XX зуунд дэлхийн II дайны дараа Япон, Өмнөд Солонгос, Тайван зэрэг өнөө цагийн “Азийн Бар” орнууд хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх төрөлжсөн хуулиуд баталсан бөгөөд эдгээр орны төр, засгийн зүгээс хөгжлийн “Хүчтэй түлхэх загвар”-ыг хэрэгжүүлж, хэд хэдэн томоохон секторуудад зохицуулалттай, чиглэсэн хөрөнгө оруулалт хийж, аж үйлдвэрийн салбарт их үсрэлт хийжээ.

Хөгжлийн стандарт загвар	Хүчтэй түлхэх загвар
Дотоодын аж үйлдвэрийг татвар, тарифын бодлогоор хамгаалах; Үндэсний банкуудыг хөгжүүлэн мөнгөний бодлогыг тогтвортой байлгах, том төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх; Төмөр замын сүлжээ, бусад дэд бүтцийг хөгжүүлэх замаар үндэсний хэмжээний зах зээлийг бий болгох; Бүх нийтийн боловсролыг дэмжих замаар ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх.	Хүнд үйлдвэрийн үндсэн секторуудад зохицуулалттай, чиглэсэн хөрөнгө оруулалт, дэмжлэг үзүүлэх эдийн засгийн хөгжлийн стратеги.

Солонгос, Тайвань, Сингапур, БНХАУ зэрэг орнууд Япон улсын туршлагаас суралцах замаар Хүчтэй түлхэх загварыг эрчимтэй хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр орнуудын туршлагыг “Галуун цуваа”-ны бодлого гэж нэрлэдэг. Эдгээр орнууд дараах үзэл баримтлалын дагуу хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж ирсэн байна.

Нэгдүгээрт, хүнд үйлдвэр хөгжүүлэхийн тулд дотоодын зах зээлээ хамгаалах протекционист бодлогыг хүнд үйлдвэрийн хөгжлийн эхний шатанд баримталж байсан.

Хоёрдугаарт, эдийн засгийн хөгжлийн эхний шатанд харьцангуй давуу талдаа дулдуйдахаас зайлсхийж, шинжлэх ухаанд тулгуурласан шинэ давуу талтай болох чиглэлд анхаарч, нэмүү өртөг шингээх боловсруулах салбарт төвлөрч байжээ. Тухайлбал, Япон, Солонгос Тайвань зэрэг орнууд экспортын баримжаатай боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлого баримталж ирсэн байна.

Гуравдугаарт, Аж үйлдвэржсэн орнууд хөгжлийн эхний үедээ хүнд үйлдвэр хөгжүүлэх зорилгоор төрөөс санхүү болон техник, технологийн дэмжлэг үзүүлэх бодлого баримталж иржээ.

XVII зуунд Англид өрнөсөн аж үйлдвэрийн хувьсгалаас XXI зууны Узбекистан улсын машин үйлдвэрлэл хүртэлх хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх бодлогын тулгуур зарчмуудыг дараах байдлаар тоймлон хураангуйлж болно. Тухайлбал:

- шинэ үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ил, далд хэлбэрээр тарифын болон худалдааны хязгаарлалтын арга хэрэглэх. Жишээ нь: зорилтот болон тухайлсан импортын бараанд онцгой албан татвар ногдуулах, эсхүл ил, далд хэлбэрээр тооны хязгаарлалт тогтоох;
- төрөөс зээлийн батлан даалт гаргах;
- экспорт, хөрөнгө оруулалт, судалгаа шинжилгээний ажил, менежер ба ажилтнуудад зориулсан сургалт явуулах зэрэг бүтээмж нэмэгдүүлэхэд чиглэгдсэн аливаа арга хэмжээнд татварын хөнгөлөлт эдлүүлэх;
- хүнд үйлдвэрийн салбаруудыг уялдуулах, төрөлжсөн картел байгуулахыг зөвшөөрөх, төрийн оролцоотой компанийг нэгтгэх, худалдан авах;
- гадаадын хамтарсан үйлдвэр байгуулах, технологи дамжуулах, R&D судалгааны төв байгуулах;
- төр-хувийн хэвшлийн хамтарсан компани байгуулах хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх;
- стратегийн үйлдвэрүүдийг хөл дээрээ тогтоход туслах зорилгоор төрийн өмчийн худалдан авах ажиллагаанд онцгой эрх олгох;
- дэд бүтэц, техникийн туслалцаа, мэдээллийн үйлчилгээ, экспортын маркетинг зэрэг үйлдвэрлэгчид өөрөө бий болгох боломжгүй бусад бүтээмжийг дээшлүүлэх чиг үүрэгтэй төрийн байгууллага байгуулах;
- эрсдэлээ хуваалцах, мэдээлэл солилцох, компаниуд нэг нэгнээсээ харилцан суралцахад нь туслах зорилгоор аж үйлдвэрийн кластерууд, хувийн хэвшлийн хамтарсан үйлдвэр, аж үйлдвэрийн холбоо, хоршоонуудыг дэмжих;
- технологи шингээх, инновацыг дэмжихийн тулд патентын хууль болон бусад оюуны өмчийн хуулиудыг батлахаас түр түдгэлзэх зэрэг арга хэмжээг өргөн ашиглаж байжээ.

Зүүн өмнөд Азийн “Галуун цуваа” туршлагаар хөгжсөн орнуудаас Өмнөд Солонгос улс нь хамгийн богино хугацаанд буюу 19 жилийн дотор хүнд үйлдвэр өндөр хөгжсөн орны нэг болсон юм.

Хуулийн төслийн тандан судалгаанаас харахад тус салбарт нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний экспортын хэмжээ маш бага, үйлдвэрлэлийн технологи хоцрогдсон, төрийн дэмжлэг, зохицуулалт, хяналт хангалтгүй, төрийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалт сул, хүнд үйлдвэрлэл хөгжих боломж, нөхцөл хязгаарлагдмал байгаа нь эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйтэй холбоотой гэж үзэж байна.

Түүнчлэн төрийн зүгээс аж үйлдвэрийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх чиглэл баримталж буй хэдий ч хүнд үйлдвэр хөгжих угтвар нөхцөлийг бүрдүүлээгүй, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нь томоохон дэд бүтцийн асуудлыг бие даан шийдвэрлэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулах санхүүгийн нөөц боломж, туршлага хангалтгүй, хүний нөөц дутмаг байгаагаас хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь жижиг, дунд үйлдвэрийн ангилалд хамаарч байна.

Иймээс Монгол Улс хүнд үйлдвэрийн эрчимтэй хөгжлийг хангах зорилгоор хүнд үйлдвэрийн салбаруудыг оновчтой тодорхойлж, тэдгээрийн төрийн нэгдсэн бодлогоор дэмжих харилцааг зохицуулах замаар тус салбарыг хөгжүүлэх угтвар нөхцөл, эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн хүнд үйлдвэрийн тухай хуулийг батлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 3. ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ тус хуулийн төсөлд тусгагдахгүй.
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ тус хуулийн төсөлд тусгагдахгүй.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийн салбарын хууль, эрхзүйн зохицуулалтын хамрах хүрээг дараах байдлаар томъёолсон. Үүнд: - УУХҮЯ болон АМГТГ; - Салбарын яамд, орон нутгийн иргэд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, уул

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	тодорхойлсон эсэх			уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй судалгааны байгууллагууд, салбарын экспертүүд, мэргэжлийн холбоод; - Төрийн өмчит уул уурхайн компаниуд, хувийн компани болон ТББ-уудын төлөөлөл зэрэг бусад оролцогч талууд
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалт ыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах Монгол Улсын Үндсэн хуульд заасан нөхцөл хангагдаж иргэн болон хуулийн этгээдийн аж ахуй эрхлэх эрх зүйн орчин сайжирч, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр төсвийн орлого нэмэгдэж, зорилтод бүлэгт хүрэх хүртээмж нэмэгдэнэ.
	1.3.2.Зохицуулалт ын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Нийцнэ.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Тус хуулийг зөрчигчдөд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээхээр тусгасан. Дагалдан гарах хуулийн төсөлд тусгана.
2.Хүний эрхийг	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг	Тийм	<u>Үгүй</u>	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх			
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
3.Эрх агуулагч[8]	3.1.Зохицуулалт ын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	<u>Тийм</u>	Үгүй	•Төр •Хуулийн этгээд гэсэн бүлгүүдийн эрх үүрэг тодорхойлогдоно.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Дэмжлэг үзүүлэх зохицуулалтууд тусгагдах тул эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлоогүй.
	3.3.Зохицуулалты н хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Эмзэг байдлаар ялгаагүй тул энэ асуудал тусгагдахгүй.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	<u>Үгүй</u>	Хуулийн этгээдэд хамаарах зохицуулалтууд тусгагдах тул эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгахгүй.
4.Үүрэг хүлээгч[9]	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төр, хуулийн этгээд үүрэг хүлээнэ.

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Нийтийн эрх ашгийг хамаарсан асуудал тусгагдана.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хөндөж буй асуудал нь жендэрийн асуудлыг хөндөхгүй нийтэд тэгш эрх, боломжийг бүрдүүлсэн.

Хүснэгт 4: ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Импортыг орлох болон экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, хүнд үйлдвэрийн салбарыг дэмжсэн чиглэл баримтлах тул өрсөлдөөнд нөлөө үзүүлэх боломжтой.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тул гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэнэ.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төрөөс хүнд үйлдвэрлэлийг дэмжих үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулах тул тодорхой хэмжээгээр дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналт зэрэг таагүй нөлөөллөөс Монголын зах зээлийг хамгаалах боломжтой.
	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Бүтээгдэхүүний төрөл нэмэгдэх тул шийдвэр гаргах боломж нэмэгдэнэ.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл,	Тийм	<u>Үгүй</u>	Хүнд үйлдвэрийн салбарт дөнгөж бий болсон шинэ үйлдвэрүүдийг дэмжих асуудал тусгагдах тул

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	хүндрэл бий болгох эсэх			бэрхшээл, хүндрэлийн асуудал багасна.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Тусгай зөвшөөрөл олгох болон бүртгэл, мэдээллийн тогтолцоо шинэчлэгдэх тул эдгээртэй холбоотой зардал нэмэгдэх боломжтой.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төрөөс хүнд үйлдвэрлэлийн салбарт санхүүгийн баталгаа гаргах, хөрөнгө оруулах зэргээр дэмжсэн зохицуулалтууд тусгагдана.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Дотоодын үйлдвэрлэлийг төрийн худалдан авалтад тэргүүн ээлжид дэмжих зохицуулалт тусгагдах тул төрийн байгууллагуудад худалдан авалтын сонголт хязгаарлагдана.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Импортын тарифаар зохицуулагдах тул импортын бараа бүтээгдэхүүний хэмжээ багасна.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Ямар нэгэн хязгаарласан зохицуулалт байхгүй учир сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Байхгүй.

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Мэдээлэл, тайлан байхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Тийм зохицуулалт байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Байхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Байхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Аж үйлдвэрийн парк, Шинжлэх ухаан технологийн парк байгуулах, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжин, таатай нөхцөл бүрдүүлнэ.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг төрөөс санхүү, татварын бодлогоор дэмжих асуудал тусгагдана.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Бусад үйлдвэрлэлийн түүхий эд болох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих тул

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

				хэрэглээний үнийн түвшинд эерэгээр нөлөөлнө.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Бусад үйлдвэрлэлийн түүхий эд болох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих тул дотоодын зах зээлийг ашиглах боломж илүү нээгдэнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Бусад үйлдвэрлэлийн түүхий эд болох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих тул импортын бүтээгдэхүүний үнэ буурах замаар хэрэглэгчдийн эрх ашигт эерэгээр нөлөөлнө.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Бусад үйлдвэрлэлийн түүхий эд болох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих тул импортын хамааралтай байдал багасаж эдийн засаг төрөлжсөнөөр ажлын байр нэмэгдэх, бараа бүтээгдэхүүний үнэ буурах зэргээр хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) эерэгээр нөлөөлнө.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрлэлийн салбарыг кластераар хөгжүүлэх тул тодорхой бүс нутагт, тодорхой нэг чиглэлд ажлын байрыг нэмэгдүүлнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Тодорхой бүс нутгаар ялгаварласан зохицуулалт байхгүй. Хүнд үйлдвэрийн салбарын ажлын байр нэмэгдэнэ.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийн салбар, түүнийг дагасан бүх

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх			салбаруудад эерэг нөлөө үзүүлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төрөөс хүнд үйлдвэрийн салбарыг санхүү, төсвийн бодлогоор дэмжих тул улсын төсвөөс эхний үеүдэд зардал гарна. Хүнд үйлдвэрийн салбар хөгжсөнөөр улсын төсөв нэмэгдэж, эдийн засаг төрөлжинө.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Бусад орны сайн туршлагаас үзэхэд Аж үйлдвэрийн салбарыг хариуцсан яам, агентлаг байгуулах замаар тухайн салбарыг дэмжих бодлого хэрэгжүүлсэн байх тул төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Одоо байгаа төрийн байгууллагад хүнд үйлдвэрийн бодлого, санхүүжилтийг хариуцсан захиргааны чиг үүргийг хуулиар тодотгох учир шинэ чиг үүрэг нэмэгдэхгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Эдийн засаг төрөлжиж урт хугацааны, тогтвортой эдийн засаг бий болж, ажил эрхлэлт нэмэгдэнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийн салбар дах хөрөнгө оруулалтыг дэмжсэн зохицуулалт тусгагдсанаар эдийн засгийн хөгжил тогтворжино.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Гадаадын шууд хөрөнгө оруулалт, импорт буурч инфляци буурна.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэх	<u>Тийм</u>	Үгүй	Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцнэ.

Хүснэгт 5: НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийг хөгжүүлснээр ажлын байр нэмэгдэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болохгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтнүүд ажлын байраар хангагдаж, мэргэжил боловсролоо нэмэгдүүлэх нөхцөл бүрэлдэнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Ажлын байр нэмэгдэх тул хөдөлмөрлөх насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдал нэмэгдэнэ.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийн салбарын ажлын чанар, стандарт олон улсын жишигт нийцэх шаардлагууд бий болно.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийн салбарт ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагыг бусад хуулиар олон улсын түвшинд зохицуулна.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Үгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийн онцлог, хөгжлөөс хамааралтай шинээр ажлын стандарт гарах боломжтой.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийн онцлог, хөгжлөөс хамааралтай ажлын байранд технологийн

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх			шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болох боломжтой.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй. Хувь хүнд чиглэсэн зохицуулалт байхгүй тул нөлөөлөхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй. Хувь хүнд чиглэсэн зохицуулалт байхгүй тул нөлөөлөхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй. Хувь хүнд чиглэсэн зохицуулалт байхгүй тул нөлөөлөхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Салбарын төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны хүрээнд олон нийт, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа /public private partnership/-г дэмжсэн бүтэц бий болгох
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төрийн байгууллагуудад орон тоог нэмэгдүүлэх, зарим чиг үүргийг өөр байгууллагад шилжүүлэх, мэргэжлийн албан тушаалд тохирсон мэргэжлийн боловсон хүчнийг ажиллуулахыг шаардах зэргээр нөлөөлж болно.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх боломжтой.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа	<u>Тийм</u>	Үгүй	Иргэд эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрх нээлттэй.

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх			
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Намуудын мөрийн хөтөлбөрийг хүнд үйлдвэрийн салбарын төлөвлөгөөтэй уялдуулах, хэрэгжилтийг дэмжиж ажиллахыг шаардах боломжтой.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Тодорхой бүс нутагт хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлснээр хүн амын хэт төвлөрлийг сааруулснаар агаар, орчны бохирдол буурч хүн амын дундаж наслалт, эрүүл мэнд зэрэгт эерэг нөлөө үзүүлнэ. /дам нөлөөллөөр/
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрлэл хөгжсөнөөр агаар, ус, хөрсний чанарт нөлөөлөх магадлалтай. Зохистой зай харьцааг бий болгох, норм дүрмийг мөрдүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дуу чимээний физик бохирдлыг бууруулах боломжтой.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Нийгмийн үйлчилгээний орон зай цар хүрээг нэмэгдүүлэх бодлогыг дэмжих, төлөвлөлтийн үйл ажиллагаагаар дамжуулан шийдэх боломжтой.
	6.2.Ажилчдын боловсрол,	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрлэлийн салбарын ажилчдыг

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх			мэргэшүүлэх, давтан сургах асуудлыг дэмжинэ.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрлэлийн салбарын ажилчдыг мэргэшүүлэх, давтан сургах асуудлыг дэмжинэ.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрлэлийн чиглэлийн инженерийн мэргэжлээр ажилчдыг бэлтгэх, давтан сургах асуудлыг дэмжих тул их, дээд сургуулиудын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй.

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	нөлөө үзүүлэх эсэх			
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Сөрөг нөлөө байхгүй.

Хүснэгт 6: БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Байгаль орчны багц хуулиуд, холбогдох стандарт, журмыг тухайн үйлдвэрлэлтэй холбоотой тавигдах шаардлагыг баримтлан ажиллахыг шаардана.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Үйлдвэрийн түүхий эд тээвэрлэлттэй холбоотой түлшний хэрэглээ нэмэгдэнэ. Гэхдээ газрын тосны салбарт хүнд үйлдвэрийг хөгжүүлснээр түлшний хэрэглээний нэг улсаас хараат байдлыг бууруулна.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрийн салбарыг дэмжих, дэд бүтэцжүүлэхтэй холбоотойгоор эрчим хүчний хэрэглээ нэмэгдэнэ.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Эрчим хүчний эрэлт өссөнтэй холбоотойгоор үйлдвэрлэл нэмэгдэнэ.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэрлэлийн түүхий эд болон бүтээгдэхүүн тээвэрлэлттэй холбоотой тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр, төдий хэмжээгээр агаарын бохирдол нэмэгдэнэ.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Үйлдвэрлэлийн бүс байгуулахтай холбоотой ан амьтдын нүүдэл, суурьшилд нөлөөлөх

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

				боломжтой. Төслийн хэмжээнд БОНБУ-ээр сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах асуудлыг шийдвэрлэх боломжтой.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Үйлдвэрлэлийн бүс байгуулахтай холбоотой тухайн бүсэд ан амьтдын нүүдэл, суурьшилд нөлөөлөх боломжтой. Төслийн хэмжээнд БОНБУ-ээр сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах асуудлыг шийдвэрлэх боломжтой.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Үйлдвэрлэлийн бүс байгуулахтай холбоотой ан амьтдын нүүдэл, суурьшилд нөлөөлөх боломжтой. Төслийн хэмжээнд БОНБУ-ээр сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах асуудлыг шийдвэрлэх боломжтой.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Тусгай хамгаалалттай газар нутагт хүнд үйлдвэр байгуулахыг хориглодог тул сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Үйлдвэрлэлийн бүс байгуулахтай холбоотой газрын дээрх болон гүний ус, цэвэр усны нөөцөд тодорхой хэмжээгээр нөлөөлнө. Иймээс төслийн хэмжээнд усны тухай хуулиар хайгуул болон ашиглалтын судалгаа хийж усны нөөцийг

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

				хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг баримталж ажиллана.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Үйлдвэрлэлийн бүс байгуулахтай холбоотой нөлөөлөх боломжтой. Төслийн хэмжээнд БОНБУ-ээр сөрөг нөлөөнөөс сэргийлэх, бууруулах асуудлыг шийдвэрлэх боломжтой. Усны бохирдлыг бууруулах, үйлдвэрийн хаягдал усыг дахин ашиглах зохицуулалт хийгдэнэ.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Усны тухай хуулиар ундны усны хэрэглээ хангагдсаны дараа бусад хэрэглээ тавигддаг тул ундны усанд нөлөөлөхгүй гэж үзэж болно. Харин үйлдвэрийн хаягдал усыг дахин ашиглах зохицуулалт хийгдэх, хүнд үйлдвэрт ашиглах химийн бодис, тэдгээрийн хог хаягдлыг байгаль орчны холбогдох хуулийн дагуу ашиглахаар тусгах тул хянах боломжтой.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэр байгуулахтай холбоотойгоор хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх боломжтой. Хүнд үйлдвэрт ашиглах химийн бодис, тэдгээрийг агуулсан хог хаягдлыг байгаль

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

				орчны холбогдох хуулийн дагуу хадгалах, тээвэрлэх, устгах болон бусад холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж хянах боломжтой.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хүнд үйлдвэр байгуулахтай холбоотойгоор үйлдвэрийн хэмжээнд хянах боломжтой хөрс эвдрэх, хөндөгдсөн газар нэмэгдэх боломжтой. Гэхдээ холбогдох хуулийн шаардлагыг баримтлахаар тусгана.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Шаардлагатай гэж үзвэл шинээр хүнд үйлдвэр барьж байгуулах асуудал үүсэж болно. Гэхдээ Газрын тухай болон БОНБУ-ний тухай хуулиар зохицуулагдана.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Шаардлагатай гэж үзвэл шинээр хүнд үйлдвэр барьж байгуулах асуудал үүсэж болно.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хамгаалалтын зориулалт өөрчлөхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Байгалийн орчны багц хуулиудын хүрээнд ашиглах боломжтой.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн	<u>Тийм</u>	Үгүй	Ашигт малтмал, газрын тосыг боловсруулах

ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	ашиглалт эсэх	нэмэгдэх		үйлдвэрлэл эрчимжинэ.
--	------------------	----------	--	--------------------------

ХАВСРАЛТ 1. ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЖАГСААЛТ

Хүнд үйлдвэрийн харилцаатай холбогдоххууль, тогтоомжийн жагсаалт

Байгаль орчны багц хууль
Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний
итгэмжлэлийн тухай
Өрсөлдөөний тухай
Патентын тухай
Технологи дамжуулах тухай
Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай
Чөлөөт бүсийн тухай
Шинжлэх ухаан, технологийн тухай

Хүнд үйлдвэрийн харилцаатай холбогдохсалбарын хууль, тогтоомж

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.7.”ашигт малтмал ашиглах” гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг;
9 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

9.1.Ашигт малтмалын асуудлаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.6.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах хамтарсан үйлдвэрт Монгол Улсаас оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

10 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

10.1.Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.11.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журмыг батлах;

/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

10.1.12.баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах;

10.1.14.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

11.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд “төрийн захиргааны байгууллага” гэх) дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.8.уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа техник, технологид үнэлэлт, дүгнэлт өгөх, техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэх;

11.1.9.уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, тухайн үед үүссэн нөхцөл байдалд үнэлэлт өгөх;

11.1.10.уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны эдийн засаг, нийгмийн салбарт үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах;

11.1.11.уул уурхайн бүтээгдэхүүний үнийг судлах, эрэлт, хэрэгцээ, хэтийн төлвийг тодорхойлох;

11.1.12.уул уурхайн үйлдвэрлэлийн тодорхой төслийг хэрэгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, хэрэгжүүлэх;

35 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг

35.11.Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлнэ.

42 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах

42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

45 дугаар зүйл. Уурхайг хаах үед тавигдах шаардлага

45.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол төрийн захиргааны төв байгууллагад нэгээс доошгүй жилийн өмнө мэдэгдэж, энэ хуулийн 10.1.14-д заасан журмын дагуу зохих бэлтгэлийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

**АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ АЛБАН
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ**

7 дугаар зүйл.Албан татвар ногдуулах

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн автобензин, дизелийн түлшинд ногдсон албан татварыг Үндэсний татварын алба, Монгол Улсын нутаг дэвсгэрт импортоор оруулж ирсэн автобензин, дизелийн түлшинд ногдох албан татварыг Гаалийн байгууллага энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хувь хэмжээгээр тус тус ногдуулна.

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

6 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

6.1. Дор дурдсан зориулалтаар ашигласан ус, рашаан тэдгээрийн орчинд төлбөр ногдуулна:

6.1.2. уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус;

15 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

15.1. Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг энэ хуулийн 10.1-д заасан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

Төлбөр ногдох ус	Төлбөрийн хязгаар / экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар/			
	Гадаргын усанд		Газрын доорх усанд	
	доод	дээд	доод	дээд
2. Хүнд үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	40	20	50

ул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд:				
а/ ашигт малтмал олборлох, баяжуулах	10	40	20	60
б/ зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах	10	50	20	70
в/ усыг шавхан зайлуулах	10	15	15	50

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ

7 дугаар зүйл. Байгаль орчны үнэлгээ

1. Байгаль орчны унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах зорилгоор байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийнэ.

10¹ дүгээр зүйл. Байгаль орчны аудит

1. Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ.

31 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэгтэй.

байна:

**4/ байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх;
БАРИЛГЫН ТУХАЙ/Шинэчилсэн найруулга/**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино

19 дүгээр зүйл. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл

19.1.Дараахь барилгын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ:

19.1.4.даацын хийц, бүтээц, эдлэхүүн, материал түүний түүхий эд болон шатамхай, химийн хортой, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

43 дугаар зүйл. Барилгын материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчийн чиг үүрэг

43.1.Барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараахь чиг үүрэгтэй:

43.1.1.Ашигт малтмалын тухай болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасан журмын дагуу барилгын материалын үйлдвэрлэлд хэрэглэх түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох, боловсруулах;

43.1.2.хууль тогтоомжид заасны дагуу орд газрын ашигласан талбайд нөхөн сэргээлт хийх;

43.1.3.үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүнийхээ чанарт баталгаа өгөх;

43.1.4.барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн лабораторийн сорилт туршилтад тогтмол хамруулан технологийн заавар батлуулах, тохирлын гэрчилгээ авах;

43.1.5.үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүнийхээ чанарын үндсэн үзүүлэлтийг тодорхойлох лабораторитой байх, хяналт тавих;

43.1.6.итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосны дагуу шинэ материал, хийц, бүтээц, эдлэхүүн, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, туршилтын журмаар хэрэглэх;

43.1.7.лабораторийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг баталгаажуулах.

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

/2013 оны 6 дугаар сарын 7-ны өдөр/

1 дүгээр зүйл.

Газрын тосны бүтээгдэхүүнийг газрын тос, занар болон нүүрснээс үйлдвэрлэлийн аргаар гарган авах төслийн хүрээнд импортоор оруулж

байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материалыг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫГ ХӨНГӨЛӨХ ТУХАЙ

/2019 оны 11 сарын 28 өдөр/

1 дүгээр зүйл.Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт барих газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барааны гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлсүгэй.

ГААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

/2012 оны 5 дугаар сарын 22-ны өдөр/

1 дүгээр зүйл.Инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг импортоор оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний борлуулалтын орлогыг нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хөнгөлөлтийг тухайн үйлдвэрлэл явуулах Инновацийн тухай хуульд заасан гарааны компани улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш гурван жилийн хугацаанд эдэлнэ.

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ТУХАЙ

38 дугаар зүйл. Гаалийн татвараас чөлөөлөгдөх бараа

38.1.Гаалийн нутаг дэвсгэрт оруулах дараахь барааг гаалийн татвараас чөлөөлнө:

38.1.14.инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодис.

38.1.18.сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг.

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах болон эдгээр үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд энэ хууль үйлчилнэ.

5 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаархи Засгийн газар болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

5.2. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын тосны бүтээгдэхүүний талаар дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.2.2. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болго

8 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх

8.1. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

8.2. Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн технологи, тоног төхөөрөмж олон улсын стандартад нийцсэн байна.

8.3. Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан бичиг баримт бүрдүүлнэ:

8.3.1. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн дүгнэлт;

8.3.2. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төсөл;

8.3.3. мэргэжлийн байгууллагаар боловсруулж, улсын экспертизийн хяналт хийлгэсэн газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл, газар эзэмших зөвшөөрөл;

8.3.4. газрын хөрсний геологийн дүгнэлт;

8.3.5. мэргэжлийн хяналтын байгууллагын ариун цэвэр, эрүүл ахуйн дүгнэлт;

8.3.6. галын аюулгүй байдлын дүгнэлт.

8.4. Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь үүрэг хүлээнэ:

8.4.1. үндэсний стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

8.4.2. газрын тосны бүтээгдэхүүний чанарын шинжилгээ, туршилт хийх итгэмжлэгдсэн лабораторитой байх;

8.4.3. үйлдвэрийн хаягдлыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хор нөлөө үзүүлэхээргүй орчинд хадгалах, зайлуулах, устгах нөхцөлийг бүрдүүлэх.

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

7.1.Засгийн газар газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.6.Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг эдлэх;

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

8 дугаар зүйл. Газрын төлбөрөөс чөлөөлөх

1. Дараахь төлбөр төлөгчийг дор дурдсан газрыг эзэмшиж, ашигласны төлбөрөөс чөлөөлнө:

9/үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийг үйлдвэрлэл технологийн паркийн зориулалтаар эзэмшүүлсэн газрын.

/Энэ заалтыг 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/

10/ алслагдсан суурин газар, орон нутагт өндөр технологийн үйлдвэрлэл явуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг газар эзэмшиж, ашигласны төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн таван жилд 50 хувиар.

/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/

12/чөлөөт бүсэд эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтэц болон үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, түүний салбарыг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний 10 жилд 100 хувиар.

3.Үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэрийн газарт хохирол учруулсан тохиолдолд гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн талаар холбогдох байгууллагаас дүгнэлт гаргасан нөхцөлд газрын төлбөрөөс чөлөөлнө.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

21 дүгээр зүйл.Тээврийн хэрэгсэл, түүний хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэх, угсрах, импортлоход тавих шаардлага

21.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцуулах зорилгоор тус улсад үйлдвэрлэсэн, угсарсан тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд шинжлэх ухааны холбогдох байгууллагын дүгнэлтээр баталгаажсан байна.

21.2.Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг,

нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан байна.

21.3.Гадаад улсад ашиглахыг хориглосон тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.

21.4.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангасныг гэрчлэх шинжлэх ухааны холбогдох байгууллага, эсхүл техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлтгүйгээр тухайн тээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглоно.

21.5.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийн хийцийг өөрчилсөн тохиолдолд техникийн хяналтын үзлэг, оношилгоог давтан хийлгэж гэрчилгээ авна.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

3.1.16.“нисэх” гэж агаарын хөлөг болон түүнд хамаарах бүтээгдэхүүнийг зохион бүтээх, үйлдвэрлэх, тэдгээрээр үйл ажиллагаа эрхлэх цогцолбор ойлголт;

3.1.19.“нисэхийн бичиг баримт” гэж энэ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын дагуу нисэхэд хамаарах үйл ажиллагаа (хуулийн этгээд, аэродром, агаарын хөлөг, түүнд хамаарах бүтээгдэхүүн болон тэдгээрийн үйлдвэрлэл, нисэхэд холбоотой бусад үйлчилгээ)-нд иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон гэрчилгээ, үнэмлэх, зөвшөөрөл болон бусад бичиг баримт;

ИННОВАЦИЙН ТУХАЙ

ИННОВАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨРИЙН ДЭМЖЛЭГ

13 дугаар зүйл.Инновацийн тэргүүлэх чиглэл

13.1.Шинжлэх ухаан, технологийн ололтыг эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, өндөр технологийн болон өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох, өндөр үр ашигтай үйлчилгээний төрөл, хэлбэрийг бий болгоход чиглүүлэх, инновацийн чадавх, нөөцийг оновчтой байршуулах, төрийн дэмжлэгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор инновацийн тэргүүлэх чиглэлийг тогтооно.

13.2.Инновацийн тэргүүлэх чиглэлийг стратегийн болон дунд хугацааных гэж ангилна.

13.3.Стратегийн тэргүүлэх чиглэл 10 жилийн хугацаатай байх бөгөөд Улсын Их Хурал батална.

13.4.Стратегийн тэргүүлэх чиглэлийн төслийг өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж өмнөх тэргүүлэх чиглэлийн хугацаа дуусахаас 12 сарын өмнө Засгийн газраар хэлэлцүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ

13 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

13.1.Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.11.цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хангах, хадгалах журмыг тогтоох;

14 дүгээр зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

14.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.7.батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх, зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

15 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний чиг үүрэг

15.3.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.3.14.цэргийн зориулалттай зэвсэг, сум, галт хэрэглэл үйлдвэрлэх бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах.

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ

20 дугаар зүйл. Улсын хил дээр ан агнуур, ажил, үйлдвэрлэл явуулах

20.1.Улсын хил дээр ан агнуур хийх, байгалийн баялаг ашиглах, мал аж ахуй эрхлэх, эрэл хайгуул хийх болон бусад үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаа явуулах журмыг хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу тогтооно.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ

5 дугаар зүйл. Хөгжлийн банкны эрх зүйн байдал

5.1.Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна.

НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

2. Нийслэлийн Засаг дарга нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрх эдлэхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3/ хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах ашиг сонирхолд нийцүүлэн хүрээлэн байгаа орчныг бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хэмжээг хэтрүүлэхүйц үйлдвэр, объектыг барьж байгуулах асуудалд холбогдох байгууллагын дүгнэлтийг үндэслэн хориг тавих, үйлдвэрлэл, үйл ажиллагааг нь түр түдгэлзүүлэх, нийслэлээс нүүлгэн шилжүүлэх тухай асуудлыг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ

10 дугаар зүйл. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

10.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.5. суурь бүтэц ашиглах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх болон суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

16 дугаар зүйл. Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл

16.1. Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ дараахь төрөлтэй байна:

16.1.2. суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах;

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.20. “Монгол Улсын гарал үүсэлтэй бараа” гэж Монгол Улсад олборлосон, ургуулсан, бойжуулсан, үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл хийж бүтээсэн бараа буюу эд ангиудын дийлэнхийг угсарч, түүний үндсэн шинж чанар, зориулалт, ашиглалтын хэлбэрээс илт өөр болгосон шинэ барааг;

10 дугаар зүйл. Тендерт оролцогчдод давуу эрх олгох

10.1. Захиалагч тендерийн үнэлгээ хийхдээ дараахь этгээдэд давуу эрх олгоно.

/Энэ заалтад 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

10.1.1. Монгол Улсын гарал үүсэлтэй болон хог хаягдал дахин боловсруулсан бараа нийлүүлэх тендер ирүүлсэн этгээд;

/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

10.1.2. 50-иас доошгүй хувийг нь бие даан гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх тендер ирүүлсэн дараахь этгээд:

10.1.2.а.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд;

10.1.2.б.Монгол Улсад бүртгэлтэй, өмчийнх нь 50-иас доошгүй хувь нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хувь хөрөнгөөс бүрдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд;

10.1.3.орон нутагт үйлдвэрлэсэн бараа, материал, үзүүлж байгаа үйлчилгээг хамгийн ихээр ашигласан;

10.1.4.орон нутгаас хамгийн их ажиллах хүч авсан.

10.1.5.хуулийн этгээдийн ажиллах хүчний 90-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ

17 дугаар зүйл.Санхүүгийн хуримтлал, түүний хөрөнгө оруулалт

17.1.Энэ хуулийн 16.2-т заасан Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 10 хувиас давсан санхүүгийн хуримтлалын хөрөнгөөр дотоод болон гадаад зах зээлд хийх хөрөнгө оруулалтын оновчтой хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгч, эдийн засгийн хөгжлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр жил бүр тогтооно.

7.3.Засгийн газар дотоод зах зээлд хийх хөрөнгө оруулалтын энэ хуулийн 17.1-д заасны дагуу тогтоосон хэмжээнд багтааж төрийн өмчит хөгжлийн банкны буцаан худалдан авах нөхцөлтэй гаргасан урт хугацаат үнэт цаасыг хууль тогтоомжийн дагуу худалдан авна.

17.4.Төрийн өмчит хөгжлийн банк энэ хуулийн 17.3-т заасан үнэт цаасыг борлуулж, татан төвлөрүүлсэн санхүүгийн хуримтлалын эх үүсвэрээр зөвхөн хөгжлийн хөрөнгө оруулалтын дараахь төсөл, арга хэмжээг дунд, урт хугацааны зээлээр санхүүжүүлж болно:

17.4.1.төмөр замын сүлжээ, газрын тос боловсруулах үйлдвэр, эрчим хүчний цахилгаан станц барьж байгуулах;

17.4.2.олон улсын болон Европын холбооны стандартын шаардлага хангасан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх.

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.3.“түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах” гэж түгээмэл тархацтай ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу газрын гадаргуу, хэвлийгээс ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг;

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

9 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэхэд тавих үндсэн шаардлага

9.1.Энэ хуулийн 5.1-д заасны дагуу химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, үйлдвэрлэх, ашиглах зөвшөөрөл авахдаа тухайн бодисын талаар дараахь мэдээллийг бүрдүүлнэ :

9.1.1. бодисын нэр, томъёо;

9.1.2. худалдааны болон техникийн нэр;

9.1.3. олон улсын бүртгэлийн дугаар;

9.1.4. ашиглах газар, зориулалт, хугацаа, тоо хэмжээ;

9.1.5. физик, химийн болон хор аюулын шинж чанар;

9.1.6. болзошгүй осол, эрсдлийн үед авах арга хэмжээ;

9.1.7. үйл ажиллагаа явуулах ажлын байрны дүгнэлт;

9.1.8. тухайн бодис, түүний хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх арга.

9.2.Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэхдээ энэ хуулийн 6.1.1-д заасны дагуу батлагдсан журмыг мөрдөнө.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ

11 дүгээр зүйл.Татварын хөрөнгө оруулалтын дэмжлэг

11.1.Хөрөнгө оруулагчид дараах хэлбэрээр татварын дэмжлэг үзүүлнэ:

11.2.Доор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:

11.2.1.барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;

11.2.2.нано, био болон инновацийн технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих;

11.2.3.эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих.

12 дугаар зүйл.Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг

12.1.Хөрөнгө оруулагчид татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг дараах хэлбэрээр үзүүлж болно:

12.1.1.газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах;

12.1.2.чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсөн горимоор үйлчлэх;

12.1.3.дэд бүтэц, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, боловсролын салбарын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох;

12.1.4.инновацийн төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжилтэд батлан даалт гаргах;

12.1.5.Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд Монгол Улсад зорчих олон удаагийн орж гарах виз болон байнга оршин суух зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох;

12.1.6.хуульд заасан бусад дэмжлэг.

12.2.Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

16 дугаар зүйл.Тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуур, хугацаа

16.2.Тогтворжуулах гэрчилгээг доор дурдсан салбарт дараах хугацаагаар олгоно:

16.2.1.уул уурхайн олборлолт, хүнд үйлдвэр, дэд бүтцийн салбарт:

Хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөгөөр/	Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа /жилээр/					Хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа /жилээр/
	Улаанбаатарын бүс	Төвийн бүс /Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Төв/	Хангайн бүс /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/	Зүүн бүс /Дорнод, Сүхбаатар, Хэнтий/	Баруун бүс /Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд/	
30-100 хүртэл	5	6	6	7	8	2
100-300 хүртэл	8	9	9	10	11	3

300-500 хүртэл	10	11	11	12	13	4
500-аас дээш	15	16	16	17	18	5

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ

3.1.6. “цөмийн төхөөрөмж” гэж цөмийн түлш бэлтгэх үйлдвэр, цөмийн болон судалгааны реактор, цөмийн эрчим хүчний эх үүсвэр, цөмийн түлш болон ашигласан түлш хадгалах байгууламж, баяжуулах үйлдвэр, ашигласан түлшийг дахин боловсруулах үйлдвэрийг;

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

15.1. Дараах үйл ажиллагааг Цөмийн энергийн комиссоос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:

15.1.1. цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах;

15.1.2. цөмийн төхөөрөмж ашиглах;

15.3. Дараах үйл ажиллагааг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:

15.3.2. цацрагийн үүсгүүрийг угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах;

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүний болон мал эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур /цаашид “эм” гэх/, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

12 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлага

12.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд дараахь үндсэн шаардлагыг хангасан байна:

12.1.1. улсын болон олон улсын стандартын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх технологитой байх;

12.1.2. эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалах, үйлдвэрлэл явуулах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

12.1.3. эмийн түүхий эдийг эмийн бүртгэлд бүртгүүлсэн байх;

12.1.4. тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эхлэхээс өмнө эмийн түүхий эд, эмийн туслах бодисыг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулах;

12.1.5. үйлдвэрлэлийн дамжлагыг технологийн дагуу удирдан хөтлөх, хянах мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх;

12.1.6.үйлдвэрлэлийн явцын болон эцсийн бүтээгдэхүүний чанарын хяналтыг зохион байгуулах, чанарын баталгааг цуврал бүрт гаргах нөхцөлийг хангасан байх;

12.1.7.үйлдвэрлэсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, түүний сав, баглаа боодол, шошго нь стандартын шаардлага хангасан байх.

12.2.Эмийн үйлдвэр өөрийн бүтээгдэхүүний чанарыг хариуцна.

12.3.Эмийн үйлдвэрт стандартын шаардлагыг хангасан тухай батламжийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

12.4.Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд дараахь зүйлийг хориглоно:

12.4.1.мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийг тусгай зөвшөөрөлгүй үйлдвэрлэх;

12.4.2.хүний эмийг мал, амьтны эмтэй нэг шугам, дамжлага дээр үйлдвэрлэх;

12.4.3.чанарын баталгаагүй түүхий эд, материалаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх.

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ

6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

6.1.Төрийн захиргааны төв байгууллага эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.2.эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулах чиглэлээр бараа бүтээгдэхүүн, материал, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон эрчим хүч хэрэглэх машин, тоног төхөөрөмж, барилга байгууламж, ажил, үйлчилгээнд мөрдөх норм батлах, стандарт батлуулах;

ХАВСРАЛТ 2. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Аливаа улсын эдийн засгийн бүтцийг хөдөө аж ахуй-уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээ гэсэн гурван үндсэн салбарт хуваан үздэг бөгөөд салбар бүр цааш дэд салбаруудад хуваагдаг байна.

Эдийн засгийн аль салбарт тулгуурлан хөгжиж байна вэ? гэдгээс хамааран тухайн улсыг хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан орон гэж үздэг. Өөрөөр хэлбэл, дээрх салбаруудын эдийн засагт эзлэх хувийн жин тухайн улсын хөгжлийн шатлалыг илэрхийлдэг байна.

Эдийн засгийн бүтцийн дээрх ерөнхий ангиллаас гадна олон улсад нийтлэг ашигладаг хөдөлмөрийн хуваарийн дагуу нарийвчлан хуваасан ангилал байдаг. 1948 онд НҮБ-ын статистикийн хороо “эдийн засгийн бүх үйл ажиллагааны олон улсын стандарчлагдсан аж үйлдвэрийн ангилал” (International Standard Industrial Classification of All Economic Activities, ISIC)¹²-ыг гаргаж эхэлсэн.

Энэ үеэс хойш хөгжилтэй орнууд ISIC-н хүрээнд өөрийн орны Стандарчлагдсан Аж үйлдвэрийн ангиллыг тогтоож, аж үйлдвэрийн оновчтой бодлого тодорхойлох, аж үйлдвэрийн бүтэц, шатлал, төрөл, давхаргажилтын байдалд судалгаа хийх, статистикийн мэдээллийн сан бий болгож иржээ.

Энэхүү ангиллыг Монгол Улс 2011 онд ашиглаж эхэлсэн бөгөөд 2018 онд шинэ ангиллыг баталсан ашиглаж байна. Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗБТУААСА)¹³ нь Монгол Улсын эдийн засгийг 21 салбар, 88 дэд, 238 бүлэг, 420 анги, 96 дэд ангид хуваасан байна.

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, салбараар:

A - Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур

B - Уул уурхай, олборлолт

C - Боловсруулах үйлдвэрлэл

D - Цахилгаан, хий, уур, агааржуулалт

E - Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа

F - Барилга

G - Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ

H - Тээвэр, агуулахын үйл ажиллагаа

I - Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ

J - Мэдээлэл, холбоо

K - Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа

L - Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа

M - Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа

N - Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа

O - Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал

P - Боловсрол

¹² https://unstats.un.org/unsd/publication/seriesM/seriesm_4rev4e.pdf

¹³ Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319 / А/160 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Q - Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа

R - Урлаг, үзвэр, тоглоом наадам

S - Үйлчилгээний бусад үйл ажиллагаа

T - Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ

U - Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа

“ЭЗБТҮАСА” ангилалд “хүнд үйлдвэр”-ийг тусгайлан ангилаагүй бөгөөд аж үйлдвэрийн салбарыг хэд хэдэн тусдаа салбар, дэд ангиудад хөдөлмөрийн хуваарийн дагуу төрөлжүүлсэн хуваасан байдаг.

Аж үйлдвэрийн салбарыг хүнд-хөнгөн үйлдвэр гэж ангилах үзэл нь XIX-XX зуунд дэлгэрсэн “Стандарт хөгжлийн загвар” болон “Эрчимт хөгжлийн загвар буюу Хүчтэй түлхэх загвар” (Big Push Model)-ын үзэл баримтлалд анх тусгагдсан байдаг. Түүх сөхвөл, XVIII зуунд Англи улсад өрнөсөн аж үйлдвэрийн хувьсгалаас хоцорсон европын бусад улсууд хүнд үйлдвэрийн салбарыг онцгой анхаарч хөгжүүлснээр хөдөө аж ахуйн орноос аж үйлдвэр давамгайлсан эдийн засагтай орон болсон ажээ.

Хүнд үйлдвэрийн хөгжил нь буцаад хөнгөн болон хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх технологийн дэвшил дагуулдаг учир төрөөс тухайн салбарыг бодлогоор дэмжих үзэл санаа өргөн дэлгэрсэн байдаг.

XX зуунд дэлхийн улс орнууд чөлөөт зах зээлийн эдийн засагтай барууны, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай социалист, төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засагтай орнууд гэсэн гурван улс төр-эдийн засгийн үзэл баримтлалын дагуу хөгжин иржээ. ЗХУ тэргүүтэй социалист орнууд болон Баруун Германы хөгжлийн загварыг дагасан төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засаг бүхий орнууд аж үйлдвэрийн салбарыг хүнд болон хөнгөн гэсэн ангилалд хуваан тав таван жилээр хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө хэрэгжүүлсэн байдаг. Эдгээр орнуудын хүнд үйлдвэрт тооцох шалгуур тодорхойлолт нь нийтлэг шинжтэй бөгөөд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-тай харилцан уялдсан байдаг.

Төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засаг бүхий орнууд экспортыг дэмжих зорилгоор машин байгууламж, хар болон өнгөт төмөрлөг, нефть-химийн үйлдвэрлэл, усан онгоц, машин үйлдвэрлэл, электроникийн салбараас өөрийн орны хөгжлийн бодлогод нийцүүлэн, стратегийн чиглэлээр сонгож, хүнд үйлдвэрийг хөгжүүлж ирсэн түүхтэй.

Эндээс үзэхэд хүнд үйлдвэр гэсэн ойлголт нь “нийгэм-эдийн засаг, улс төр”-ийн ойлголт бөгөөд дараах хүчин зүйлсийг үндэслэн хүнд үйлдвэрийн ангиллыг тогтоодог байна. Үүнд:

Аж үйлдвэрийн салбар	Хүнд үйлдвэр	Хөнгөн үйлдвэр
Үндсэн зориулалт	Бусад үйлдвэрт ашиглах, хэрэглэх завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу шууд бус замаар эдийн засгийн эрэлт хэрэгцээ хангахад оршино	Хэрэглэгчдэд зориулсан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу шууд хэрэгцээг хангахад чиглэгдэнэ.

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2.Байрлал	Түүхий эд, дэд бүтцэд ойр байх зэрэгцээ суурьшлын бүсээс тусгаар байх шаардлагатай	Үйлдвэрийн байршилд тодорхой шаардлага тавигдахгүй.
Түүхий материал эд,	Боловсруулаагүй, тоо ширхэг, овор хэмжээ их.	Боловсруулсан болон хагас боловсруулсан, овор хэмжээ бага.
Дэд бүтэц	Эрчим хүч, ус, зам тээвэр, харилцаа холбооны тусгай дэд бүтэц шаардана.	Тусгай дэд бүтэц шаардлагагүй, нийтийн зориулалттай дэд бүтэц ашиглах боломжтой.
Газар ашиглалт	Тусгай үйлдвэрийн бүс шаардлагатай.	Тусгайлсан бүс шаардлагагүй.
Хөрөнгө оруулалт	Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана.	Хөрөнгө оруулалт харьцангуй бага.
Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл	Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл бага биш.	Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл бага.

Аж үйлдвэрийн салбарт бодлогоор зарим үйлдвэрийн салбарыг дэмжиж өсгөх, эсхүл хамгаалах бодлогыг хэрэгжүүлснээр аж үйлдвэрийн бүтцэд өөрчлөлт ордог. Хүнд үйлдвэрийн хөгжлийн түүхээс ажиглахад Аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлт нь эдийн засгийн өсөлтийн мөчлөгтэй маш нарийн уялдаатай байдаг. Өнөөгийн хөгжилтэй орнуудад эдийн засгийн өндөр өсөлтийг ХАА үйлдвэрээс хүнд үйлдвэрт чиглэсэн бүтцийн өөрчлөлтийг хийж чадсанаар бий болгосон.

Өнөөгийн төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засаг бүхий орнуудын эгнээнд БНГУ, Япон, БНСУ, Тайвань, Сингапур, БНХАУ зэрэг хүнд үйлдвэр өндөр хөгжсөн орнууд багтдаг бөгөөд эдгээр орнуудын аж үйлдвэрийн салбарын зарим ангилалтай танилцъя.

Тухайлбал, БНХАУ–ын аж үйлдвэрийн салбар нь үндсэн 4, дэд 36-н салбарт хуваагдаг байна.

Аж үйлдвэрийн ангилал	Үйлдвэрийн код, нэр
Уул уурхайн Үйлдвэрлэл	(1)Нүүрсний уурхай, нүүрс угаах; (2)Газрын тос, хий олборлох; (3)Хар төмрийн уурхай; (4)Өнгөт төмрийн уурхай; (5)Металл биш уурхай;
Хөнгөн үйлдвэр	(6)Хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах; (7)Хүнсний бүтээгдэхүүн боловсруулах; (8)Согтууруулах ундааны үйлдвэрлэл; (9)Тамхины үйлдвэрлэл; (10)Нэхмэл, сүлжмэлийн үйлдвэрлэл; (11)Хувцас үйлдвэрлэл; (12)Савхи, Үслэг, Өдний үйлдвэрлэл; (13)Мод боловсруулах үйлдвэрлэл; (14)Тавилга үйлдвэрлэл; (15)Цаасны үйлдвэрлэл; (16)Дарах, хэвлэх үйлдвэрлэл; (17)Соёл, боловсрол, спортын бараа үйлдвэрлэл;

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хүнд үйлдвэр	18)Газрын тос боловсруулах, кокс боловсруулах, цөмийн түлш боловсруулах; (19)Химийн үйлдвэрлэл; (20)Эм үйлдвэрлэл; (21)Нейлон материал боловсруулах; (22)Резин материал боловсруулах; (23)Хуванцар боловсруулах; (24)Металл биш үйлдвэрлэл; (25)Хар төмөрлөг боловсруулах; (26)Өнгөт төмөрлөг боловсруулах; (27)Төмөрлөгийн үйлдвэрлэл; (28)Машин байгууламжийн үйлдвэрлэл, (29)Тусгай тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл; (30)Тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэл; (31)Цахилгаан машин үйлдвэрлэл; (32)Компьютер, холбооны хэрэгсэл, бусад электрон төхөөрөмжийн үйлдвэрлэл; (33)Албан болон соёл урлагийн зориулалт бүхий механизм болон зэмсэг үйлдвэрлэл;
Цахилгаан эрчим хүч, байгалийн хий, усны үйлдвэрлэл	(34)Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, түгээлт; (35)Байгалийн хий түгээлт; (36)Ус олборлох, түгээх;

БНСУ-ын аж үйлдвэрийн салбар нь НҮБ-ын статистикийн хорооны “эдийн засгийн бүх үйл ажиллагааны олон улсын стандарчлагдсан аж үйлдвэрийн ангилал”-ыг загвар болгодог. Гэхдээ хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор аж үйлдвэрийн салбараа хөнгөн болон хүнд үйлдвэр тусдаа авч үздэг байна.

**ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

БНХАУ-ын тухайд хуулиар хүнд үйлдвэрийг тодорхойлоогүй боловч статистикийн мэдээллийн үүднээс дараах байдлаар тодорхойлдог.¹⁴ Хүнд үйлдвэрлэл гэдэг нь үндэсний эдийн засгийн янз бүрийн салбаруудыг шаардлагатай материал, техникийн баазаар хангадаг, завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг салбарыг хэлнэ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах зориулалтаар нь дараах гурван салбарт ангилна.

Үйлдвэрийн салбар	Технологийн Түвшин		Үйлдвэрийн салбар
ХӨНГӨН ҮЙЛДВЭР	Нам Технологи	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Хүнс
			Согтууруулах ундаа
			Нэхмэл сүлжмэл
			Бэлэн хувцас, үслэг эдлэл
			Арьс боловсруулах, гутал, цүнх
			Мод боловсруулах
			Цаасны үйлдвэр
			Хэвлэх үйлдвэр
			Тавилга үйлдвэр
			Бусад үйлдвэрлэл
ХҮНД ҮЙЛДВЭР	Дунджаас Доош	Завсрын бүтээгдэхүүн Үйлдвэрлэл	Газрын тос боловсруулах
			Резин болон хуванцар боловсруулах
			Металл биш ашигт малтмал боловсруулах
			Үндсэн металл боловсруулах
			Металл хийц
			Тээврийн хэрэгслийн сэлбэг
	Дунджаас дээш	Тусгай үйлдвэрт зориулсан	Цахилгаан тоног төхөөрөмж
		Завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Машин байгууламж
			Химийн үйлдвэрлэл
			Эмийн үйлдвэрлэл
			Моторт тээврийн хэрэгсэл, чиргүүл
			Тээврийн хэрэгслийн сэлбэг
	Өндөр технологи	Шинжлэх ухаан-инновацид тулгуурласан үйлдвэрлэл	Оптикийн төхөөрөмж, багаж
			Электроникийн эд анги, компьютер, радио, телевиз, холбооны хэрэгсэл болон аппарат

(1) Уул уурхай, олборлох үйлдвэрлэлд байгалийн баялаг, түүний дотор газрын тос, нүүрс, металл ба металл бус хүдэр олборлох үйлдвэрлэлийг хамаарна.

(2) Түүхий эдийн үйлдвэрлэлд үндэсний эдийн засгийн янз бүрийн салбаруудыг түүхий эд, түлш, эрчим хүчээр хангадаг салбарыг хэлнэ. Үүнд металл хайлуулах, боловсруулах, коксжих болон кокс хими, химийн материал, цемент, фанер, зэрэг барилгын материал, нефть боловсруулах, эрчим хүч үйлдвэрлэх, нүүрс баяжуулах зэрэг орно.

¹⁴ <http://www.stats.gov.cn/tjsj/ndSj/yb2004-c/html/14ie.htm>

(3) Үйлдвэрлэлийн салбар гэдэг нь түүхий эд боловсруулдаг салбарыг хэлнэ. Үүнд үндэсний эдийн засгийн салбарыг хангах машин үйлдвэрлэл, металл хийц болон цементийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт зориулсан химийн бордоо, пестицид гэх мэт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг аж үйлдвэрийн салбарууд орно. Дээрх ангиллын зарчмын дагуу хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний засварын хэрэгслийг хүнд үйлдвэрийн ангилалд, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний засварын хэрэгслийг хөнгөн үйлдвэрийн ангилалд ангилдаг.

Хүнд үйлдвэрлэл гэдэг нь явцуу утгаар тодорхойлбол эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглах “завсрын бүтээгдэхүүн” болон “тоног төхөөрөмж”-ийн үйлдвэрлэлийг хэлнэ .

Хүнд үйлдвэр гэдэг нь өргөн утгаар авч үзвэл “үйлдвэрийн хэрэгсэл”-ийг бүтээх эдийн засгийн харилцаа юм.

“Үйлдвэрийн хэрэгсэл” гэж хүмүүсээс материал баялгийг бүтээхэд үйлдвэрлэлд хэрэглэсэн “хөдөлмөрийн хэрэгсэл”, “хөдөлмөрийн зүйлс”-ийн цогцос.

Хөдөлмөрийн зүйлс гэдэг нь эцсийн шатны үйлдвэрийн хэрэгцээг хангах зорилгоор үйлдвэрлэлд боловсруулагдах нүүрс, хүдэр, нефть, байгалийн хий гэх мэт түүхий эд, байгалийн нөөцийг хэлнэ.(завсрын бүтээгдэхүүн)

Хөдөлмөрийн хэрэгсэл гэдэг нь материал баялгийг бүтээх зорилгоор хөдөлмөрийн зүйлстэй ажиллахад хүмүүсээс хэрэглэж байгаа зүйлс буюу машин, суурь машин, багаж хэрэгсэл, хөдөлгүүр, янз бүрийн төхөөрөмж, үйлдвэрийн барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, холбооны хэрэгсэл зэргийг хэлнэ.(тоног төхөөрөмж гм)¹⁵

Товч тодорхойлоход хүнд үйлдвэрийн салбар гэдэг нь хөдөө аж ахуй, уул уурхай, хөнгөн үйлдвэр, үйлчилгээ зэрэг бусад салбарт ашиглах завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу шууд бус замаар эдийн засгийн эрэлт хэрэгцээ хангах зорилготой, боловсруулах түүхий эд, ашиглах дэд бүтцэдээ ойр, суурьшлын бүсээс алс орших, томоохон хөрөнгө оруулалт, эрчим хүч, ус, зам тээвэр, харилцаа холбооны тусгай дэд бүтэц шаарддаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл бага биш үйлдвэрийн салбар гэж тодорхойлж болно.

¹⁵ Улс төр, эдийн засгийн ухааны тайлбар толь-Улаанбаатар 1977 он, 291 дэх тал.

Ашигласан материал:

1. Industrial Development in East Asia.2009. by K. Ali Akkemik
2. Industrial upgrading of Korea. Cheonsik Woo. 2000 . KDI
3. <https://mrpam.gov.mn/article/90/>
4. <https://www.legalinfo.mn/law/details/11226>
5. <https://www.meti.go.jp/english/information/data/laws.html>
6. <https://www.moleg.go.kr/index.es?sid=a3>
7. https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=49335&type=new&key=
8. https://www.law.go.kr/LSW//lsInfoP.do?efYd=19640416&lsiSeq=37278&urlMode=lsInfoP&ancYnChk=&chrClsCd=010202&fbclid=IwAR35S5WrYpH9qlcdLSenmWLhmbnBYspDvjOI382jJKsOkvGzIRwO_ILukPk#0000
9. <http://laws.66law.cn/law-81356.aspx>
10. <http://laws.66law.cn/law-130329.aspx>
11. https://unstats.un.org/unsd/publication/seriesM/seriesm_4rev4e.pdf
12. Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319 / А/160 тоот тушаалын нэгдүгээр хавсралт
13. <http://www.stats.gov.cn/tjsj/ndSj/yb2004-c/html/14ie.htm>
14. Улс төр, эдийн засгийн ухааны тайлбар толь-Улаанбаатар 1977 он, 291 дэх тал.